



Хууль зүй, дотоод  
хэргийн яам



“Шүүх, эрх зүйн  
шинэчлэлт” төсөл

# ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ

## Гарын авлага

Зөвлөх: Ц. Алтанцэцэг (дэд.проф)

Боловсруулсан: А. Дугармаа (LLM)

*Энэхүү гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас  
хэрэгжүүлж буй Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт”  
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар 2007

DDC

## **Гэр бүлийн эрх зүй**

*Гарын авлага*

### **Хөтөлбөр боловсруулсан:**

Ц.Алтанцэцэг

А.Дугармаа

Т.Булган

### **Гарын авлага боловсруулсан:**

*Зөвлөх:* Ц. Алтанцэцэг (дэд.проф)

*Багийн гишүүд:* Ц.Алтанцэцэг (Отгонтэнгэр ИС-ийн ХЗС-ийн захирал, дэд.проф)

А.Дугармаа (МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш. LLM)

Хэвлэлийн хуудас: 14.6

Цаасны хэмжээ: B5

Хэвлэсэн тоо: 1200

Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани

**ISBN: 978-99929-56-28-3**



## “ШҮҮХ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ” ТӨСЛИЙН ТУХАЙ

### Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудад



*“Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн зохицуулагч*  
**Д.ОЮУНЧИМЭГ**

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл 2002 оноос хэрэгжээд дуусах шатандаа орж байна.

Энэ төслийн хүрээнд эрх зүйн дээд боловсролыг чанаржуулах чиглэлээр эхний шатны зарим ажлыг хийж дуусгалаа. Эдгээр ажлын үр дүн нь таны гар дээр очиж буй энэ гарын авлага юм. Бид энэ ажлыг зохион байгуулахдаа гадаадын зөвлөх гэхээсээ монголчууд бидний оюун ухаанд тулгуурлаж, дотоодын эрдэмтэн, багш нараар хийлгэсэн юм. Энэ номыг бүтээхэд хууль зүйн сургуулиудаас нэр хүндтэй, туршлагатай ахмад багш, нөгөө талаар идэвхтэй, санаачлагатай, хийж хамтран ажиллаж, бие биенээсээ харилцан суралцаж, цаашид судалгаа шинжилгээний ажил, эрх зүйн сургалтын шинэчлэлтийг хамтран хийхэд үр дүнд хүрнэ гэдгийг харуулсан болно.

Оюутанд зориулсан цогц гарын авлага (хичээлийн хөтөлбөр, тойм лекц) нь Монголд анх удаагаа гарч байгаа билээ. Оюутны гарын авлага нь тэдний судалж буй хичээлд хандах хандлагыг өөрчилж, “бэлэнчлэх” сэтгэлгээнээс ангижруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Төсөл бол тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг жамтай. Харин төсөл хэрэгжүүлэх явцад танилцсан, хамтарч ажилласан багш нар цаашдаа өөрсдийгөө боловсруулах, сургалтынхаа арга барил, чанарыг сайжруулах чиглэлээр хийж эхэлсэн ажлаа үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна. Хичээлийн хөтөлбөр, оюутны гарын авлага бүтээхэд оролцсон 100 орчим эрдэмтэн, багш нар болон энэ ажлыг гардан зохион байгуулж, уялдаа холбоог нь хангах талаар идэвх зүтгэлтэй ажилласан төслийн ажилтан Б.Сарантуяад талархал илэрхийлье.

### Үр дүнд чиглэсэн сургалтын хөтөлбөр



*“Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн зөвлөх*  
**У.ТУЯА**

Оюутан залуус та бүхэнд их мэдлэгийг хуримтлуулах нь чухал уу, харин уг мэдлэгээ ашиглах чадвар, мэргэжлийн үнэт зүйлсийг эзэмших нь чухал уу. Аль замыг чухал гэж сонгосноос таны суралцах арга барил, цаашлаад сургалтад хандах хандлага тань тодорхойлогддог байна. Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулахад ч энэ хоёр талаас авч үзэх хэрэгтэй болдог.

Бид 2003 оноос Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг сайжруулах” дэд төслийн хүрээнд энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулахдаа дараах шаардлагыг харгалзсан бөгөөд оюутан таныг ч энэ тухай мэдэж сургалтын хөтөлбөр, гарын авлагаа ашиглахыг зөвлөж байна. Үүнд:

- ❖ Оюутан ямар зорилгоор уг хичээлийг судалж, ямар үр дүнд хүрэхээ мэдэж байх ёстой.
- ❖ Мэргэжлийн мэдлэг нь мэргэжлийн ур чадвар болон хөгжиж, үнэт зүйл болон төлөвшсөн байх нь чухал. Иймээс мэдээлэл болгоныг боловсруулах бие даалтын ажил оюутанд хэрэгтэй.

## Гарын авлага боловсруулсан багийн гишүүд



**Цэрэнжавын Алтанцэцэг**

*Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, дэд профессор, МӨХ-ын гишүүн, Өмгөөлөгч, ДБМИҮЗ шинжээч Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн холбооны гишүүн, хяналтын зөвлөлийн дарга*

Иргэн, гэр бүлийн эрх зүйн болон хүүхэд хамгаалал, татвар, гаалийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн.

- |   |         |
|---|---------|
| 1. "Гэр бүлийн эрх зүй", редактор                         | 1995 он |
| 2. "Эрх зүйн гарын авлага", хамтын бүтээл                 | 2000 он |
| 3. "Иргэн бизнесийн эрх зүйн гарын авлага", хамтын бүтээл | 2006 он |
| 4. "Гэр бүлийн эрх зүй"                                   | 2007 он |
| 5. "Хуульчийн ур чадвар" хичээлийн хөтөлбөр, зөвлөх       | 2007 он |
| 6. "Хуульчийн ур чадвар" хичээлийн гарын авлага, зөвлөх   | 2007 он |



**Авирмэдийн Дугармаа**

*МУИС ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхмийн ахлах багш, Магистр, МУИС-ийн докторант*

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" Ерөнхий анги. УБ, 1999 он. Хамтын бүтээл

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" Тусгай анги. УБ, 2001 он. Хамтын бүтээл

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" Ерөнхий анги. УБ, 2004 он. Хамтын бүтээл

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" Тусгай анги УБ, 2006 он Хамтын бүтээл.

А.Дугармаа "Гэр бүлийн эрх зүй" УБ, 2005 он

А.Дугармаа Тэр бүлийн эрх зүйн бодлого, төстийн хураамж" 2007 он

"Иргэдийн эрх зүйн хөтөч" УБ, 2007 он Хамтын бүтээл/ Нээлттэй нийгэм хүрээлэнгийн санхүүжилтээр хэвлэгдсэн/

"Эрх зүйн хөтөч" /Арга зүй/ УБ, 2007 он Хамтын бүтээл/ Нээлттэй нийгэм хүрээлэнгийн санхүүжилтээр хэвлэгдсэн/

*"Монголын төр эрх зүй", "Хууль дээдлэх ёс", "Эрх зүй" сэтгүүлд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, гэр бүлийн эрх зүйн чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл, материал нийтлүүлсэн ба онол, практикийн эрдэм шинжилгээний хуралд энэ чиглэлээр хэд хэдэн илтгэл тавьж хэлэлцүүлсэн.*



## ӨМНӨХ ҮГ

Дэлхийн банкны "Шүүх, эрх зүйн шинэчлэлт" төслийн "Эрх зүйн бакалаврын боловсролыг сайжруулах" дэд төслийн хүрээнд "Эрх зүйн бакалаврын боловсролын Монгол Улсын стандарт" болон мэргэжлийн суурь хичээлийн жишиг хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлсэн.

Хууль зүйн их, дээд сургуульд судлах мэргэжлийн суурь хичээл болох Гэр бүлийн эрх зүйн хичээлийн гарын авлагыг энэхүү шинэчлэн боловсруулсан жишиг хөтөлбөрийн хүрээнд боловсруулан бэлтгэлээ.

Та бүхэнд толилуулан буй энэхүү гарын авлага нь Гэр бүлийн эрх зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулгад багтсан үндсэн асуудлуудын хүрээг хамарч, оюутнуудад "мэдлэг + чадвар + хандлага"-ыг цогц эзэмшүүлэх үр дүнд чиглэсэн сургалтын зорилгыг агуулсан юм. Энэ үүднээс гэр бүлийн эрх зүйн асуудлыг бүлэг, сэдэв, дэд сэдвээр системчлэн авч үзэж, сэдэв бүрийн хүрээнд:

- Нэр томъёоны тайлбар
- Агуулга
- Бататгах хэсэг/хяналтын асуулт, сорил, бодлого, даалгавар, дасгал/

Эх сурвалж гэсэн үндсэн 4 хэсэгт багтааж, тухайн бүлэг, сэдвийн агуулгыг тоймлон бичсэн болно. Оюутнууд та бүхэн сэдвийн зорилго, агуулгатай танилцаж энэхүү сэдвийн хүрээнд ямар мэдээг, чадвар, эзэмших ёстой болохыг юуны өмнө авч үзэж судалсны үндсэн дээр нэр томъёоны тайлбар, сэдвийн агуулгыг судлах шаардлагатай.

Үүний дараа мэдлэгээ бататгах хэсгийн хүрээнд өгөгдсөн хяналтын асуулт, сорил, даалгавар болон бодлого, дасгалыг бие даан гүйцэтгэнэ.

Бататгах хэсгийн хүрээнд өгөгдсөн бие даалтын ажлууд нь гэр бүлийн харилцаанд үүсэж болох нөхцөл байдлыг танин мэдэх, холбогдох эх сурвалжуудыг судалж эрх зүйн маргаантай асуудалд дүн шинжилгээ хийх, эрх зүйн хэм хэмжээг бүтээлчээр хэрэглэх, өөрийн байр сууриа илэрхийлэх, харилцан ярилцах, баримт бичиг боловсруулах болон практик амьдралд үүссэн асуудалд хууль зүйн үүднээс хандаж шийдвэрлэх чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн үр дүнд суурилсан сургалтаар оюутныг чадваржуулж, хөгжүүлэх зорилгоор боловсруулсан гэдгийг та бүхэн анхаарна уу.

*Ц. Алтанцэцэг*

ГАРЧИГ

НЭГ. "ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ"  
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Гэр бүлийн эрх зүй хичээлийн танилцуулга	7
Гэр бүлийн эрх зүй хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг хуваарилалт	9
Гэр бүлийн эрх зүй хичээлийн заах арга зүй	
Гэр бүлийн эрх зүй хичээлийн үнэлгээ	

ХОЁР. ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

<b>1 бүлэг.</b> Гэр бүлийн эрх зүйн ойлголт	11
Гэр бүлийн эрх зүйн ойлголт, зохицуулах зүйл, зохицуулалтын арга	11
Гэр бүлийн эрх зүйн харилцааны тухай ойлголт, ангилал, элемент	17
Гэр бүлийн эрх зүйн эх сурвалжийг тодорхойлох	26
<b>2 бүлэг.</b> Гэр бүлийн эрх зүйн хамгаалалт	31
Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдээс эрхээ хэрэгжүүлэх нь	31
Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын ойлголт, арга, хэлбэр	36
Шүүхийн бус хамгаалалт	41
<b>3 бүлэг.</b> Гэрлэлт, түүний хууль зүйн үр дагавар	46
Гэрлэлтийн ойлголт, гэрлэх нөхцөл, журам, хууль зүйн үр дагавар	46
Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины харилцаа	51
Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцаа	57
Тэжээн тэтгэх, тэтгүүлэх харилцаа	64
Гэрлэлт дуусгавар болох нь	70
Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох	74
Гэрлэлтийг захиргааны ба шүүхийн журмаар цуцлах	79
Гэр бүлийн хүчирхийлэл	84
Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл	93
<b>4 бүлэг.</b> Үрчлэлт	98
Хүүхэд үрчлэх тухай ойлголт	98
Хүүхэд үрчлэх нөхцөл, журам	
Үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай, түүний үр дагавар	98
<b>5 бүлэг.</b> Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асран хүмүүжүүлэх	106
Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тухай ойлголт, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах	106
Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаа	109
Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа	114
<b>6 бүлэг.</b> Гэр бүлийн харилцааны олон улсын эрх зүйн зохицуулалт	119
Гэрлэлтийн харилцааны олон улсын эрх зүйн зохицуулалт	
Эцэг, эх, хүүхдийн харилцааны олон улсын эрх зүйн зохицуулалт	127
Гэр бүлийн харилцаанд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх нь	133



## НЭГ. "ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ" ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

*Дэлхийн банкны "Шүүх, эрх зүйн шинэчлэлт" төслийн Эрх зүйн боловсролыг сайжруулах дэд төсөл. "Гэр бүлийн эрх зүй" хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлын баг.*

### ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

<b>Хичээлийн нэр:</b>	Гэр бүлийн эрх зүй
<b>Индекс:</b>	
<b>Кредит цаг:</b>	2
<b>Нийт цаг:</b>	40 цаг (лекц-24, семинар-16)
<b>Семестр:</b>	IV
<b>Залгамж холбоо:</b>	Эрх зүйн онол, Үндсэн хуулийн эрх зүй хичээлийн дараа Иргэний эрх зүй, Өмчийн эрх зүй, Гэрээний эрх зүй хичээлтэй зэрэгцүүлэн судална.

№	Заавал судалсан байх хичээл	Үндэслэл
1	Эрх зүйн онол	Эрх зүйн онол хичээл нь юуны түрүүнд судлах шаардлагатай салбар эрх зүйн хичээлүүдийн суурь болох тул эрх зүйн онолын талаарх суурь мэдлэгийг эзэмших, хууль зүйн шинжлэх ухааны үндсэн нэр томъёонуудтай танилцах, эрх зүйт ёс, иргэний эрхийн үүднээс хуулийн тогтолцоонд хандах арга чадварт суралцах тулгуур нь болох учир уг хичээлийг юуны түрүүнд судалсан байх шаардлагатай.
2	Үндсэн хуулийн эрх зүй	Аливаа салбар эрх зүйн үндсэн эх сурвалж болох тул уг хичээлийг судалж Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчим, хүний эрх, эрх чөлөө, түүнийг баталгааг танин мэдсэнээр гэр бүлийн эрх зүйг салбар шинжлэх ухааны хүрээнд гүнзгийрүүлэн судлах суурь мэдлэг нь болно.
3	Иргэний эрх зүй	Эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулж байгаа хувийн эрх зүйн суурь болох тул иргэний эрх зүйн категор болон Гэрээний эрх зүй, Өмчийн эрх зүйг судалж, танин мэдсэнээр гэр бүлийн эрх зүйн хүрээнд гүнзгийрүүлэн судлахад тулгуур бол ох үүднээс эдгээр хичээлийг судалсан байх шаардлагатай бөгөөд зэрэгцүүлэн судлах боломжтой.

4	Гадаад хэл	Гэр бүлийн эрх зүйн хичээлээр олсон мэдлэгээ бататган цаашид гүнзгийрүүлэн, бие даан суралцах, семинарын хичээлд бэлтгэх, гадаад хэл дээр ном, сурах бичиг, сонин сэтгүүл, веб хуудсыг ашиглахад хэлний мэдлэг нэн чухал тул гадаад хэлний зохих мэдлэгтэй байх шаардлагатай.
---	------------	---

### **Хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага**

Нийгмийн амьдралын өөрчлөлт, хөгжлийн чиг хандлагад уялдан гэр бүлийн амьдрал, түүний хэв маягт гарч буй эерэг, сөрөг үзэгдлүүд, гэр бүлийн өнөөгийн хөгжил, төлөв байдлыг судлахын зэрэгцээ гэр бүлийн харилцааны асуудлуудыг эрх зүйн үүднээс авч судлах, "гэр бүл" хэмээх ойлголтын мөн чанар, түүний хүрээнд үүсч буй олон талт харилцаа нь эрх зүйн хэм хэмжээгээр төдийгүй зан заншил, ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг онцлогийг танин мэдэх нь чухал юм.

Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин бөгөөд гэр бүлийн харилцаанаас ангид нэг ч хүн оршин амьдрах боломжгүй юм. Хүмүүс өөрсдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалж эрхээ хэрэгжүүлэн, үүргээ гүйцэтгэхийн тулд нэн түрүүнд гэр бүлийн харилцааны эрх зүйн зохицуулалтын талаар зохих мэдлэгтэйбайх зайлшгүй шаардлага бий болно.

Гэр бүлийн эрх зүйн харилцаа нь гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүдийн хооронд үүсэж буй эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүрэгтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцааны нэгэн төрөл болно.

"Гэр бүлийн эрх зүй" хичээлийг судалснаар гэр бүлийн асуудалд эрх зүйн үүднээс хандаж гэр бүлийн хууль тогтоомжийн зохицуулалтын талаар шинжлэх ухааны цэгцтэй мэддэг, чадвар, дадал эзэмшиж, түүнийгээ өөрийн амьдрал, ахуй, ажил мэргэжил болон хууль тогтоомжийг, хэрэглэж, хэрэгжүүлж сурах хэрэгцээ шаардлагын үүднээс энэхүү хичээлийг суддах шаардлага зайлшгүй гарч байна.

### **Хичээлийн зорилго**

Энэ хичээлээр гэр бүлийн талаарх ерөнхий мэдлэгт тулгуурлан гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн хооронд үүссэн эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцааны эрх зүйн зохицуулалтын талаарх шинжлэх ухааны онолын мэддэгийг олгох замаар гэрлэлт, гэр бүлийн мөн чанарыг эрх зүйн үүднээс танин мэдэж, холбогдох хууль тогтоомжийн ач холбогдолыг ойлгосны үндсэн дээр амьдрал, практикт хэрэглэх, гэр бүлийн хүрээнд үүссэн асуудалд эрх зүйн үүднээс хандаж, үнэлэлт дүгнэлт өгөх, тодорхойлох, тайлбарлах, бусдад хууль зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх, эрх зүйн шийдэл гаргах, тодорхой арга замуудыг сонгож хэрэглэх чадварыг эзэмшүүлэхийн зэрэгцээ хууль зүйн мэргэжлийн ур чадвартай болох эрмэлзлэлийг бий болгоход дэмжлэг болох юм.

Гэр бүлийн эрх зүйн хичээлээр олж авсан мэдлэг, чадвар дээрээ тулгуурлан гэр бүлийн асуудалд эрх зүйн болон хүний эрхийн мэдрэмжтэй хандах хандлага төлөвшинө.



### Хичээлийн зорилт:

- Эрх зүйн тогтолцоонд гэр бүлийн эрх зүйн гүйцэтгэх үүргийг тодорхойлж сурах
- Гэр бүлийн эрх зүй болон иргэний эрх зүйн нийтлэг болон ялгаатай шинжүүдийг тодорхойлох
- Гэр бүлийн эрх зүйн онолын суурь мэддэг эзэмших
- Гэр бүлийн эрх зүйн талаар өөрийн мэдлэгийг бүтээх
- Гэр бүлийн эрх зүйн үндсэн ойлголтуудыг тайлбарлах
- Гэр бүлийн аливаа асуудалд эрх зүйн үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзэмших
- Олж авсан мэддэг, чадвараа амьдрал практикт хэрэглэж, хэрэгжүүлж сурах
- Гэр бүлийн асуудалд эрх зүйн онолын болон хүний эрхийн мэдрэмжтэй хандаж сурах
- Гэр бүлийн хууль тогтоомжоор бусдад хууль зүйн зөвлөгөө өгөх арга барилд суралцах, нотлох баримтыг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт гаргах, бичиг баримт боловсруулах дадал дүй эзэмших

### ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЦАГ ХУВААРИЛАЛТ

№	Бүлгийн нэр	Лекцийн сэдэв	Цаг	Семинарын сэдэв	Цаг
1	Гэр бүлийн эрх зүйн ойлголт	Гэр бүлийн эрх зүйн ойлголт, зохицуулах зүйл, зохицуулалтын арга, зарчим Гэр бүлийн эрх зүйн харилцааны ойлголт, ангилал, элемент	4	Гэр бүлийн эрх зүйн эх сурвалжийг тодорхойлох	2
2	Гэр бүлийн эрх зүйн хамгаалалт	Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдээс эрхээ хэрэгжүүлэх нь Гэр бүлийн эрх зүйн хамгаалалт	2	Шүүхийн бус хамгаалалтын үр нөлөө	2
3	Гэрлэлт, түүний хууль зүйн үр дагавар	Гэрлэлтийн ойлголт, гэрлэх нөхцөл, журам, хууль зүйн үр дагавар Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины харилцаа Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааны ойлголт, онцлог Тэжээн тэтгэх, тэтгүүлэх харилцаа Гэрлэлт дуусгавар болох нь	10	Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох Гэрлэлтийг захиргааны ба шүүхийн журмаар цуцлах Гэр бүлийн хүчирхийлэл Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл	8

**ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 1**  
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1	Үрчлэлт	Хүүхэд үрчлэх тухай ойлголт, онцлог Хүүхэд үрчлэх нөхцөл, журам Үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай, түүний үр дагавар	2	Гэр бүлийн эрх зүйн эх сурвалжийг тодорхойлох	
2	Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асран хүмүүжүүлэх	Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тухай ойлголт, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаа	4	Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа	2
3	Гэр бүлийн харилцааны олон улсын эрхзүйн зохицуулалт	Гэрлэлтийн харилцааны олон улсын эрх зүйн зохицуулалт Эцэг, эх, хүүхдийн харилцааны олон улсын эрх зүйн зохицуулалт	2	Гэр бүлийн харилцаанд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх нь	2



## ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙ

### Гэр бүлийн эрх зүй хичээлийн арга зүйд тавигдах шаардлага

Гэр бүлийн эрх зүй хичээлийг судлах хэрэгцээ, хичээлийн зорилго, зорилттой уялдан уг хичээлийг заах арга зүйд дараах шаардлага тавигдана. Үүнд:

- Хичээлийн зорилгыг хангахуйц, түүний агуулгад тохирсон арга, хэлбэрийг сонгож хичээлийг заах
- Гэр бүлийн эрх зүй хичээлээр уг харилцаанд оролцогчдын хооронд үүсэх гэр бүлийн харилцаа, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины харилцаа, түүний онцлог, мөн чанарын талаар оюутан өөрөө мэдлэг бүтээх, түүнийгээ амьдралд хэрэглэх, хууль хэрэглэх дадал, чадвар эзэмших нөхцөл боломжийг хангах
- Оюутан бүр хичээлд идэвхитэй, жигд оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх
- Хичээлийн агуулга нь онол, практикт нийцсэн байх
- Оюутныг бие даан ажиллах, хөгжүүлэхэд чиглэх

### Мэдээлэл түгээх аргууд

#### Лекц (Lecture)

Лекцийн арга нь онолын нэгдсэн ойлголт өгөх зорилгыг хангахад илүү тохиромжтой байдаг бөгөөд гэр бүлийн эрх зүйн хичээлийн агуулгыг судлахад лекцийн аргыг өргөнөөр ашигладаг. Гэр бүлийн эрх зүйн ойлголт, зарчим, харилцаа зэрэг тулгуур ойлголтуудыг лекцийн аргаар заах нь илүү үр дүнтэй.

Гэр бүлийн эрх зүйн хичээлийн зарим сэдвийг дан ганц лекцийн аргаар заах нь тохиромжгүй тул кейс буюу тохиолдол шинжлэх болон хэлэлцүүлэг явуулах, шалтгаан үр дагаврыг тодорхойлох зэрэг оролцооны аргуудтай хослуулан ашиглах нь зүйтэй.

Лекцийн хичээлд багш цуглуулсан мэдээллээ хураангуй хэлбэрт оруулан урьдчилан тараах, зураг, бүдүүвч болон бусад үзүүлэн, тараах материал бэлтгэж ашиглах нь цаг хэмнэх, оюутан цэгцтэй мэдээлэл хүлээж авах чадварыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой. Гэр бүлийн эрх зүй хичээлийг лекцийн аргаар заахдаа уг аргыг лекцийн зорилго, бүтэц, агуулгатай нийцүүлэн төлөвлөх шаардлагатай. Тухайлбал, олон эх сурвалжаас авсан мэдээллийг нэгтгэн дүгнэж оюутнуудад хүргэх, тухайн лекцийн хичээлийн хамгийн чухал хэрэгтэй хэсгийг оюутанд хүргэх нь зүйтэй.

#### “Хүн бүр багш” (Each one teach one)

Бүлэг сэдвийг танилцуулахад болон үзсэн сэдвийн агуулга, ухагдахуунуудыг дүгнэх, мэдээллийн агуулгыг оюутнуудад хүргэхэд энэ аргыг гол төлөв хэрэглэнэ.

Энэ аргын зорилго нь оюутнууд сургалтын үйл явцад идэвхтэй оролцох, харилцан санал бодлоо солилцоход ихээхэн ач холбогдолтой юм. Энэ аргыг хэрэглэснээр уг сэдвээр заавал эзэмших ёстой агуулга болон ухагдахууны талаар ерөнхий ойлголт өгөх ба оюутнуудын сонирхлыг өдөөж, асуулт тавихад хүргэнэ.

#### Хэрэгжүүлэх дараалал:

- Лекцийн агуулга, мэдээллийг утгат хэсгээр нь хувааж, тарааж өгөх зорилгоор оюутныхаа тоогоор жижиг цаасан дээр бичиж бэлдээд оролцогч оюутан нэг бүрт тараана.
- Оюутнууд мэдээллийг уншсаны дараа уг уншсан зүйлийнхээ агуулгыг ярих,

зураглал, бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэлээ хийнэ. Энэ үед багш тусламж шаардлагатай оюутанд зөвлөгөө өгч, тайлбар хийж болно.

- Бэлтгэх хугацаа дууссаны дараа тэд мэдээллээ бие биедээ танилцуулж оролцогч оюутан бүрт хүргэх зорилгоор ангиа тойрон явна. Оюутан бүр өөрт буй мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл авч дуустал энэ ажил үргэлжилнэ. Зорилго нь бусадтай мэдээлэл солилцох буюу өөрт буй мэдээллээ бусдад тарааж, шинэ мэдээлэл бусдаас олж авахад оршино. Үүний дараа багш оюутнуудаас бие биенээсээ юу мэдсэн, ямар шинэ мэдээлэл авсан тухай, уг мэдээллийг юу гэж ойлгож байгаа тухай, энэ мэдсэн зүйл өөрт нь ямар хэрэгцээтэй болох тухай асууж, харилцан яриулна. Ярилцлагын явцад оюутнуудад юу хэрэгтэй байгаа, тэдний бие биеэсээ авсан мэдээллийг хэрхэн цэгцлэх шаардлагатайг багш ажиглаж, тэр дагуу шаардлагатай нэмэлт мэдээллийг өгнө.

## **Оролцооны аргууд**

### **Тохиолдол шинжлэх (Case method)**

Тохиолдол шинжлэх арга нь суралцагчдад эрх зүйн хэм хэмжээг амьдралын тодорхой жишээн дээр үндэслэн хэрэглэж сурахад туслахад чиглэгдсэн асуултын аргад тулгуурласан хэлбэр юм. Гэр бүлийн эрх зүйн хичээл нь амьдралд харьцангуй ойрхон, практикаар байнга шалгагдаж байдаг учир энэ хичээлийг тохиолдол шинжлэх аргад түшиглэн явуулах нь илүү тохиромжтой юм. Сургалтын энэ арга нь суралцагчийг ямар нэгэн бодит баримтын талаар асуулга тавих, тодорхой нөхцөлд чухам ямар элемент нь чухал болохыг тодорхойлж, тэдгээрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, тохиолдол нэг бүрийг эргэцүүлэн бодож байх боломж олгодог.

Шүүхийн шийдвэр болон гэр бүлийн хэрэг, маргаанд дүн шинжилгээ хийх, хууль хэрэглэх дадал, чадвар олох, тухайн тохиолдлыг шинжлэх явцдаа суралцагчид нь цээжлэн тогтоох эхний хэлбэрээс эхлээд бодит баримтыг үнэлэх хүртэлх сэтгэхүйн үйлдлүүдийг хийж даддагажихтулоюутнууд уг хичээлийг сонирхон судлах, идэвхийг өрнүүлэхэд энэ аргын зорилго оршино.

Сургалтын тохиолдлууд ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байдаг боловч кино дүрс, дуу бичлэг, шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаан, дүр бүтээж тоглох болон бусад хэлбэрээр байж болно.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхийн тулд практикт гарч байсан гэр бүлийн эрх зүйтэй холбоотой хэрэг маргааны талаархи янз бүрийн мэдээлэл, хууль тогтоомж, эрх зүйн актууд болон холбогдох бусад гарын авлагыг бэлтгэсэн байх буюу, оюутнуудаар өөрсдөөр нь бэлдүүлсэн байх шаардлагатай.

Сонгож авсан тохиолдол нь бодит байдлын тусгал болох бөгөөд шүүхээр шийдэгдсэн хэрэг, маргаан байвал оюутнууд практик мэддэг, чадвар дадал эзэмшихэд нэн чухал болно.

Ердийн танхимын нөхцөлд багш нь энэ аргаар хичээл явуулахад лектор биш, ярилцлагыг хөтлөгчийн дүрд тоглох болно. Харин багш энэ дүрд бэлэн байх ёстой.

Мөн хуулийн зарим зүйл, заалт тэр бүр ойлгомжтой биш, тэгээд ч хуулийн цоорхой, хийдэл байгаа үед багш, оюутнууд хууль ямар үзэл баримтлалаар батлагдсан, хуулийн тухайн зүйл, заалтыг үзэл баримтлалд нь хэрхэн нийцүүлэн ойлгох, яаж өөрчлөн сайжруулж болох, ийнхүү өөрчлөн сайжруулахад оролцох арга замуудын талаар ярилцахад хүрдэг. Энэ нь нэг талаар цаг их шаардах боловч нөгөөтэйгүүр оюутан хуулийн зүйл заалтыг бусад хууль тогтоомжтой харьцуулах, хуулиа хэрхэн ойлгох чадварыг эзэмшихэд дөхөм болдог.



Энэ аргыг хэрэглэхдээ багш 25 хүртэл оюутантай ажиллах хэрэгтэй бөгөөд хэтэрхий олон оюутантай багш нэгэн зэрэг ажилласан тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлөх сөрөг талтай.

Холбогдох гарын авлага, ном товхимол, хууль тогтоомжийг урьдчилан бэлдсэн байх бөгөөд энэ шаардлага хангагдаагүй тохиолдолд хичээлийг үр дүнтэй явуулах боломжгүй.

Багшийн хувьд хуулийн байгууллагад ажилласан, өмгөөллийн үйл ажиллагаа явуулдаг, онол, практикийн өндөр мэдлэг, чадвартай байх учиртай.

### **Тохиолдлыг бэлтгэх:**

Тохиолдлыг сонгож авах болон боловсруулахдаа дараах шалгууруудыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Тухайн хичээлийн агуулга, арга, үр дүнд тохирсон эсэх.
- Гэр бүлийн эрх зүйн хүрээнд практикт олонтоо тохиолддог маргаантай асуудлуудыг тусгасан буюу бодит байдалд бүрэн нийцсэн эсэх.
- Хичээлийн хөтөлбөрийн дагуу оюутнуудад сонирхолтой байх.
- Тохиолдол нь оюутанд анализ хийх, шийдэл гаргах, бодож боловсруулах боломж олгохуйц байгаа эсэх.
- Тохиолдлын талаар эерэг, сөрөг нотолгооны хувилбар, шийдэлд хүрэхүйц эсэх.

Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай баримт нотолгоог бүрдүүлж, холбогдох мэдээллийг өгөх нь мэдээллийг боловсруулж, үндэслэл бүхий шийдвэр гаргахад чухал нөлөөтэй.

Тохиолдлыг уншуулж танилцуулахдаа тохиолдлын эцсийн шийдийг мэдээлэхгүй байх хэрэгтэй. Уг асуудлын бодит шийдлийг хичээлийн төгсгөлд авч үзэж болно. Гэхдээ зарим тохиолдлоос хамаарч тухайн өгөгдлийн шийдлийг хэлээд зөв, эсвэл буруу шийдэл болох талаар хэлэлцүүлж болох юм.

Оюутнуудын анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлэх хэрэгтэй. Юуны түрүүнд тохиолдлын үйл явдлыг сайтар ойлгуулах нь чухал.

Хичээлийн явцад бүх оюутан нэг ижил баримтад тулгуурлах ёстой бөгөөд энэ үндсэн дээрээ идэвхтэй ажиллах ёстойтулбагш сургалтын явцад оюутныг идэвхжүүлэхэд энэ шатанд анхаарч байх нь маш чухал юм. Үүний хамт уншлагын дадал суугаагүй суралцагчдад ч энэ үе нь их ач холбогдол, нөлөөлөлтэй байдаг.

Багш өөрөө болон оюутнуудаар өөрсдөөр нь асуулт бэлдүүлж болно. Оюутнууд хэрэгтэй мэдээллээ авч тохиолдлыг тал бүрээс нь сайн судалж, ойлгосны эцэст шийдэл гаргах үйл ажиллагаандаа орно.

Оюутнууд мэдээллээ боловсруулан тохиолдлоо ойлгосны үндсэн дээр шийдэх бөгөөд ийнхүү шийдвэр гаргах үйл явцыг багш ямар ч аргаар зохион байгуулж болно.

### **Хэлэлцүүлгийн арга (Discuss)**

Хэлэлцүүлгийн арга нь оюутан олон үзэл бодлыг харьцуулж, ойлгож, эсрэг үзэл бодлыг няцаах, өөрийн нотолгоог дэвшүүлэх, хамгаалах, харилцан мэдээлэл солилцох, өөрийн байр суурь, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдыг сонсох, хүлээн зөвшөөрөх чадварыг эзэмшүүлэх зорилготой ба цаашид багаар ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

Онолын болон практик, хууль тогтоомжийн хүрээнд маргаан өрнөхүйц сэдвээр

багш хэлэлцүүлэг, ярилцлагыг явуулна.

Багш оюутны мэдлэгийн ерөнхий түвшин болон хэлэлцүүлэг хийх даддага туршлага зэргийг харгалзан цаг хэмнэх үүднээс өөрөө уг жишээний гол маргаантай хэсгийг нь тайлбарлан ярьж өгч болно.

Оюутан шүүн хэлэлцэж буй ямар ч асуудал, санаа бодол, хүсэлт нь эвтэй эетэй байдал, маргаан зөрүүтэй аль ч үед адил тэгшээр хэлэлцэгдэж, яригдах ёстойг ойлгосон байх ёстой. Өөрөөр хэлбэл бусдыгаа сонсдог, үзэл санааг нь хүндэтгэдэг, бодитой хандаж, үнэлэлт өгөх чадвартай байх ёстой.

Оюутнуудын гаргасан бүх учир шалтгаан, нотолгоог сонссоны дараа шийдвэр гаргуулах цаг гаргах хэрэгтэй бөгөөд шийдвэрийн үндэслэлийг асуух нь зүйтэй. Харин багш өөрөө шийдвэр гаргасан бол оюутнуудаар шийдвэртээ үнэлэлт өгүүлэх хэрэгтэй.

Аливаа маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөнддөг тул үүнээс сэтгэлийн хөдөлгөөн үүсгэдэг талтай учраас заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар явуулахад хүндрэлтэй байдаг. Иймээс хичээлийг зохион байгуулалт сайтай явуулах, үүссэн маргаантай байдлыг хяналтандаа байлгахад дараах дүрэм нь багшид тус болно. Тухайлбал,

- Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.
- Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.
- Маргааныг хийсвэр түвшинд хүргэхээсээ өмнө тодорхой асуудлуудаар ярилцана.
- Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж, бусдын санааг сонсох.
- Өөрийн байр суурь зөв эсэхэд анхаарлаа хандуулж, түүний сул талуудыг хүлээн зөвшөөрнө.

### **Багаар ажиллах (Small group)**

Багаар ажиллах арга нь бусдыг анхааралтай сонсох, нэгдсэн дүгнэлтэд хүрэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, багаа төлөөлөх зэрэг чадварыг эзэмшиж түүнийгээ амьдралд хэрэглэх боломжийг оюутанд олгодог.

Энэхүү аргын зорилго нь хамтран ажиллах болон бусдыг ойлгох зэрэг чухал чадварыг эзэмших боломжийг олгодгоос гадна өөр хоорондоо зөрүүтэй бодол санааг нийцүүлэхэд тусалдаг. Юуны өмнө багийн ажлын зааварчилгааг маш тодорхой өгөх ёстой. Хэрэв дасгал дээр ажиллах хэлбэрээр ажиллаж байгаа үед гэр бүлийн эрх зүй хичээлээр үзсэн ойлголтоо амьдралд хэрэглэх чадварыг эзэмшихийн тулд тодорхой сэдэв сонгон авч дасгалыг бэлтгэнэ.

Жижиг багт тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд хангалттай цаг хугацаа олгох ёстой. Ойролцоогоор 3-5 гишүүнтэй баг бүрдүүлэх нь хамгийн зохимжтой бөгөөд оюутнуудыг багт хуваахдаа тэдэнд аль болох сонирхолтой хэлбэрээр буюу тоглоом тоглуулах зэргээр хуваах нь тохиромжтой.

Багийн нэг гишүүн үр дүнгээ танилцуулахад түүнийг хэрхэн сонгох боломжийг бүрдүүлж өгнө.

Багаар ажиллахад гарах дуу чимээг хүлээн зөвшөөрөх ёстой. Жижиг багаар ажиллах явцад суралцагчид бие биенээ харах боломжтой байдлаар суусан байна.

Энэ нь гишүүн тус бүр бусад гишүүдээ төвөггүйгээр харж, харилцах боломжийг олгодог.



## Сургалтын загвар хичээл

**Сэдэв:** Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа

### Хичээлийн зорилго:

Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхийг хүссэн иргэнд гэрээний үндсэн дээр хүүхдийг шилжүүлэх нь тухайн хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах нэг арга мөн гэдгийг ойлгон, энэхүү гэрээг бусад гэрээнээс ялгах, онцлог үр дагаврыг нь танин мэдсэнээр тодорхой тохиолдолд уг гэрээг байгуулах чадвар эзэмшиж, цаашид хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад эрх зүйн талаас хандах хандлагыг төлөвшүүлэхэд оршино.

### Сэдвийн агуулга:

1. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ асарч хүмүүжүүлэхийг хүссэн иргэнд шилжүүлэх нь хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах шинэлэг арга болох тухай
2. Асран хүмүүжүүлэх гэрээний агуулга
3. Асран хүмүүжүүлэх иргэнд тавигдах шаардлага
4. Асран хүмүүжүүлэх гэрээ дуусгавар болох

### Асуудал:

1. Асран хүмүүжүүлэх гэрээний нөхцөлийг тодорхойлох
2. Асран хүмүүжүүлэх гэрээний үр дагаврыг тайлбарлах
3. Асран хүмүүжүүлэх гэрээг бусад гэрээнээс ялгах
4. Асран хүмүүжүүлэх гэрээ байгуулж болохгүй хүний талаар тодруулах
5. Асран хүмүүжүүлэх гэрээ дуусгавар болох асуудлыг хэлэлцэх
6. Гэр бүлийн хуулийн 74 дүгээр зүйл амьдралд хэрэгжих боломж ямар байгаад дүгнэлт хийж тайлбарлах

### Санал болгож байгаа арга:

- Оюуны зугаалга
- Багаар ажиллах

### Семинарын хичээлийн дараалал:

Багш энэхүү сэдвийн хүрээнд семинарын хичээл явуулахын өмнө лекцийн хичээлээр тодорхой мэдлэг олгосон байх бөгөөд оюутнууд сэдвийн агуулгыг хэрхэн авч үзэж, ямар мэдлэгтэй байгааг оюуны зугаалга хийх явцад шалгана.

- Оюутнуудыг багуудад хуваах /Багт хуваахдаа нэг баг тус бүрт 6 хүртэл хүн байхаар тооцно/
- Багш баг тус бүрт урьдчилан бэлтгэсэн материалаа тарааж өгнө /Тараах материалын агуулга нь асран хүмүүжүүлэх гэрээний агуулга, бусад гэрээнээс ялгагдах онцлогийг тодруулах, гэрээний ач холбогдлыг тодорхойлох, гэрээний эх загварыг баг тус бүр бэлтгэхэд чиглэгдсэн байна/
- Багш багийн ажиллах журмыг тодорхой тайлбарлаж өгнө
- Багийн гишүүд хоорондоо зөвлөлдөх, ярилцах, гэрээний төслийг бичгээр боловсруулах зэргээр ажиллах ба нэг гишүүн нь багийн ажлын үр дүнг бусад

тайлбарлана. Шаардлагатай гэж үзвэл бусад гишүүд нэмэлт тайлбар хийж болно. Баг тус бүрийн боловсруулсан асран хүмүүжүүлэх гэрээний төсөл, загварыг бичгэн хэлбэрээр гаргаж үзүүлнэ.

- Багш багуудын хооронд мэтгэлцээн өрнүүлж, оюутнуудад мэтгэлцэх боломж олгоно.
- Багш семинарын хичээлийн явцыг дүгнэж, оюутнуудын олж авсан мэдлэгийг баталгаажуулах асуулт тавьж, хариуг сонсож хичээлийг нэгтгэн дүгнэнэ.

## ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

### Үнэлгээний зорилго

Гэр бүлийн эрх зүйн хичээлийн явцад олж авсан мэдлэг, түүнийг практик амьдралд ашиглах чадвар хийгээд оюуны үнэт зүйлийн баримжаалалд гарсан өөрчлөлтийг бодитойгоор үнэлэх нь уг хичээлийн үнэлгээний гол зорилго юм.

Үнэлгээ нь бүхэлдээ зорилгодоо хүрч чадсан эсэхийг тогтооход чиглэгдэнэ.

Багш үнэлгээний дүнг дараахь зорилгоор ашиглана:

- давтан судлах шаардлагатай эсэхийг тогтоох
- сургалтын үр дүнд оюутны мэдлэг, чадвар ямар түвшинд байгааг тодорхойлох
- багш өөрийгөө болон хичээл зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх
- сурч боловсрох эрмэлзлэлийг идэвхжүүлэн хөгжүүлэх

### Үнэлгээний шалгуур:

#### Мэдлэг

- тодорхой асуултанд онолын үндэстэй хариулж чадаж байгаа эсэх
- мэдлэгээ бусдад танилцуулж, тайлбарлаж чадаж байгаа эсэх
- тухайн судлагдахууны тодорхойлолт гаргах, үндсэн ба үндсэн бусыг ялгах харьцуулалт хийх, хамаарлыг тогтоох арга зүйг эзэмшсэн эсэх
- хариулт болон үзэл бодлынхоо үндэслэл нотолгоог гаргаж байгаа байдал

#### Чадвар

- тодорхой онолын мэдлэгийг ашиглан (үндэслэл, нотолгоо болгох, жишээ баримт татах, таилбарлах) тухайн асуудлыг тайлбарлаж, шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх
- бодлого бодох, тохиолдол шийдвэрлэхдээ Гэр бүлийн эрх зүйн онолын мэдлэгээ ашиглаж чадаж байгаа эсэх
- баримт бичиг боловсруулах чадварт суралцсан байдал
- амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадварын хөгжлийн түвшин

#### Хандлага

- өөрийн үзэл бодол, байр суурь, үнэлгээ дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа эсэх, ийнхүү илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж, түүнээс үнэ цэнэтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх
- багийн гишүүн байх, бусдыг төлөөлөх чадварын хөгжилт
- ялгаатай үзэл бодол байр сууринд хандах хандлага, түүнийг хүлээн зөвшөөрч



байгаа байдал

- асуудалд хууль зүйн үүднээс хандаж байгаа эсэх

Үүнээс гадна оюутны мэдлэг, чадварын түвшнийг дараахь байдлаар ангилан, үнэлгээг ялгавартай тогтоож байх нь зүйтэй. Энэ байдлыг хамгийн энгийн буюу доод түвшнээс хамгийн төвөгтэй буюу дээд түвшинд хүрэх дарааллаар тодорхойлж болно. Үүнд:

**Мэдлэг**

Хамгийн доод түвшин. Ихэвчлэн тодорхой баримт, мэдээллийг тогтоож авах, сэргээн санах чадварыг авч үзнэ.

**Ойлгоц**

Бусдын олж тогтоосон зүйлийг оюутан наад захын түвшинд ойлгосон болохыг харуулж буй тайлбарлах, өөрийн үгээр илэрхийлэх, ургуулан бодож дүгнэлт хийх чадвар юм.

**Хэрэглээ**

Оюутан олж авсан ойлголт, зүй тогтол зэргийг урьд тохиолдож байгаагүй, шинэ нөхцөл байдал, мөн практикийн тодорхой тохиолдолд хэрэглэх чадвар болно.

**Анализ**

Мэдээллийг бүрэлдэхүүн хэсгүүдэд, задлан хувааж, ялгаж зааглахыг хэлнэ.

**Синтез**

Бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэн бүхэл зүйл болгохыг хэлнэ. Оюутан урьд нь байгаагүй бүтцийн шинэ хувилбарыг бүтээх чадвартай байх ёстой.

**Үнэлэлт**

Хамгийн дээд түвшин. Бусдын бүтээсэн зүйл, түүний логик бүтэц, үндэслэл нотолгоо нь бүрэн гүйцэд хийгдсэн эсэхэд үнэлгээ өгөх зэргийг ойлгоно.

Дээрхи чадварын түвшинг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

Сургалтын зорилго

Оюутны чадвар

Заавал эзэмшсэн байвал зохих (essential)  
Эзэмшсэн байвал сайшаалтай (desirable)

мэдлэг, ойлгоц, хэрэглээ  
анализ, синтез, үнэлгээ

### **Сэдвийн жишиг үнэлгээ**

**Сэдэв:** Үрчлэлтийг хүчингүйд тооцох, түүний үр дагавар

#### **Сэдвийн зорилго:**

Үрчлэлтийг хүчингүйд тооцох нөхцөл, ажиллагааны журам, түүний үр дагаврын талаар тодорхой мэдлэгтэй болсноор хүүхдийн эрх ашгийг хамгаалах чадвартай болж, энэ асуудалд хууль зүйн талаас хандах хандлага төлөвшихөд оршино.

#### **Мэдлэг үнэлэх шалгуур:**

- Сэдвийн хүрээнд хэрэглэгдэж буй гол нэр томъёоны агуулгыг мэдэж байгаа эсэх
- Хүүхэд үрчлэхийг Сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэж байдаг бол үрчлэлтийг хүчингүйд тооцуулахаар гаргасан хүсэлтийг шүүх харъяалан хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэдэг журамтайг мэдэж байгаа эсэх
- Үрчлэлтийг хүчингүйд тооцсон тохиолдолд түүнээс үүсэх эрх зүйн үр дагавар, холбогдох хууль тогтоомжийн заалтын зорилго, агуулгыг мэдэж байгаа эсэх

#### **Чадвар үнэлэх шалгуур:**

- Хүүхэд үрчлэх талаарх онолын мэдлэгээ ашиглан үрчлэлтийн онцлог шинж, түүний мөн чанарыг нь илрүүлж чадаж байгаа эсэх
- Гэр бүлийн амьдралд өргөн тохиолддог хүүхэд үрчлэх, түүний талаар гарсан маргаан, үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай асуудлыг хууль зүйн үүднээс задлан шинжилж, төсөөтэй тохиолдлуудыг харьцуулан авч үзэж, ашиглах чадвар эзэмшсэн эсэх
- Тодорхой өгөгдөл ашиглан тайлбар хийх чадвартай эсэх
- Амаар болон бичгэн хэлбэрээр санал бодлоо чөлөөтэй илэрхийлж чадаж байгаа эсэх
- Эрх бүхий байгууллагад бүрдүүлж өгөх бичиг баримтыг тодорхойлох, боловсруулах чадвар эзэмшсэн эсэх
- Эрх бүхий байгууллагаас гарсан эрх зүйн баримт бичигт дүгнэлт өгч чадаж байгаа эсэх

#### **Хандлага үнэлэх шалгуур:**

- Өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж байгаа эсэх
- Амьдрал практикт байж болох хязгааргүй олон янзын боломж, хувилбарыг хуульд нэг бүрчлэн, нарийвчлан зааж өгөх боломжгүй, гагцхүү ерөнхий хүрээ заагийг тогтоосон байдаг тул үүнийг зөв ойлгож, тухайн тохиолдолд бүрт хууль зүйн талаас нь хандах хандлага төлөвшсөн эсэх

#### **Мэдлэг, чадварын түвшинг ялгавартай үнэлэх жишиг**

Мэдлэг 25%

Ойлгоц 40%

Хэрэглээ 55%



Анализ 70%  
Синтез 85%  
Үнэлэлт 100%

Оюутан өөрийн мэдлэгийн түвшинг харуулах боломжийг олон арга хэлбэрээр нээлттэй болгох хэрэгтэй. Асуултад хариулах, багшаас асуулт асуух, бусад оюутны өгсөн хариултад тайлбар, шүүмж хэлэх, эсэ бичих, бодлого бодох, тохиолдол шинжлэх, шинэлэг мэдээлэл цуглуулж, дүгнэлт хийх, түүнийгээ бусад оюутнуудад танилцуулах гэх мэт арга хэлбэр байж болно. Эдгээрийн аль ч хэлбэрийг сонгосон оюутны мэдлэгийг дээрх зургаан түвшинд ялгавартай үнэлэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, бичгээр хийсэн ажлыг илүү хөдөлмөр зарцуулсан гэж үзэн илүүтэй үнэлэх хандлагаас зайлсхийвэл зохино.

### **Жишиг даалгавар:**

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 4-р хорооны иргэн Должин эцэг, эх нь хоёулаа нас барсан өнчин охин Дариаг 11 настай байхад нь хүүхдийн асрамжийн газраас үрчлэн авчээ. Дариаг 15 нас хүртэл нь тэрээр түүнийг төрсөн хүүхдийн адил асарч хүмүүжүүлдэг байсан боловч, сүүлийн нэг жилийн хугацаанд үл ялих шалтгаанаар түүнтэй маргалдаж, хэрцгий догшин харьцаж, орон гэрээсээ хөөж, биед нь удаа дараа гэмтэл учруулах болжээ. Энэ байдлыг тэсвэрлэхээ байсан Дариа хэнд хандаж эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахаа мэдэхгүй байв. Энэ үед Дариа 16 насанд хүрч байсан байна.

### **Шийдвэрлэх асуудал:**

- Дариа өөрийнхөө эрх ашгийг хэрхэн хамгаалах вэ?
- Үрчлэлтийг хүчингүйд тооцох үндэслэлийг нэрлэнэ үү?
- Дариад эрх зүйн туслалцаа үзүүлнэ үү?

### **Асуулт:**

- Ямар тохиолдолд үрчлэлтийг хүчингүйд тооцдог вэ?
- Үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай асуудлыг ямар байгууллага харьяалан шийдвэрлэдэг вэ?
- Үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлт гаргах эрхтэй этгээдийг нэрлэнэ үү?
- Үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай хэргийг хянан шийдвэрлэхэд заавал оролцох талуудыг нэрлэнэ үү?
- Үрчлэлтийн харилцааг дуусгавар болох хугацааг тодорхойлно уу?
- Үрчлэлтийг хүчингүйд тооцсоны үр дагаврыг нэрлэн тодорхой өгөгдөл дээр түүний мөн чанарыг илэрхийлнэ үү?
- Үрчлүүлэгч насанд хүрсэн бол үрчлэлтийг хүчингүйд тооцох боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- Үрчлэгчийн буруугаас үрчлүүлэгчид гэм хор учирсан бол түүнийг хянан шийдвэрлэх журмыг тодорхойлно уу?

## “ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ” ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

### I бүлэг. ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ОЙЛГОЛТ

#### ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ОЙЛГОЛТ ЗОХИЦУУЛАХ ЗҮЙЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА, ЗАРЧИМ

##### Сэдвийн агуулга

Гэр бүлийн эрх зүйн ойлголт

Гэр бүлийн эрх зүйн зохицуулах зүйл, түүний хамрах хүрээ

Гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын арга, онцлог

Гэр бүлийн эрх зүйн зарчим

##### Сэдвийн зорилго

Гэр бүлийн эрх зүйн ойлголт, зохицуулах зүйл, зохицуулалтын арга, зарчмын талаар онолын цэгцтэй мэдлэг олж авах, улмаар гэр бүлийн хүрээн дэх эрх зүйн асуудлыг тодорхойлох, гэр бүлийн эрх зүйн харилцаанд иргэний болон бусад хууль тогтоомж хэрэглэгдэх үндэслэл, гэр бүлийн эрх зүйн зарчмуудын агуулгыг холбогдох хууль тогтоомжийг хэрэглэн тайлбарлах, гэр бүлийн үнэт зүйлсийн талаар өөрийн үзэл баримтлалаа илэрхийлэх чадвар эзэмшинэ.



##### Нэр томъёоны тайлбар

**Гэр бүл** - Гэрлэлтийн үр дүнд буй болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ.

**Гэр бүлийн эрх зүй** - Гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцөл болон үрчлэлт, хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлэх, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон гэр бүлийн гишүүдийн хооронд үүссэн эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээний системчлэгдсэн нийлбэр цогц юм.


**Гэр бүлийн эрх зүйн зохицуулах зүйл** - Гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцааг хэлнэ.

**Гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын арга** - Гэр бүлийн эрх зүйн харилцааны зохицуулалтанд хэрэглэж байгаа хууль зүйн арга хэрэгсэл юм.

**Гэр бүлийн эрх зүйн зарчим** - Гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээнд тусгагдаж тухайн харилцааг зохицуулахад удирдлага болгох үзэл санааг хэлнэ.

**Гэр бүлийн эрх зүйн ойлголт, гэр бүлийг тодорхойлох хандлага**

Гэр бүлийн эрх зүйн мөн чанарыг тодорхойлохын тулд зохицуулж буй харилцааны онцлог шинжүүдийг илэрхийлсэн ойлголтуудыг авч үзэж түүнийг танин мэдэх шаардлагатай.





Судлаачид энэхүү ойлголтын мөн чанарыг биологи, нийгэм, социологи, хууль зүйн талаас нь тодорхойлдог.

### Нийгэм, философийн үүднээс

- ◆ Гэр бол нөхөр эхнэр, эцэг, эх, үр хүүхэд хүмүүсийн хоёр буюу хэд хэдэн үеэс бүрдсэн сэтгэл санаа, эд материал, ёс суртахууны харилцаагаар, юуны өмнө бие биедээ чин сэтгэлээсээ харамгүй туслах үйл ажиллагаагаар холбогдсон нийгмийн бүлэг юм. /Философский энциклопедический словарь М.1989/




- ◆ Эхнэр ба нөхөр, эцэг, эх ба үр хүүхдийн хоорондын хувийн харилцааны хэв загвар /Э.Берджесс/
- ◆ Цусан төрлийн ба эдийн засгийн байдлаар бус оюун санааны нийтлэгээр холбогдсон хүмүүс/Т.Афанасьев/
- ◆ Хүн амын биеийн болон оюун санааны хэрэгцээ, нийгмийн шаардлагаар нөхцөлдсөн гэрлэлт, ураг төрлийн буюу эхнэр, нөхөр, эцэг, эх, үр хүүхдийн харилцаа, түүнчлэн ахуй байдлын нийтлэг, ёс суртахууны хариуцлагад холбогдсон гишүүд бүхий нийгмийн бага бүлэг /А.Г.Харчев/

### Хууль зүйн үүднээс

- ◆ Гэр бүл, ураг төрөл, үрчлэлт болон өөр ямар нэгэн хэлбэрээр хүүхдийг авч хүмүүжүүлэх ба ёс суртахууны зарчим дээр гэр бүлийн харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоос урган гарсан эрх ба үүргийн холбоотой бүлэг хүмүүс /В.А.Ресянцеv/
- ◆ Гэрлэлт, ураг төрөл, үрчлэлт, гэр бүлд хүүхдийг хүмүүжүүлэх явцад үүссэн харилцан эрх, үүргээр холбогдсон хамтран амьдарч буй хүмүүсийн нэгддийг хэлнэ. /С.А.Муратова/
- ◆ Өөр хоорондоо гэрлэлт, ураг төрлийн үндсэн дээр ахуй байдлын нийтлэг ашиг сонирхол, үр удмаа төрүүлж хүмүүжүүлдэг, харилцан хувийн эрх, үүрэгтэй хүмүүсийн нэгдлийг хэлнэ. /Г.М.Нечаева/
- ◆ Хүүхэд төрүүлэх, хүмүүжүүлэх, аж ахуй хамтран хөтлөх, оюуны болон эр, эмийн харилцаа тогтоох, эд хөрөнгийн эрх, үүрэг эдлэх зорилгыг хүлээсэн гэр бүл, ураг төрөл, хүүхэд үрчлэх ба хуулийн бусад үндэслэлээс үүсэн бий болсон хүмүүсийн хамтын амьдрал /Е.М.Ворожейкин/

**Зохицуулах зүйл** Тухайн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн тодорхой төрлийн харилцаа юм. Гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл, журмыг тогтоож, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцаа, хүүхэд асран хүмүүжүүлэх, үрчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.



Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл нь гэрлэлт, гэр бүлийн хүрээнд үүссэн харилцаануудтай шууд хамааралтай тухайн субъектүүдийн эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болох хууль зүйн факт болохынхоо хувьд хэдийгээр бие даасан хуулиар зохицуулагдаж байгаа ч иргэний гэр бүлийн бүртгэлтэй холбогдсон харилцааг гэр бүлийн эрх зүйн зохицуулах зүйлд хамааруулна. Зохицуулалтын арга Энэ нь тухайн харилцааг эрх зүйн ямар арга хэрэгслээр зохицуулах вэ? гэдгийг илэрхийлсэн ойлголт юм.






**Гэр бүлийн эрх зүйн зорилго, чиг үүрэг** - Гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан харилцааг зохицуулахад оршино.



**Гэр бүлийн эрх зүйн зарчим** - Гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээнд тусгагдаж тухайн харилцааны оролцогчдоос болон гэр бүлийн харилцааг зохицуулахад удирдлага болгох хууль зүйн үзэл санааг хэлнэ.

Гэр бүлийн эрх зүйн зарчим нь Монгол Улсын үндсэн хуулиар баталгаажуулсан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох иргэний эрх, эрх чөлөөг хангах механизмыг бүрдүүлнэ. Гэр бүлийн эрх зүйн зарчмын агуулгыг зөв тодорхойлж амьдрал практикт хэрэгжүүлэх нь гэр бүлийн эрх зүйн нийгэмд гүйдэтгэх үүргийг тодорхой болгож, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход ач холбогдолтой юм. Гэр бүлийн эрх зүй нь дараах зарчмуудад тулгуурлана. Үүнд:





**Хяналтын асуулт:**

1. Монгол Улсад Ардын хувьсгал ялснаас хойших хугацаанд гэр бүлийн харилцааг ямар хуулиудаар зохицуулж байсан вэ? Ямар онцлог зохицуулалтууд тусгагдаж байсан бэ?
2. Гэр бүлийн эрх зүйн харилцаанд олон улсын эрх зүйн хэм хэмжээг ямар нөхцөлд хэрэглэх вэ? Түүний учир шалтгаан, ач холбогдлыг хэрхэн үнэлж байна вэ?
3. Гэр бүлийн болон иргэний хуулийн харилцан хамаарлыг тодорхойлно уу? Гэр бүлийн тухай хуульд иргэний хуулийг хэрэглэх талаар шууд заасан заалтуудыг тодорхойлон гаргана уу? Түүний учир шалтгааныг тайлбарлана уу? Уг хуульд шууд заасан заалт байхгүй нөхцөлд Иргэний хуулийн заалтыг хэрэглэж болох уу?
4. Гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлогын шинэчлэлт, цаашдын чиг хандлагыг жишээгээр тайлбарлаж, энэ талаарх төрийн үндсэн чиг үүрэгт ямар өөрчлөлтүүд ажиглагдаж байгааг тодорхойлно уу?
5. Гэр бүлийн түүхэн хэв маягууд, тэдгээрийн онцлог шинжийг тодорхойлно уу?



**Сорил**

1. **Гэр бүлийн тухай хууль тогтоомж нь:**
  - a. Монгол Улсын Үндсэн хууль түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас бүрдэнэ
  - b. Иргэний болон гэр бүлийн хууль түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.
  - c. Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.
  - d. Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
2. **Гэр бүлийн ашиг сонирхолыг хамгаалах эрх бүхий этгээдүүдийг нэрлэнэ үү?**
  - a. Гэр бүлийн гишүүд өөрсдөө хамгаална.
  - b. Гэрлэлтийг бүртгэсэн тухай байгууллага хамгаална
  - c. Гэр бүлийн ашиг сонирхолыг төр хамгаална.
  - d. Гэр бүлийн ашиг сонирхолыг шүүх хамгаална.
3. **Гэр бүл гэдэг нь**
  - a. Хамтран амьдрагч болон түүнтэй хамт амьдарч буй эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон гэр бүлийн гишүүдийг
  - b. Ураг төрлийн холбоо бүхий эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хүмүүсийг
  - c. Эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг
  - d. Гэрлэлтийн үр дүнд буй болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ.



### Даалгавар:

1. Гэр бүлийн эрх зүйн харилцааны хүрээнд түүнтэй холбогдох Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн заалт нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хуулиудад хэрхэн тусгагдаж, хэрэгжиж байгаад дүн шинжилгээ хийж дүгнэлтээ гаргана уу?
2. Олон улсын гэрээ конвенц болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн холбогдох заалтыг иш татаж гэр бүлийн эрх зүйн зарчмуудын агуулгыг тодорхойлж бичнэ үү?



### Эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль	1992 он
2. Гэр бүлийн тухай хууль	1999 он
3. Иргэний хууль	/1926,1952,1963,1994, 2002 он/
4. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль	1996 он
5. Иргэний бүртгэлийн тухай хууль	1996 он
6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	2002 он
7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	2004 он
8. Монгол Улсын Олон Улсын гэрээ, Төрийн мэдээлэл тусгаар дугаар I боть	2004 он
9. Иргэний гэр бүлийг бүртгэх байгууллагын тухай хууль	1950 он
10. БНМАУ-ын гэрлэх ба гэр бүл, асрамж тэтгэмжийн тухай хууль	1956 он
11. Гэр бүлийн тухай хууль	1973 он
12. Иргэний хуулийн тайлбар	2005 он
13. Хууль зүйн нэр томъёоны дагалга	2004 он
14. Т.Мөнхжаргал Гэр бүлийн эрх зүй	1995 он
15. Ц. Алтанцэцэг Иргэн, бизнесийн эрх зүйн гарын авлага 114-120х	2006 он
16. А.Дугармаа Гэр бүлийн эрх зүй	2005 он
17. Д.Тунгалаг Гэр бүлийн ёс суртахуун	2000 он
18. А.Дугармаа Гэр бүлийн хууль тогтоомжийн түүхэн хөгжил, /Хууль дээдлэх ёс/	2003 он
19. Л.Пчелинцева Семейное право России	2001 г
20. Семейное законодательство	2003 г
21. Комментарий к Семейному кодексу Российской Федерации 19-39 х	2003 г

## ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ, ЭЛЕМЕНТ

### Сэдвийн агуулга

Гэр бүлийн эрх зүйн харилцааны ойлголт, үндсэн шинж, ангилал  
Гэр бүлийн эрх зүйн харилцааны элемент  
Гэр бүлийн эрх зүйн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох хууль зүйн факт  
Ураг төрөл хэмээх ойлголтын хууль зүйн учир холбогдол

### Сэдвийн зорилго

Гэр бүлийн эрх зүйн харилцааны үндсэн асуудлын талаар онолын мэдлэгтэй болж улмаар гэр бүлийн эрх зүйн харилцаа, түүний субъектын онцлогийг танин мэдэх, гэр бүлийн хүрээнд үүсч байгаа харилцаанд анализ хийж, эрх зүйн зохицуулалтын асуудлыг тодорхойлон түүний учир холбогдлыг тайлбарлаж, дүгнэлт хийх, бусад эрх зүйн харилцаанаас ялгаж тодорхойлох чадварыг эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Гэр бүлийн харилцаа** - Гэр бүлийн хүрээнд үүссэн зан зашил, ёс суртахууны болон эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж, зөвшөөрөгдөж, хамгаалагдаж байгаа нийгмийн харилцааг хэлнэ

**Гэр бүлийн эрх зүйн харилцаа** - Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцаа. Тодруулвал: Гэрлэлт, гэр бүлд хамаарал бүхий хууль зүйн фактаас үүдэлтэй гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж, гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн хооронд үүссэн эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцааг хэлнэ

**Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъект** - Гэр бүлийн эрх зүйн харилцаанд оролцож субьектив эрх эдэлж, хууль зүйн үүрэг хүлээж байгаа эрх зүйн этгээдийг хэлнэ

**Гэрлэгчид** - Гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг хэлнэ.

**Гэр бүлийн гишүүд** - Гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг хэлнэ

**Ураг** - Худ худгуйн хамаатан овгийн хүмүүсийг (эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин тэдгээрийн хүүхдийг) хэлнэ.

**Төрөл /төрлийн хүн/** - Гэрлэгчийн эцэг эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг хэлнэ.

**Садан /садангийн хүн/** - Ураг төрлийн хажуугийн / баруун, зүүн гар/ хүмүүс буюу гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг хэлнэ.

**Гэр бүлийн эрх зүйн харилцааны объект**- Гэр бүлийн эрх зүйн харилцаанд оролцогчдын зан үйлийн хандлага чиглэгдэж байгаа зүйлийг хэлнэ

**Гэр бүлийн эрх зүйн харилцааны агуулга** - Гэр бүлийн эрх зүйн харилцаанд оролцогчдын эдаах эрх, хүлээх үүрэг хариуцпагын нэгддийг хэлнэ.

**Гэр бүлийн эрх зүйн хууль зүйн факт**- Гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээний дагуу гэр бүлийн харилцаа үүсэх, өөрчлөгдөх дуусгавар болох эрх зүйн үр дагаварт хүргэж байгаа амьдралын тодорхой нөхцөл байдлыг хэлнэ.



### Гэр бүлийн эрх зүйн харилцааны ойлголт, мөн чанар

Гэр бүлийн эрх зүйн харилцаа нь эрх зүйн харилцааны нэгэн төрөл юм. Гэр бүлийн хүрээнд олон талт харилцаа үүсдэг. Тэр бүр нь эрх зүйн харилцаа болохгүй.

Гэр бүлийн хүрээнд үүсэх бүхий л харилцааг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах боломжгүй.



**Гэр бүлийн эрх зүйн харилцааны онцлог: Энэ нь дараах байдлаар илэрнэ. Үүнд:**

1. "Гэрлэлт", "Гэр бүл", хэмээх ойлголтын мөн чанартай салшгүй холбоотойтулэдгээр ойлголтын мөн чанарыг тодорхойлох шаардлагатай. Түүний мөн чанар нь тухайн ойлголтын хууль зүйн агуулгаар тодорхойлогдоно.

Гэрлэлт	Гэр бүл
<ul style="list-style-type: none"> <li>• Моногами дээр үндэслэсэн нөхөр, эхнэрийн холбоо /иргэний эрх зүйн гэрээ хэлцэл биш/</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэрлэлтийн үр дүнд үүснэ</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>• Чөлөөтэй сайн дурын хүсэл зоригийг илэрхийлэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон гэр бүлийн гишүүдийг бүрдүүлэх</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>• Тэгш эрхийн үндсэн дээр байгуулагдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хамтын амьдрал үүсэх</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>• Насан туршийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэр бүлийн нэгдмэл хэрэгцээ, ашиг сонирхол бий болох</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>• Гэр бүлийг үүсгэн үр удмаа бий болгож, асран хүмүүжүүлж, бие биеэ халамжлах, хамтын амьдралыг үүсгэх зорилготой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэр бүлийн гишүүд нь харилцан бие биенээ тэжээн тэтгэх</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэр бүлийн хөрөнгө болох хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бий болох</li> </ul>

2. Гэр бүлийн эрх зүйн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох хууль зүйн фактын хувьд онцлогтой:



3. Субъектийн хувьд онцлогтой. Гэрлэлт, төрлийн холбоо бүхий хүмүүсийн нэгдэл юм. Тухайлбал гэрлэгчид, эцэг эх, хүүхэд, төрөл садангийн хүн байна.
4. Гэр бүлийн эрх зүйн харилцааны мөн чанар, түүний онцлогийг илэрхийлнэ. Эд хөрөнгийн бус амины харилцаа нэн тэргүүнд үүсч түүнтэй уялдаж эд хөрөнгийн харилцаа үүснэ. Эд хөрөнгийн харилцаа нь үүсмэл шинжтэй, хариу төлбөргүй. Гэр бүлийн эрх зүйн харилцаа нь үргэлжилсэн, нийлмэл шинжийг илэрхийлнэ. Гэр бүлийн хүрээнд үүсэх эрх зүйн ихэнх харилцаа нь захиргааны эрх зүйн хэм хэмжээний зохицуулалттай холбоотойгоор эрх зүйн үр дагаварыг бий болгоно. Жишээ нь: Сум дүүргийн Засаг дарга асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоох, иргэний гэр бүлийн байдлын бүртгэл хөтлөх гэх мэт.


### **Гэр бүлийн эрх зүйн харилцааны ангилал**

Энэ нь онолын төдийгүй практик ач холбогдолтой

- Субъектын бүтцийг тодорхойлох
- Субъектын эрх, үүргийг зөв тодорхойлох
- Эрх зүйн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох үйл явцад эрх зүйн хэм хэмжээг зөв тогтоох, хэрэглэх нөхцлийг бүрдүүлнэ.



**Гэр бүлийн эрх зүйн харилцааны элемент-** Энэ нь тухайн харилцааны “ субъект”, “объект”, “агуулга”-ын нэгдэл юм



**Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъект**

<p style="text-align: center;"><b>Иргэн</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын иргэн</li> <li>- Гадаад Улсын иргэн</li> <li>- Харьяалалгүй хүн</li> </ul>	<p>"Оноосон" нэрээр</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрлэгчид</li> <li>- Эцэг эх, хүүхэд</li> <li>- Үрчлэгч, үрчлүүлэгч</li> <li>- Асран хамгаалагч, хамгаалуулагч</li> <li>- Харгалзан дэмжигч, дэмжүүлэгч</li> <li>- Төрөл садан</li> </ul>
--	-------------------------	--

Гэр бүлийн эрх зүйн харилцаанд оролцож эрх эдэлж, үүрэг хүлээх субъектын тухай ойлголт нь “Субъект байх чадвар”-ыг агуулна. Субъектын эрх буюу субъект байх чадвар нь төрийн зүгээс баталгаажсан байна.

*Монгол Улсын Үндсэн хууль /14§ /*

“Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.”

*Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт /16§ /*

“Хүн бүр хаана ч эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй”

Эрх зүйн чадварыг Монгол Улсын иргэд тэгш эдэлнэ гэж ойлгоно.

Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэр бүлийн харилцаанд Монгол улсын иргэнтэй адил тэгш эрх эдэлж үүрэг хүлээнэ. Иргэний эрхийн чадварыг хуулиас гадуур ямар ч тохиолдолд хязгаарлахыг хориглоно. Хэн нэгэн этгээд өөрийн үйлдлээрээ бусдын эрх зүйн чадварыг хязгаарлаж болохгүй. Эрх зүйн эрхийн чадамж нь тухайн бодгаль этгээд өөрийн ухамсартай үйлддээр өөртөө эрх олж авах, хууль зүйн үүрэг бий болгох, хариуцлага хүлээх чадвар юм. Энэ нь тухайн бодгаль этгээдийн нас, сэтгэцийн үйл явцтай хамааралтай.

- Бүрэн чадамж
- Бүрэн бус чадамж
- Зарим чадамж
- Хязгаарлагдмал чадамж
- Эрх зүйн чадамжгүй иргэн

**Ураг төрөл хэмээх ойлголтын хууль зүйн учир холбогдол**

Ураг бол садан төрлийн холбооны анхдагч үүсгэвэрийн нэг юм. Худ худгүй бололцохгүйгээр ургийн ёс байж үл болохыг илэрхийлсэн садан сүлбээний шүтэлцээ нь ургаас үүсвэртэй.

**Ураг төрлийн мөн чанар**

*“... Энэ бол утга учиргүй жирийн нэр биш харин яс махан төрлийг хол, ойр адил ондоогоор нь авч үзэх явдал юм. Эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүүс гэдэг үг бол зөвхөн ямар нэгэн хүндэтгэлд хэрэглэх нэрүүд биш бөгөөд эдгээр нэр бол харилцан бие биенийхээ өмнө хүлээсэн тодорхой эрх, үүргүүдийг илэрхийлнэ.”*

*“Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл” түүвэр зохиолын III боть*

**Ураг төрлийн нэрс тодорхой чиглэлээр ангилагддаг.**

- Эцгийн шугам баримталсан /ясан төрөл/
- Эхийн шугам баримталсан /цусан төрөл/
- Худ, худгуйн ёсонд шүтэлцсэн тал

**ТӨРӨЛ** - Нэг этгээд нөгөөгөөсөө буюу тэдгээрийн нийтлэг удмаас гаралтай цусан төрлийн холбоо бүхий хүмүүс юм.



- Шууд төрөл - Нэг нь нөгөөгөөсөө гаралтай
- Шууд бус төрөл - Нийтлэг удмаас гаралтай
- Бүрэн төрөл - Нэг эцэг эхээс гаралтай
- Бүрэн бус төрөл - Эх нэгтэй эцэг өөр, эцэг нэгтэй эх өөр

**Төрлийн хэлхээ нь:**

- Дээшээ өгсөх /эцэг,өвөг, элэнц, хуланц, өндөр өвөг/
- Доошоо уруудах /хүү, ач, жич, гуч, /дөч/ жих, зээ, бүл зээ, зээнцэр, бүлэнцэр/

**Төрлийн хэлхээ үеийг Ойр, аглаг гэж 2 хуваана.**

- Ойр нь сунжираагүйг / 5 үе хүртэлх/ хэлнэ.
  - Аглаг нь сунжирсанг /5 үеэс цааш/ хэлнэ.
- Есөн үеийн дотор цус ойртохоос сэрэмжилж ураг болохыг цээрлэнэ.

**Хууль зүйн факт болохын хувьд тодорхой эрх зүйн үр дагаврыг бий болгоно.**



**Хяналтын асуулт:**

1. О.С.Иоффе, Г.Ф.Шершеневич, В.А.Умов, К.Победоносцев, К.Ю.Кавелин, Е.М. Ворожейкин, А.И Загровский нар гэр бүлийн эрх зүйн харилцааны талаар ямар үзэл баримтлалуудыг дэвшүүлсэн бэ?
2. Гэр бүлийн эрх зүйн харилцааны элементүүдийг иргэний эрх зүйтэй харьцуулвал ямар онцлог ялгаатай вэ?
3. Гэр бүлийн эрх зүйн харилцаа үүсэх, өөрчлөгдөх дуусгавар болох хууль зүйн фактын онцлогийг тодорхойлно уу?

4. Гэр бүлийн болон бусад хууль тогтоомжид “төрөл садан” хэмээх ойлголтыг хэрэглэх болсон учир шалтгааныг тайлбарла. “Ураг төрөл” хэмээх ойлголтоор илэрхийлж болох уу?
5. Танай гэр бүлийнхэн угийн бичиг хөтөлдөг үү? Хэрэв угийн бичигтэй бол ямар арга, хэлбэрээр, хэдэн үеийг хамруулан бичсэнээ тайлбарлана уу?
6. Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол нь юу вэ?



### Сорил

1. **Аль нь гэр бүлийн эрх зүйн харилцааг үүсгэх хууль зүйн факт болох вэ?**
  - a. *Хамтран амьдрах*
  - b. *Хүүхэдтэй болох*
  - c. *Гэрлэлтээ бүртгүүлсэн*
  - d. *Хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргах*
2. **Дараах ойлголтод хамрагдах хүмүүсийг хуульд заасны дагуу тодорхойлно уу?**
  - A. *Төрлийн хүн*
    1. *Гэрлэгчийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ*
    2. *Гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү тэдгээрийн хүүхдийг*
  - B. *Садангийн хүн*
    1. *Гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг*
    2. *Гэрлэгчийн төрсөн, ах, эгч, дүү*
3. **“Овог” гэж**
  - a. *Эцгийн нэр*
  - b. *Эцгийн талын бүлэг хүмүүсийн дунд хэрэглэгддэг нэр*
  - c. *Эхийн талын бүлэг хүмүүсийн дунд хэрэглэгддэг нэр*
  - d. *Нэг өвөг дээдсээс гаралтай эцгийн талын холбоо бүхий бүлэг хүмүүсийн дунд уламжлан хэрэглэгддэг нэр*
4. **Гэр бүлийн гишүүн гэдэг нь**
  - a. *Гэрлэгчид тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн хүүхэд*
  - b. *Хамтын амьдралтай байгаа бух хүмүүсийг*
  - c. *Гэрлэгчид тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл садангийн хүнийг*
  - d. *Гэрлэгчид тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд*
5. **Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъект нь**
  - a. *Эрх зүйн бүрэн чадамжтай этгээд*
  - b. *Эрх зүйн бүрэн бус, зарим чадамжтай болон эрх зүйн чадамжгүй этгээд*
  - c. *Эрх зүйн бүрэн, бүрэн бус, зарим чадамжтай болон хязгаарлагдмал чадамжтай, чадамжгүй этгээд*
  - d. *Эрх зүйн хязгаарлагдмал болон бүрэн бус чадамжтай этгээдүүд байна*



6. **Аль нь гэр бүлийн эрх зүйн харилцаа дуусгавар болох үндэслэл болохгүй вэ?**
  - a. Гэрлэгч нас барсан
  - b. Тэтгүүлэгч гэрлэсэн
  - c. Гэрлэгчид тусдаа амьдарсан
  - d. Үрчлэлтийг хүчингүйд тооцсон
7. **Гэр бүлийн эрх зүйн бүрэн бус чадамжтай этгээд нь**
  - a. Асран хатгаалалт тогтоогдсон этгээд
  - b. Насанд хүрээгүй буюу 14-18 хүртлэх насны этгээд
  - c. 7-14 хүртлэх насны этгээд
  - d. Бага насны буюу 14 хүртлэх насны этгээд
8. **Насанд хүрээгүй буюу 16 настай Б нь гэр бүл болох зорилгоор Г-тэй хамтран амьдарч хүүхэд төрүүлсэн байна. Энэ тохиолдолд**
  - a. Хамтран амьдарч хүүхэд төрүүлсэн учир гэрлэлтийн харилцааны субъект болно.
  - b. Эцэг, эхийн хүсэлтээр гэрлэлтийн харилцааны субъект болж болно.
  - c. 16-18 нас хүртлэх иргэнийг шүүхээс иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцсон нөхцөлд субъект болно
  - d. Насанд хүрээгүй тул гэрлэлтийн харилцааны субъект болохгүй



### Даалгавар:

1. Та өөрийн гэр бүлийнхээ угийн бичгийг хөтөлж нэгдүгээр схем зураглалыг ашиглан таны төрөл садангууд ямар шугамаар холбогдсон тэдгээрийн хоорондын төрлийн зэргийг тодорхойлно уу? Ясан болон цусан төрөлд мөн өөрийн өмнөх, хойтох үед хэн хэнийг хамаатуулж тэдгээрийн төрлийн нэрсийг юу гэж хэлдэг вэ?
2. Таны элэнц, хуланц, өвөг болон ач, жич, гуч, авга, нагац гэж хэнийг хэлэх вэ?



### Эх сурвалж:

- |   |         |
|---|---------|
| 1. Монгол Улсын Үндсэн хууль                                      | 1992 он |
| 2. Гэр бүлийн тухай хууль   | 1999 он |
| 3. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль                          | 1996 он |
| 4. Иргэний бүртгэлийн тухай хууль                                 | 1996 он |
| 5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль              | 2002 он |
| 6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль                   | 2004 он |
| 7. Иргэний хуулийн тайлбар  | 2005 он |
| 8. Т.Мөнхжаргал Гэр бүлийн эрх зүй                                | 1995 он |
| 9. Ц. Алтанцэцэг Иргэн, бизнесийн эрх зүйн гарын авлага 114-120 х | 2006 он |
| 10. А.Дугармаа Гэр бүлийн эрх зүй                                 | 2005 он |
| 11. Л.Пчелинцева Семейное право России                            | 2001 г  |
| 12. Семейное законодательство                                     | 2003 г  |
| 13. Комментарий к Семейному кодексу Российской Федерации 19-39 с  | 2003 г  |

Нэгдүгээр схем зураглал





## ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖИЙГ ТОДОРХОЙЛОХ

### Сэдвийн агуулга

Гэр бүлийн эрх зүйн эх сурвалжийн тухай ойлголт, ангилал

Гэр бүлийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, хөгжил

Гэр бүлийн болон иргэний хууль тогтоомжийн харилцан хамаарал

### Сэдвийн зорилго

Гэр бүлийн эрх зүйн эх сурвалжийн талаар мэдлэгтэй болж холбогдох эх сурвалжуудыг тодорхойлж, түүнийг танин мэдсэнээр гэр бүлийн эрх зүйн харилцаанд тухайн эх сурвалжийг ашиглаж сурах чадварыг эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Гэр бүлийн эрх зүйн эх сурвалж** - гэдэг нь гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулж байгаа хэм хэмжээний илрэх гадаад хэлбэр юм.

Гэр бүлийн эрх зүй нь өөрийн гэсэн хууль тогтоомжтой. Гэр бүлийн эрх зүйн эх сурвалжид:

### 1. Үндсэн хууль

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудын дотор 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль нь гол эх сурвалжид хамаарна. Гэр бүлийн харилцааг зохицуулахад иргэдийн эрх, эрх чөлөөг тогтоосон Үндсэн хуулийн хэм хэмжээ онцгой ач холбогдолтой. Монгол Улсын Үндсэн хуульд улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална гэсэн нь гэрлэлтийн харилцааны үндсэн зарчим, гэрлэсний дараа бий болох эрх зүйн үр дагавар, гэр бүлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын үндсийг нарийвчлан тогтоосноороо гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын эх сурвалж болно.

### 2. Ердийн хуулиуд.

**Гэр бүлийн тухай хууль** нь гэр бүлийн эрх зүйн гол эх сурвалжид багтана. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль нь гэрлэх, гэрлэлтийн харилцаа дуусгавар болох, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон гэр бүлийн эрх зүйн үндсэн гол харилцааг зохицуулна. УИХ-аас 1999 оны 6 дугаар сард одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хуулийг баглан гаргасан бөгөөд тус хууль нь 9 бүлэг, 76 зүйлтэй.

**Монгол Улсын Иргэний хууль** нь гэр бүлийн эрх зүйн эх сурвалж болно. Гэр бүлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д зааснаар Иргэний хууль нь гэр бүлийн тухай хууль тогтоомжид багтана. Гэр бүлийн эрх зүй дэх гэр бүлийн эд хөрөнгийн харилцаа, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос үүссэн эд хөрөнгийн маргаан, гэрлэгчийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд хохирол гаргуулах, тэжээн тэтгэх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон нилээд олон төрлийн харилцааг Иргэний хуулиар зохицуулдаг учраас эх сурвалжид багтаан авч үзнэ.

**Иргэний бүртгэлийн тухай хууль (1999)** нь Гэр бүлийн эрх зүйн хууль тогтоомжид хамаарна. Уг хуульд гэр бүлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор гэр бүлийн эрх зүйн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болгоход чиглэгдсэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002 он)** нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, иргэний хэрэг үүсгэх, анхан шатны болон давж заалдах, хяналтын шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байдаг. Гэр бүлийн тухай хуульд зааснаар гэр бүлийн харилцаанаас үүдэлтэй шүүхийн журмаар гэрлэлт цуцлах, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, хүүхдэд нэр, овог өгөх, хүүхэд эцэг, эхийн нэр авахтай холбогдсон маргаан, хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарлах ба хасах, сэргээх, хүүхдийг хууль бусаар авсан хүнээс хүүхдээ эргүүлж авахыг шаардах, тэжээн тэтгэх гэрээг өөрчлөх, цуцлахтай холбогдсон маргаан, хүүхэд үрчлэлтийг болон асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосныг хүчингүйд тооцох зэрэг маргааныг шүүх шийдвэрлэж, гэр бүлийн эрхийг хамгаалахдаа ИХШХШ тухай хуулийг дагаж мөрдөнө.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.** Уг хуулийг УИХ-аас 2002 онд батлан гаргаж, одоо мөрдөж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулж байгаа нэг гол харилцаа нь шүүхээс гаргасан буюу түүнээс баталгаажуулсан шийдвэрийг албадан биелүүлэхтэй холбогдсон харилцаа юм. Уг хуульд хүүхдийн тэтгэлэг албадан гаргуулах журам, асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байх хүнийг шилжүүлэхтэй холбогдсон зэрэг олон асуудлыг тусгаж өгсөн юм.

**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.** УИХ-аас 2004 онд баталж, 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн гишүүд, төрөл, садангийн хүн, хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсний, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон тэдний асрамжинд байгаа хүмүүсийн хүрээнд нэг нь нөгөөгийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, учруулахаар заналхийлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэлд хариуцлага хүлээлгэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон нийгмийн харилцааг зохицуулж байна.

**Олон улсын гэрээ, түүнтэй адилтгах баримт бичгүүд эх сурвалж болох нь.** Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын Олон Улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Гэр бүлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т: “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” хэмээн тусгасан нь олон улсын гэрээ нь, гэр бүлийн хууль тогтоомжийн салшгүй нэгээхэн хэсэг мөн гэдгийг тодотгож байна. “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, “Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай” олон улсын пакт”, “Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай” болон “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай”, “Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай” конвенциудыг сэдвийн хүрээнд судлах шаардлагатай.



### Хяналтын асуулт:

1. Гэр бүлийн эрх зүйн харилцаанд хууль, хуульчилсан акт, олон улсын гэрээг ямар нөхцөлд эх сурвалж болох талаар жишээн дээр тайлбарлана уу.
2. Монголын эртний хууль цаазын сурвалж бичгүүд нь гэр бүлийн харилцааг хэрхэн зохицуулж байсан бэ?
3. Их засаг хуульд тусгагдсан гэр бүлийн харилцааны зохицуулалтын онцлогийг тайлбарлана уу.
4. 1926, 1950, 1956 оны хуулиудад тусгагдсан гэр бүлийн харилцааны зарчмуудыг тодорхойлно уу.
5. 1999 онд батлагдсан гэр бүлийн хуулийг 1973 оны хуультай харьцуулж түүний зохицуулалтын онцлогийг тодорхойлно уу.
6. Гэр бүлийн тухай хуулийн заалтыг иш татаж, хуулийн тайлбарыг бичиж түүний ач холбогдлыг тайлбарлана уу.



### Сорил

1. **Монгол улсын иргэн гадаадын иргэнтэй гадаад улсад гэрлэсэн бол тэдгээрийн эрх, үүргийг аль улсын хуулиар тодорхойлох вэ?**
  - a. Монгол улсын хуулиар
  - b. Гэрлэлтийг бүртгүүлсэн улсын хуулиар
  - c. Гэрлэгчдийн сонгосон улсын хуулиар
  - d. Гэрлэгчдийн амьдарч байгаа улсын хуулиар
2. **Монголын эртний хууль цаазын ямар сурвалж бичигт олон эхнэртэй байх, эхнэр авахын тулд заавал сүй тавьж авдаг зохицуулалт байсан бэ?**
  - a. Монгол-Ойрдын цааз бичиг
  - b. Халх журам
  - c. Их засаг
  - d. Монгол цаазын бичиг
3. **Хүүхдийн тоо, хүүхэд төрүүлэх зайг чөлөөтэй бөгөөд хариуцлагатай шийдвэрлэх, эдгээр эрхийг хэрэгжүүлэх боломж олгох мэдээлэл, боловсрол, аргыг олж авах эрхийн талаар олон улсын ямар конвенцид зааж өгсөн байдаг вэ?**
  - a. Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн конвенц
  - b. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
  - c. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай
  - d. Хүүхдийн эрхийн тухай конвенц
4. **Инж сүйгээр илэрхийлэгдсэн эд хөрөнгө гэрлэх хэмжүүр болдог байсан талаар ямар эх сурвалжид тодорхой заасан байсан бэ?**
  - a. Хаях журам
  - b. Монгол цаазын бичиг
  - c. Их засаг
  - d. Монгол -Ойрдын хууль

5. Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг ямар эх сурвалжаар зохицуулж байна вэ?

- Иргэний хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Дээр дурьдсан хуулиудын аль аль нь зохицуулна
- a, b, c-д заасан бүх хариулт зөв



### Бодлого

1. 2000 онд Монгол Улсын иргэн, эмэгтэй Оргио Япон улсын иргэн Томио Акиёошид холбогдох хүүхдийн эцгээр тогтоолгох, хүүхдийн тэтгэвэр гаргуулах хүсэлтийг Налайх дүүргийн шүүхэд гаргасан байна. Энэ хэргийг хянан шийдвэрлэхэд Япон улсын хуулийг хэрэглэх байсан эсэхэд шүүх ямар нэгэн анхаарал хандуулаагүй ба нэхэмжлэгчээс гаргасан “хүүхдийн тэтгэврээ нэг удаа бөөнд нь авна” гэсэн шаардлагыг ч шийдвэрлэлгүй орхисон байна.

Энэ тохиолдолд:

- Шүүх Оргиогийн нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ аль улсын ямар эх сурвалжийг хэрэглэх вэ?
- Шүүх хүүхдэд ашигтай хуулийг сонгож хэрэглэх боломжтой байсан эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- Монгол улсад байнга оршин суудаггүй, Япон улсын харьяат иргэний харьяалсан улсын хуулиар хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тодорхойлж болох уу?

Бодлого

1. Вьетнам улсын иргэн Хо Ши Ми 1999 онд БНСУ-ын иргэн Им Жон Вутай Сеул хотод гэрлэлтээ бүртгүүлжээ. Хо Ши Ми нь нөхөр Им Жон Вутай гэрлэлтээ бүртгүүлснээс хойш 3 жилийн хугацаанд хамт амьдрахдаа хүү Жонг төрүүлсэн. Хо Ши Ми Монгол улсад байнга амьдран суудаг ба Солонгост амьдарч байгаа нөхөр Им Жон Вугаас гэрлэлтээ цуцлуулах, хүүдээ тэтгэлэг тогтоолгохоор өөрийн оршин суугаа газрын харьяа Баянгол дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Энэ тохиолдолд:

- Шүүх нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийг хэрэглэж болох уу?
- Шүүхээр маргааныг шийдвэрлэх үед Монгол улсад байнга оршин сууж байсан гадаадын иргэн өөрийн эх орондоо буцсан үед хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тухайн иргэний харьяалж байгаа улсын хуулийн дагуу тогтоолгох боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?



### Даалгавар:

Сэдвийн тоймд дурьдагдсан ердийн хуулиуд болон олон улсын гэрээ конвенциудыг нарийвчлан судалж, гэр бүлийн эрх зүйн эх сурвалж болох талаар өөрсдийн санал, дүгнэлтийг гаргана уу?



### Эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Хүүхдийн эрхийн тухай конвенци
3. “Төрийн мэдээлэл”, Тусгай дугаар 1 дүгээр боть /х-94/ 2004 он
4. Иргэний хуулиуд (1926,1952,1963,1994, 2002), 2002 он
5. Монгол Улсын Иргэний хууль 2002 он
6. Иргэний гэр бүлийг бүртгэх байгууллагын тухай хууль, 1950 он
7. БНМАУ-ын гэрлэх ба гэр бүл, асрамж, тэтгэмжийн тухай хууль 1956 он
8. Гэр бүлийн тухай хууль 1973,1999 он
9. Иргэний бүртгэлийн тухай хууль 1999 он
10. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
11. Улсын Дээд шүүхийн 71 дүгээр тогтоол
12. С. Жалан-Аажав Халх журам бол Монголын хууль цаазын эртний дурсгалт бичиг юм 1958 он
13. Б. Баярсайхан Монгол цаазын бичиг 2001 он

## 2 БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

### ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ СУБЪЕКТҮҮДЭЭС ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

#### Сэдвийн агуулга

Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдээс эрхээ хэрэгжүүлэх тухай ойлголт, зарчим, журам

Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдээс эрхээ хэрэгжүүлэх боломж, түүний хүрээ, хязгаар

#### Сэдвийн зорилго

Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдээс хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх йлголтын үндсэн асуудлын талаар онолын мэдлэгтэй болох, эрх зөрчигдөөхөөс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, эрхээ хэрэгжүүлээгүйгээс гарах үр дагаврыг хууль зүйн үүднээс тайлбарлах, холбогдох хуулийн заалтыг сонгон хэрэглэх чадварыг эзэмшинэ.



#### Нэр томъёоны тайлбар

**Гэр бүлийн эрх зүйн харилцаанд эрх, үүргийг хэрэгжүүлэх** – Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдээс хуулиар олгогдсон субъектив эрхээ эдэлж, хууль зүйн үүргээ биелүүлэх замаар тэдний зан үйл хуульд нийцэж бодит биелэлээ олох үйл явц түүний үр дүнг хэлнэ.

**Эрх, үүргийг хэрэгжүүлэх хүрээ, хязгаар** – Хууль зүйн хүрээнд бусдын эрх ашиг сонирхолд нийцүүлэн субъектив эрх, хууль зүйн үүргээ хэрэгжүүлэх зан үйлийн хэмжүүр юм.

#### Гэр бүлийн харилцаанд эрх, үүргийг хэрэгжүүлэх

Гэр бүлийн эрх зүйн харилцаа нь харилцан бие биенийхээ өмнө эрх эдэлж, үүрэг хүлээсэн гэрлэлт, төрлийн холбоо бүхий гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа байдаг. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар тус улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх бөгөөд үүний нэгэн адил гэр бүлийн эрх зүйн харилцаанд оролцогчид нь адил тэгш эрх эдэлнэ.

Иргэний эдлэх эрх, хүлээх үүргийг хуулиар хүлээн зөвшөөрч тогтоодог.

Төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. Гэр бүлийн эрхийг хэрэгжүүлэх тухай ойлголт нь уг эрх зүйн харилцааны субъект, тэдгээрийн субъектив эрх, хууль зүйн үүргийг илэрхийлдэг.

#### Субъект байх чадвар

- Хуулиар зөвшөөрсөн болон олгосон боломжийг эдлэх субъектийн идэвхтэй зан үйл
- Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг бусдаас шаардах эрх
- Эрх зөрчигдсөн нөхцөлд хууль зүйн боломжоо хамгаалуулах



### Субъектив эрх илрэх хэлбэр

#### Хууль зүйн боломж

- Эрхээ хэрэгжүүлэх субъектын идэвхтэй үйлдэл
- Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг бусдаас шаардах эрх
- Эрх зөрчигдсөн үед хамгаалуулахын тулд эрх бүхий байгууллагад хандах эрх

#### Хууль зүйн үүрэг

- Үүргээ хэрэгжүүлэх идэвхтэй үйлдэл
- Эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх үйлдэл
- Үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг арилгах

### Монгол Улсын Үндсэн хууль / 14§ /

*“Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”*

### Гэр бүлийн тухай хууль / 9§ /

*Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харъяалалгүй хүн гэр бүлийн харилцаанд Монгол Улсын иргэнтэй адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ.*

### Гэр бүлийн тухай хууль /10§ /

*Гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.*

*“Таны юу хийх, надаас хамааралтай байх хэлхээ холбоо бол үүрэг мөн”*

*/Гая Дигест/*




- Гэр бүлээ төлөвлөх
- Оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох
- Хуваарьт эд хөрөнгөтэй байх
- Дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө эзэмших, ашиглах захиран зарцуулах
- Материалын болон сэтгэл санааны хохиролоо буруутай этгээдээс гаргуулах

- Бие биедээ үнэнч байх
- Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх
- Бие биеэ халамжлан хүндэтгэх
- Тэжээн тэтгэх, туслах
- Гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх
- Хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй байх
- Бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх
- Угийн бичиг хөтлөх

### Субъектив эрхээ хэрэгжүүлэх зарчим

- Хууль ёсны байх
- Шударга, хүнлэг ёсыг эрхэмлэх
- Хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах



Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдээс хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх эсэх нь эдний хүсэл зоригийн дагуу сайн дураар чөлөөтэй эдлэх шинжийг агуулдаг. Энэхүү эрхийг субъектүүдийн хүсэл зоригийн хэмжээ хязгааргүй чөлөөт байдал хэмээн ойлгож болохгүй.

Иймээс хууль тогтоомжинд заасан хүрээ хязгаарын дотор эрх, үүргээ хэрэгжүүлэх шаардлагатай.

#### Монгол Улсын Үндсэн хууль / 19§ /

*“Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх дээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”*

**“Эрх чөлөөнд ямарваа хил, хязгаар үгүй бол түүнд үнэ цэнэ гэж үгүй ээ.”**

*/Ромын хуулиас/*

**“Хэмжээ хязгаар хамгийн яв цав тодорхойлогдож, хамгаалагдаж байгаа” тэр цагт, тэгэхдээ бусдын эрх чөлөөтэй хослон нийцэх тэрхүү хэмжээгээрээ тодорхойлогдож буй тэр үед тэрхүү эрх чөлөөг хангаж өгөх эрх зүйт иргэний нийгэмдэх түүхэн үүрэг зөвхөн эрх зүйд ноогдсон ажээ.”**

*/И.Кант/*



### Хяналтын асуулт:

1. Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдээс эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн шаардлагыг тодорхойлно уу?
2. Субъектив эрхээ бие даан хэрэгжүүлэх боломжгүй субъект гэдгийг хуульд хэрхэн тодорхойлсон бэ?
3. Гэр бүлийн тухай хуульд заасан субъектив эрхийг хязгаарлах үндэслэлийг жишээ татан хуулийн холбогдох заалтыг хэрэглэн тайлбарлана уу?
4. “Эрхээ хэтрүүлэх”, “эрхээ зүй бусаар эдлэх ” зэрэг ойлголтуудын хууль зүйн агуулгыг тодорхойлно уу?
5. Насанд хүрээгүй иргэн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр ямар эрхээ бие даан хэрэгжүүлж болох вэ?
6. Эцэг, эх хүүхдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална гэдгийг хуулийн холбогдох заалтыг иш татан тайлбарлана уу?



### Сорил

1. **Насанд хүрээгүй хүмүүс нь дараах эрхээ бие даан хэрэгжүүлнэ.**
  - a. Насанд хүрээгүй иргэний нэр дээр гуравдагч этгээдийн нээсэн хадгаламжийг захиран зарцуулна.
  - b. Гэр бүлийн гишүүнийхээ хувьд хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг захиран зарцуулах
  - c. Хөдөлмөрийн хөлс, тэтгэлгийг захиран зарцуулах
  - d. Өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, уралдаан тэмцээнээс авсан шагналыг захиран зарцуулна.
2. **Гэрлэлтийг дараах тохиолдолд цуцлахыг хориглоно.**
  - a. Эхнэр нь гэрлэлтээ цуцлуулахыг зөвшөөрөхгүй байгаа
  - b. Гэрлэгчдийн хэн нэгний эцэг, эх хүндээр өвчилсөн
  - c. Эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд 3 нас хүрээгүй
  - d. Эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд 1 нас хүрээгүй
3. **Дараах зохицуулалтын үндэслэлийг зөв тодорхойлно уу.**

A. Эцэг эх байх эрхийг хязгаарлах

  - a. Хүүхдээ орон гэрээсээ дайжуулсан
  - b. Эрх зүйн зөрчилд татан оруулсан

B. Эцэг, эх байх эрхийг хасах

  - a. Хүүхдийн хөдөлмөрийг зүй бусаар ашигласан
  - b. Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан
4. **Гэр бүлийн эрх зүйн харилцааны оролцогчдоос эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ баримтлах хууль ёсны зарчмыг**
  - a. Гэрлэгчдийн эрх, ашиг сонирхолд нийцсэн арга, хэрэгслийг ашиглан гэрээгээр тогтоосон журмын дагуу хэрэгжүүлэхийг
  - b. Эцэг, эхийн эрх, ашиг сонирхолд нийцсэн арга, хэрэгслийг ашиглан гэрээгээр тогтоосон журмын дагуу хэрэгжүүлэхийг
  - c. Хуульд нийцсэн арга, хэрэгслийг ашиглан тогтоосон журмын дагуу хэрэгжүүлэхийг
  - d. Шүүхээс тогтоосон арга, хэрэгслийг ашиглан тогтоосон журмын дагуу хэрэгжүүлэхийг ойлгоно.



### Бодлого

“Д”-гийн эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулжээ. Түүний эрх ашгийг хамгаалах үүднээс нийгмийн ажилтан, холбогдох байгууллагад хандсан байна.

1. Тэрээр ямар байгууллагад хандсан бэ?
2. Хүү “Д”-гийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий этгээдийг тодорхойлно уу?
3. Хүү “Д”-гийн ямар эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн вэ?



### Эх сурвалж:

- |  |          |
|--|----------|
| 1. Монгол Улсын Үндсэн хууль /2 дугаар бүлэг/  | 1992 он. |
| 2. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль   | 1999 он. |
| 3. Хүүхдийн эрхийн тухай конвенц “Төрийн мэдээлэл”<br>сэтгүүлийн тусгай дугаар I боть  | 2004 он  |
| 4. Монгол Улсын Иргэний хууль /2 дугаар бүлэг/   | 2002 он  |
| 5. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<br>/12 дугаар бүлэг/ | 2002 он  |
| 6. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль   | 1996 он  |



## ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫН ОЙЛГОЛТ, АРГА ХЭЛБЭР

### Сэдвийн агуулга

Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын ойлголт, ач холбогдол  
Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын арга хэлбэр  
Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэх субъект

### Сэдвийн зорилго

Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл, тэдгээрийн мөн чанарыг танин мэдэж, гэр бүлийн эрх зүйн хамгаалалтыг зөв хэрэгжүүлэх чадварыг эзэмшиж, хууль зүйн хүрээнд эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулах хандлага төлөвшинө.



### Нэр томъёоны тайлбар

**Гэр бүлийн эрх зүйн хамгаалалт** - Эрх зүйн арга хэрэгслэлийг ашиглан хуульд заасан үндэслэл, журмын дагуу хууль бус үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх эрх зүйн механизмыг хэлнэ

**Гэр бүлийн эрх зүйн хамгаалалт хийх эрх** - Эрх бүхий этгээд өөрийгөө болон бусад этгээдийг хамгаалах зорилгоор тодорхой үйлдэл хийх, төрийн болон эрх бүхий байгууллагаар дамжуулан эрх, ашиг сонирхолоо хамгаалуулах субъектив эрхийг хэлнэ

**Шүүхийн хамгаалалт** - Гэр бүлийн маргааныг шүүхийн журмаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэх ажиллагааг хэлнэ


**Шүүхийн бус хамгаалалт** - Гэр бүлийн маргааныг шүүхийн бус журмаар маргаж буй талуудыг харилцан зөвшилцөлд хүргэн шийдвэрлэх арга замыг хэлнэ

**Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын арга хэрэгсэл** - Гэр бүлийн эрх зүйн харилцааны субъектүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн гэр бүлийн болон бусад хуульд заасан эрх зүйн механизмыг хэлнэ

**Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын ойлголт, арга, хэлбэр** Гэр бүлийн эрх зүйн хамгаалалт нь зөрчигдсөн эрхийг сэргээх явдал бөгөөд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалуулах субъектив эрхийн хүрээнд эрх нь зөрчигдсөн этгээд болон бусад субъектын зүгээс хууль бус үйлдлийг таслан зогсоох, эрх зөрчигдөхөөс өмнөх байдлыг сэргээхэд оршино.

Хамгаалалт хийх эрхийн агуулга нь материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээгээр илрэх бөгөөд дараах асуудлыг хамруулан зохицуулна. Үүнд:

- Эрхээ хамгаалах арга, хэлбэрийг тогтоох
- Хамгаалалт хийх эрхийг хэрэгжүүлэх үндэслэлийг тогтоох
- Хамгаалалт хийх бүрэн эрх бүхий этгээдийн хүрээг тодорхойлох
- Хамгаалалтын аргыг хэрэглэх журмыг тогтоох
- Хамгаалалтын арга, хэрэгслийг хэрэгжүүлэх явцад үүсэх харилцаанд оролцогч субъектүүдийн эрхийг тодорхойлох





### Хамгаалалтын арга түүний төрөл

- Эрхийг хүлээн зөвшөөрөх
- Зөрчигдсөн эрхийг сэргээх
- Эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож зөрчигдсөн эрхийг хамгаалах зорилгоор тодорхой этгээдийн эрхийг хасах буюу хязгаарлах
- Үүргийг албадан биелүүлэх
- Эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгох
- Хуульд заасан бусад арга хэрэгсэл

Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын арга тус бүрт процессын тодорхой журам үйлчлэх ба хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий этгээдээс хамгаалалтын арга хэрэгслийг хэрэгжүүлнэ.

Гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхэд шүүхээс шаардлагатай гэж үзвэл урьдчилсан арга хэмжээг авна. Энэхүү арга хэмжээг авахдаа:

1. ИХШХШ тухай хуульд заасан үндэслэл, журмыг баримтална.
2. Эрх бүхий байгууллага болох шүүхээс хэрэгжүүлнэ
3. Хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Тухайлбал: ИХШХШ тухай хуульд зааснаар гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах, орон сууц болон өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох г.м



### Хяналтын асуулт:

1. Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэх үндэслэл шаардлага нь юу вэ?
2. Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын аргууд нь эрх зүйн бусад аргуудаас ямар онцлогтой вэ?
3. Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын арга, хэлбэрийг сонгон хэрэглэхэд юуг анхаарах вэ?
4. Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын арга, хэрэгслийг хэрэгжүүлснээр ямар үр дагавар үүсэх вэ?



### Сорил

1. **Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаар дараах арга хэмжээг авах эрхтэй.**
  - a. *Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг авах*
  - b. *Тусдаа амьдрахыг даалгах*
  - c. *Шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах*
  - d. *Хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох*
2. **Үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтийг дараах этгээд гаргах эрхтэй.**
  - a. *7-14 хүртэлх насны хүүхэд*
  - b. *Асран хамгаалагч тогтоогдоогүй 14 настай хүүхэд*

- c. 14 настай хүүхэд  
d. 18 настай хүүхэд
3. **Гэр бүлийн холбогдолтой дараах маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.**
- a. Гэрлэлтийг сэргээх  
b. Эцэг, эх байх эрхийг сэргээх  
c. Иргэний овог, эцгийн /эхийн/ нэр, нэр өөрчлөх  
d. Иргэний бүртгэл болон иргэний баримт бичгийн бичилтэд өөрчлөлт, залруулга хийх
4. **Гэрлэлтээ цуцлуулах үедээ эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ хэрэгжүүлэх журмыг тусгайлан тохиролцоогүй бол түүнийг**
- a. Хүүхдийн эрх ашгийг хамгаалах байгууллага тогтооно  
b. Нийгмийн ажилтан тогтооно  
c. Шүүх тогтооно  
d. Сум дүүргийн Засаг дарга тогтооно
5. **Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг:**
- a. Хүүхдийн эрх ашгийг хамгаалах байгууллага хамгаална  
b. Эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч хамгаална  
c. Шүүх хамгаална  
d. Хүний эрхийн байгууллага хамгаална



### Бодлого

Төрсөн ах дүү хоёрын аав нь 1994 онд, ээж нь 2001 онд нас барсан тул тэд бүтэн өнчин үлдэж ээжийнх нь ах болох “У” асран хамгаалагчаар тогтоогджээ. Гэвч “У” нь хүүхдүүдэд анхаарал халамж төдий л сайн тавьдаггүй, тэднийг гадуурхаж байсны улмаас түүний том ах нь гэр орноосоо дайжин хэд хоногоор сураггүй алга болдог байжээ. Тэрээр тухайн нутаг дэвсгэрт байгаа хараа хяналтгүй хүүхдийн бүртгэлд орсон төдийгүй түүний дүү ч “У”-гийн гэрт хамт амьдрахад хүндрэлтэй болсон.

Бүтэн өнчин 2 хүүхдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах вэ? Энэ нөхцөлд хэрэгжүүлэх хамгаалалтын арга, хэлбэрийг тодорхойлж түүний онцлогийг хуулийн холбогдох заалтыг иш татаж тайлбарлана уу? Тэдгээрийг “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэж үзэх үү? Хамгаалалтын ямар арга хэлбэрээр тэдний эрх, ашиг сонирхлыг хамгаалах вэ? Асран хамгаалагч болох “У”-гийн үйлдэлд дүгнэлт хийнэ үү.



### Эх сурвалж:

- |  |         |
|--|---------|
| 1. Монгол Улсын Үндсэн хууль /2 дугаар бүлэг/                                      | 1992 он |
| 2. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль   | 1999 он |
| 3. Хүүхдийн эрхийн тухай конвенц “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаар I боть | 2004 он |
| 4. Монгол Улсын Иргэний хууль /2 дугаар бүлэг/                                     | 2002 он |



- |   |         |
|---|---------|
| 5. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /12 дугаар бүлэг/ | 2002 он |
| 6. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль  | 1996 он |
| 7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль                                     | 2004 он |
| 8. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /2 дугаар бүлэг/                            | 2005 он |
| 9. Иргэний бүртгэл, мэдээллийн ажлын гарын авлага                                   | 2003 он |
| 10. Ц.Алтанцэцэг, Иргэн, бизнесийн эрхзүйн гарын авлага 128-136-х                   | 2003 он |
| 11. А.Дугармаа, Гэр бүлийн эрх зүй  | 2005 он |
| 12. Л.М.Пчелинцева Семейное право России /58-70 х/                                  | 2001 он |

## ШҮҮХИЙН БУС ХАМГААЛАЛТ

### Сэдвийн агуулга

Гэр бүлийн маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх асуудал, үр нөлөө  
Шүүхийн бус арга түүний төрөл

### Сэдвийн зорилго

Гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын хүрээнд олж авсан онолын мэдлэг дээрээ тулгуурлан шүүхийн бус хамгаалалтын ач холбогдлыг танин мэдэх, түүнийг амьдралд хэрэгжүүлэх боломж нөхцөлийг судалж түүний ач холбогдлыг тайлбарлан таниулах, үр нөлөөг дээшлүүлэх арга замыг тодорхойлж энэ чиглэлээр бусдад дэмжлэг туслалцаа үзүүлэх чадварыг эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Шүүхийн бус арга** - Эрх зүйн маргааныг шийдвэрлэх үүднээс маргаж буй талуудыг харилцан зөвшилцөлд хүргэх шүүхийн бус зохицуулалтын аргуудыг хэлнэ

**Зуучлал** - Аливаа маргаантай асуудлыг уг маргаанд ямар нэгэн сонирхолгүй, зуучлагчийн туслалцаатай шийдвэрлэж, тодорхой зөвшилцөлд хүргэх, харилцан ойлголцуулах арга хэмжээг хэлнэ

**Хэлэлцээ** – Маргаж буй тал болон түүний төлөөлөгч зуучлалын ажиллагаанд харилцан байр сууриа илэрхийлж үр дүнд хүрэх зорилгоор оролцох бөгөөд талуудын хооронд зуучилж буй этгээд боломжит нөхцлийг тодорхойлох, үр дүнтэй болгоход чиглэсэн арга хэмжээг хэлэлцэн шийдвэрлэх арга замыг хэлнэ

**Зөрчилдөөнт байдал** - Аливаа ашиг сонирхлыг хангах зорилгоор үүсэн бий болсон нөхцөл байдлыг хэлнэ


### Маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх тухай ойлголт, давуу тал

Маргааныг хэрхэн шийдвэрлэх вэ? гэдэг асуултыг ихэнх иргэд шүүхээр болон захиргааны журмаар хэмээн ойлгодог. Иймээс шүүхийн бус аргаар маргааныг шийдвэрлэх боломжийг төдий л сайн мэддэггүй.

Үүний тулд шүүхийн бус аргаар маргааныг шийдвэрлэх боломжийн талаар мэдэж авах нь зайлшгүй чухал юм. Учир нь аливаа маргааныг шүүхийн болон захиргааны журмаар шийдвэрлэх үед талууд болон тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчид ихээхэн цаг хугацаа, хүч хөрөнгө зарцуулахад хүргэдэг.

Харин шүүхийн бус аргаар маргааныг шийдвэрлэх үед талууд харилцан ашигтай сонголт хийх, харилцан сэтгэл ханамжтай үр дүнд хүрэх боломж нээгддэг ач холбогдолтой

### Шүүхийн бус аргын давуу тал






## Шүүхийн бус аргын төрөл

- Зуучлал
- Хэлэлцээ
- Эвлэрэл

Эдгээр аргуудыг ямар тохиолдолд хэрхэн хэрэглэх, зөв сонголт хийх, талуудын ашиг сонирхлыг тэгш хамгаалахын тулд шүүхийн бус аргыг үр дүндтэй хэрэглэхэд хуульчийн гүйцэтгэх үүрэг, ур чадвар онцгой нөлөөтэй болно.

### Зуучлал




### Зуучлалын зарчим


- Талууд тэгш эрхтэй оролцох
- Зуучлагч нь бие даасан хараат бус төвийг сахисан байх
- Зуучлал сайн дурын байх
- Нууцыг чандлан хадгалах

### Зуучлагчийн үүрэг

- Маргалдагч талуудын харилцан сонгосноор зуучлагчийн үүрэг гүйцэтгэх
- Зуучлалын зарчмыг ажиллагаандаа мөрдөх
- Зуучлалын чиглэлээр ажиллаж буй хүмүүстэй байнга холбоотой байх
- Маргагч талуудын хооронд харилцан ярилцах ярилцлагыг явуулах
- Маргааныг зохицуулах, маргаантай байдлаас гарах саналын чиглэлийг талуудад санал болгох
- Өөрийнхөө тухай болон зуучлалын үр дүнгээс тодорхой танилцуулга хийх
- Зуучлалын процесс явуулах дүрэм, журмыг танилцуулах
- Маргагч талуудын гэрээ, хэлэлцээрийг бэлтгэх



### Хэлэлцээ



### Эвлэрэх

Иргэний хэрэг маргааны талаар шүүхийн өмнөх буюу шүүхийн шатанд эвлэрэн хэлэлцэж болно.

Эвлэрэх нь маргагч талууд маргааны талаар харилцан буулт хийх, эвийн хэлэлцээр байгуулах замаар маргааныг дуусгавар болгож шийдэлд хүрч байгааг ойлгоно. Иргэн өөрийн эрх ашиг нь зөрчигдсөн гэж үзвэл эрх ашгаа хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх эрхтэй.

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх явцад хуульд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд шүүх хуралдаан хийлгүй, шүүгчийн захирамж гарган хэргийг дуусгавар болгож болно. Үүнийг хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа гэнэ.

### Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах үндэслэл:

- Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан
- Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн
- Эвлэрсэн
- Нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн



### Хяналтын асуулт:

1. Гэр бүлийн маргааныг шүүхийн бус аргаар хэрхэн шийдвэрлэж болох вэ?
2. Гэр бүлийн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэхэд маргагч талууд ямар үүрэг гүйцэтгэх вэ?
3. Шүүхийн бус аргуудыг зөв сонгож хэрэглэх, талуудын ашиг сонирхлыг хамгаалахын тулд хуульч хүн ямар чадваруудыг эзэмшсэн байх ёстой гэж бодож байна вэ?
4. Хэлэлцээний ерөнхий дүр зургийг урьдчилан тодорхойлох үүднээс хэлэлцээ хийхээс өмнө та дараах асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?
  - Хэлэлцээ хийх ёстой юу?
  - Хэлэлцээнээс татгалзах уу?
  - Хэрэв хэлэлцээ хийвэл ямар чиг шугам барих вэ?
  - Хүрэх үр дүн нь юу вэ?
  - Эсрэг тал юуг, яагаад хүсэж байна вэ?
5. Хэлэлцээний үр дүнг гэрчилсэн баримт бичгийг хэрхэн үйлдэх вэ? Тухайлбал: хэлэлцээр, хэлэлцсэн тухай тэмдэглэл, хэлэлцээ хийсэн тухай батламж гэх мэт бичиг баримтыг үйлдэхэд юуг анхаарах ёстой вэ?
6. Зуучлалыг явуулах үе шат, түүний хүрээнд ямар ажиллагааг хийх вэ? Үе шат тус бүрт юуг анхаарах ёстой вэ ?
7. Ямар тохиолдолд зуучлагчийн оролцоотойгоор маргааныг шийдвэрлэх нь тохиромжтой вэ?



### Бодлого

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө судалгааны дүн /2005/, болон Монгол Улсын Дээд шүүхийн тайлан /2005-2006/-ийн материал дээр тулгуурлан хялбаршуулсан журмаар буюу талуудын эвлэрлийн үндсэн дээр хэрэг шийдвэрлэж буй шүүхийн практикт дүн шинжилгээ хийж, дараах асуултанд хариулна уу?
  - Маргагч талууд эвлэрч, түүний үндсэн дээр шүүх хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа хэргийг шүүгчийн шийдвэрлэсэн хэрэгт оруулж дүгнэх нь хир үндэслэлтэй вэ?
  - Шүүгчийн ачаалал, шүүхийн зардлыг багасгах нөгөө талаар иргэд ч богино хугацаанд бага өртгөөр өөрийн ашиг сонирхолдоо нийцсэн зөвшилцөлд хүрэх шүүхийн бус аргын үр нөлөөг дээшлүүлэхэд юуг анхаарах ёстой вэ?



### Даалгавар:

Зуучлал, Хэлэлцээ, Эвлэрэл гэсэн 3 баг болж гэр бүлийн эрх зүйн бодлого, дасгалын гарын авлагыг ашиглан шүүхийн бус аргаар маргааныг шийдвэрлэх ажиллагааг биечлэн гүйцэтгэж харилцан санал солилцож холбогдох баримт бичгийг боловсруулна уу?



Эх сурвалж:

1. Монгол Улсын Иргэний хууль /410- 412 зүйл/ 2002 он
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
3. Гэр бүлийн тухай хууль 1999 он
4. Иргэний хуулийн тайлбар 2005 он
5. Хууль дээдлэх ёс сэтгүүл 82-86 т 2006/01
6. Хүний эрх сэтгүүл /49-56 т/ 2005/4
7. Өмгөөлөгч сэтгүүл/26 тал/ 2006/5
8. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт,үр нөлөө судалгааны дүн 2005 он
9. Монгол Улсын Дээд шүүхийн жилийн тайлан /2004,2005,2006/
10. Ц. Алтанцэцэг Иргэн бизнесийн эрх зүйн гарын авлага 128-136 тал 2006 он
11. Ц. Алтанцэцэг Гэр бүлийн эрх зүйн гарын авлага 2007 он



### 3 БҮЛЭГ. ГЭРЛЭЛТ, ТҮҮНИЙ ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР ГЭРЛЭЛТИЙН ОЙЛГОЛТ, ГЭРЛЭХ НӨХЦӨЛ, ЖУРАМ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР

#### Сэдвийн агуулга

Гэрлэлтийн ойлголт, мөн чанар  
Гэр бүлийн түүхэн хэв маяг, хөгжлийн чиг хандлага  
Гэрлэх нөхцөл  
Гэрлэх журам  
Гэрлэлтийн бүртгэл  
Гэрлэгчдийн эрх, үүрэг

#### Сэдвийн зорилго

Гэрлэхэд тавигдах шаардлага, гэрлэлтийг бүртгэх, гэрлэлтийн түүхэн хэв маягт гарч буй өөрчлөлт, түүний талаарх үзэл баримтлалтай танилцаж тэдгээрийг харьцуулан судалж, танин мэдсэний үндсэн дээр, энэхүү харилцааны хүрээнд гарч буй асуудлуудад онолын талаас үнэлэлт, дүгнэлт өгөх, хуулийг сонгон хэрэглэх, хууль зүйн үр дагаврын учир холбогдлыг тайлбарлах, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх дадал, чадвар эзэмшинэ.



#### Нэр томъёоны тайлбар

**Гэрлэлт** - Хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг хэлнэ

**Гэрлэх нөхцөл** - Төрийн эрх бүхий байгууллагаас гэрлэлтийг бүртгэхэд хуулиар тогтоосон нөхцөл байдлыг хэлнэ

**Гэрлэх нас** - Эрх зүйн бүрэн чадамжтай байх нэг гол шалгуур нь нас бөгөөд гэрлэлтийн харилцаанд субъектээр оролцож болох өөрөөр хэлбэл хуулиар тогтоож зөвшөөрсөн гэрлэх насны доод хязгаарыг хэлнэ

**Гэрлэхэд харшлах шалтгаан** - Энэ нь эрх бүхий байгууллагаас гэрлэлтийг бүртгэхэд саад болох, хориглосон, хуулиар тогтоож өгсөн нөхцөл байдлыг хэлнэ.

**Гэрлэлтийн бүртгэл** - Гэрлэлтийг хууль зүйн дагуу баталгаажуулж байгаа үйл ажиллагааг ойлгоно.


**Гэрлэлтийн гэрчилгээ** - Гэрлэлтийг хууль зүйн дагуу баталгаажуулж эрх бүхий байгууллагаас олгогдох албан ёсны баримт бичгийг хэлнэ

**Гэрлэлт** Энэхүү ухагдахууныг гадаад илрэл үзэгдлээр нь хурим, найр хийх, айл гэр болох гэж ойлгодог боловч энэ нь олон салбар шинжлэх ухааны судлах зүйл болдог. Философи, социологи, хууль зүй, анагаах ухаан, сэтгэл зүйн шинжлэх ухаанд гэрлэлт, гэр бүлийн асуудлыг судлаачид өөр, өөр байр сууринаас тодорхойлон тайлбарладаг.

Манай улсад 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд анх удаа “гэрлэлт”-ийн талаарх ойлголтыг тодорхойлж өгсөн юм. Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг хэлнэ гэж заасан байна.

Хуулийн тодорхойлолтыг үндэслэвэл гэрлэлт гэдэг ойлголт нь дараах шинжүүдийг илэрхийлнэ.

Гэр бүлийн тухай хуульд 3 үндсэн нөхцөлийг тодорхойлон заасан байна. Үүнд: Эрэгтэй, эмэгтэй хоёр харилцан зөвшөөрөлцсөнөөр гэрлэх, гэрлэх насанд хүрсэн байх, хуульд заасан гэрлэхэд харшлах шалтгаан байхгүй байх.





НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенцид зааснаар насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй бөгөөд дээрх конвенциудад нэгдэн оролцогч улсууд гэрлэх доод насыг хуулиар тогтооно.

Хуулиар тогтоосон насанд хүрээгүй этгээдтэй гэрлэх явдлыг хууль ёсны хэмээн тооцохгүй байх, эрх бүхий байгууллага гэрлэгсдийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс, онцгой шалтгааныг харгалзан гэрлэх насны доод хязгаарыг өөрчлөн тогтоож болох талаар тусгасан байдаг.


Манай улс дээрх конвенциудад нэгдэн орсон ба Үндсэн хуульд гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ гэж заасан.

Гэр бүлийн тухай хуулиар гэрлэх насыг 18 байхаар тогтоосон ба 16-18 хүртэлх насны хүмүүс шүүхээс хүндэтгэн үзэх шалтгааны улмаас эрхийн бүрэн чадамжтай гэж тооцогдсон нөхцөлд бусадтай гэрлэж болно.



Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 7-р зүйлд зааснаар Иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага нь гэрлэхийг хүсэгчид, гэрчийн этгээдийг байлцуулан гэрлэлтийг тогтоосон журмын дагуу бүртгэх ба, гэрлэлтийг бүртгэсэн өдрөөс эхлэн гэрлэгчдийн эрх, үүрэг үүснэ.

Гэрлэлт бүртгэхэд дараах журмыг баримтална.





**Хяналтын асуулт:**

1. Гэрлэлтийн тухай ойлголтын хууль зүйн шинж юу вэ?
2. Гэрлэх хэв маягийн уламжлал, шинэчлэлийн асуудлыг тайлбарлана уу?
3. Гэрлэх нөхцөл, журам, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын ялгааг тайлбарлана уу?
4. Гэрлэх насыг багасгаж болох үндэслэл, ийнхүү багасгасны хууль зүйн үр дагавар юу вэ?
5. Иргэний бүртгэлийн байгууллага нь гэрлэлтийг бүртгэхээс татгалзах ямар үндэслэл байдаг вэ?
6. Гэрлэлтээ бүртгүүлэхийн хууль зүйн ач холбогдол юунд орших вэ?



**Сорил**

1. **Гэр бүлийн тухай хуульд заасан гэрлэхэд харшлах шалтгааны талаар хангалттай нотлох баримт байгаа бол гэрлэлтийг бүртгэхээс татгалзаж болох талаар ямар хуульд заасан байдаг вэ?**
  - a. Иргэний бүртгэлийн тухай хууль
  - b. Гэр бүлийн тухай хууль
  - c. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
  - d. a, б-д заасан хуулиуд
2. **Гэр бүлийн холбогдолтой аль маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэх вэ?**
  - a. Эцэг, эх байх эрхийг сэргээхтэй холбогдсон маргаан
  - b. Асран хамгаалагч тогтоохтой холбогдсон маргаан
  - c. Хүүхэд үрчлэхтэй холбогдсон маргаан
  - d. Овог, нэр өөрчлөхтэй холбогдсон маргаан
3. **Гэрлэхэд харшлах шалтгааныг олно уу?**
  - a. Асран хамгаалагч нь асран хамгаалалтад байх хүнтэйгээ гэрлэх
  - b. Харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоёр гэрлэх
  - c. Гэрлэгчдийн аль нэг нь нийгмийн халдварт өвчтэй байх
  - d. Гэрлэгчдийн аль нэг нь эсхүл хоёулаа согтууруулах, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэдэг байх
4. **Гэрлэхийг хүсэгчид нь эрүүл мэндийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулахыг:**
  - a. Хуульд заасны дагуу заавал хийлгэнэ
  - b. Сайн дураараа хийлгэж болно
  - c. Сонирхогч этгээд хүсэлт гаргавал заавал хийлгэнэ
  - d. Өмнө нь гэрлэж байсан бол хуульд зааснаар заавал дүгнэлт гаргуулна
5. **Гэрлэлтийг “гэрээ” юм гэж тодорхойлсон эрдэмтнийг нэрлэнэ үү?**
  - a. В. А. Рясенцев
  - b. Г.К. Матвеев
  - c. М.В. Антокольская
  - d. А.М. Нечаев



6. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар аль байгууллагад хандаж болох вэ?
- Шүүхэд
  - Сум дүүргийн Засаг даргын тамгын газарт
  - Асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагад
  - Гэрлэлтээ сүм, хийдэд бүртгүүлсэн бол тэдгээрийн захиргаанд



**Бодлого**

Гармаа, Адъяа нар төрийн эрх бүхий байгууллагад гэрлэлтээ бүртгүүлэлгүй 1986-1996 оны 2 дугаар сар хүртэл хамт амьдарч байв. Тэд 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдөр гэрлэлтээ бүртгүүлж, 1997 оны 4 дүгээр сард шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан.

Гармаа 1989 онд худалдаж авсан БГД-ийн нутаг дэвсгэрт байрлалтай 3 өрөө орон сууц, Худалдаа хөгжлийн банкны хадгаламжийн дансанд 1993 онд хадгалуулсан 4 000 000 төгрөгийн өмчлөгчөөр тус тус тогтоолгож, өөрт ногдох хэсгийг гаргуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байна. Шүүх Гармаагийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэр гаргасан.

Энэ тохиолдолд:

- Шүүхийн шийдвэр үндэслэлтэй эсэхэд дүгнэлт хийнэ үү:



**Даалгавар:**

- Шүүхийн болон захиргааны журмаар гэрлэлт цуцлах үндэслэл, журмын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар саналаа гаргана уу?
- Шүүхээс гэрлэлт цуцлах хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зайлшгүй байх нотолгооны хэрэгслийг нэрлэн бичнэ үү?
- Шүүхэд болон захиргааны байгууллагад гаргах нэхэмжлэл, өргөдлийн загвар боловсруулна уу?



**Эх сурвалж:**

- |  |         |
|--|---------|
| 1. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль         | 1999 он |
| 2. Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хууль | 1999 он |
| 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль       | 2000 он |
| 4. Ц. Алтанцэцэг. Иргэн бизнесийн эрх зүй      | 2006 он |
| 5. А. Дугармаа. Гэр бүлийн эрх зүй             | 2005 он |

## ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ЭД ХӨРӨНГИЙН БУС АМИНЫ ХАРИЛЦАА

### Сэдвийн агуулга

Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины харилцааны тухай ойлголт, онцлог

Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины харилцааны ангилал

Гэрлэгчдийн эд хөрөнгийн бус амины эрх, үүрэг

Эцэг, эх, хүүхдийн эд хөрөнгийн бус амины эрх, үүрэг

Хүүхдийн эцэг, эхийг тогтоох, түүний үр дагавар

### Сэдвийн зорилго

Гэр бүлийн гишүүдийн хооронд үүсэх эд хөрөнгийн бус амины харилцаа, түүний онцлог шинж, ангилал, гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн амины эрх, үүрэг, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, түүний үр дагаврын талаар цэгцтэй мэддэг эзэмших, энэхүү харилцааг бусад харилцаанаас ялгаж тодорхойлох, тайлбарлах, хууль зүйн талаас үнэлэлт, дүгнэлт хийх, бусдад хууль зүйн зөвлөгөө өгөх чадвар эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины харилцаа**-Гэрлэгчдийн хооронд материаллаг бус, эд хөрөнгөтэй холбоогүйгээр үүсч, гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцааг хэлнэ

**Гэрлэгчид эрхлэх ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй** - Эхнэр, нөхөр нь өөрийн авьяас чадвар, сонирхол, бие махбодийн хөгжил зэрэгт тохирсон хөдөлмөр эрхлэх тухай ойлголт юм. Эхнэр, нөхөр ямар байгууллагад, хөдөлмөрийн ямар нөхцөлд, ямар ажил үүрэг гүйцэтгэхээ өөрөө сонгоход эхнэр, нөхрийн аль нэг нь саад болж хязгаарлалт тавихгүй байх ёстой. Мөн түүнчлэн гэрлэгчдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно. Гэрлэгчид мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй гэдэг нь хүн бүр сурч боловсрох эрхтэй гэж заасан хуулийн заалттай салшгүй холбоотой.

**Гэрлэгчид оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй** - Иргэний оршин суугаа газар нь эрх зүйн ач холбогдлын хувьд гэр бүлийн эрх зүйн харилцааны тогтвортой байдлыг хангах төрийн болон иргэний эрх, ашиг сонирхолыг хамгаалахад чиглэгдсэн нэн чухал ач холбогдолтой ойлголт юм. Гэрлэгчид нь гэр бүл болсноор өөрсдийн амьдрах оршин суух газраа чөлөөтэй сонгох тэдний хүсэл зоригийн илэрхийлэл, боломжийг хэлнэ

**Гэрлэгчид гэр бүлээ төлөвлөхөд тэгш эрхтэй байх** - Гэр бүлийн нийгмийн өмнө хүлээх үүргийн нэг бол үр удмаа үлдээн хүүхэд төрүүлэх явдал юм. Гэрлэгчид нь харилцан тохиролцож хүүхэд төрүүлэх асуудал болон хэдэн хүүхэд төрүүлэх эсэхээ шийдвэрлэнэ. Мөн түүнчлэн хүүхдээ үрчлүүлэх, хүүхэд үрчлэн авах, бусдын хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх тухай асуудлыг харилцан зөвшөөрөлцсний үндсэн дээр шийдвэрлэнэ. Гэрлэгчид нь гэр бүлийн тухай хуульд зааснаар бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, бие биеэ халамжлах, хүндэтгэх,



хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй байх үүргийг хүлээнэ.

**Эцэг, эх байх эрхийг хязгаарлах** - Энэ нь хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасахгүйгээр эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон хугацаанд хүүхдийг тэднээс тусгаарлахыг ойлгоно. Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарлах нь эцэг, эхтэй хариуцлага тооцож буй нэг хэлбэр мөн боловч хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж байгаа арга хэмжээ юм. Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийг орон сууц, хувцас, хоол ундаар байнга, санаатай гачигдуулсан, хүүхдийн хөдөлмөрийг зүй бусаар ашигласан, хүүхдээ гуйлгачлуулсан, орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан зэрэг тохиолдолд шүүхээс хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарлана.

**Эцэг, эх байх эрхийг хасах** - Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий байгууллагаас хуульд заасан нөхцөл, журмын дагуу оногдуулж буй хариуцлагын арга хэмжээ юм. Сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх онцгой ажиллагааны журмаар хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасах тухай хэргийг хянан хэлэлцэнэ. Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасах үндэслэл, нөхцөл, журмыг хуульд тусгайлан зохицуулж өгсөн учраас зөвхөн хуулиар журамлагдсан ажиллагаа юм. Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хассанаар эрх зүйн тодорхой үр дагавар үүснэ. Эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан (хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, эрх зүйн зөрчилд татан оруулах), хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцах, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, хүүхдээ сэтгэл санааны дарамтанд байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатай зайлсхийсэн, мансууруулах, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг бол шүүх эцэг, эх байх эрхийг хасна.

Гэрлэгчдийн гэрлэлтийг төрийн эрх бүхий байгууллага бүртгэсэн өдрөөс эхлэн тэдний хооронд эрх, үүрэг үүсэх бөгөөд түүнийг эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүрэг гэж 2 ангилна.

### **Гэрлэгчдийн амины эрх, үүрэг**

Гэрлэгчдийн эд хөрөнгийн бус амины харилцааны өвөрмөц онцлог шинж:

1. Гэрлэгчдийн эрх, үүрэг үүсэх хууль зүйн факт нь гэрлэгчдийн гэрлэлтийг бүртгэхтэй шууд холбоотой.
2. Гэрлэгчдийн хоорондын эд хөрөнгийн бус амины эрх, үүрэг нь зөвхөн гэрлэгчдийн хооронд үүсэх бөгөөд энэхүү эрх, үүрэг нь хэн нэгэнд шилжих, дамжих боломжгүй юм.
3. Гэрлэгчдийн эд хөрөнгийн бус амины эрх, үүрэг нь материаллаг болон эдийн засаг, эд хөрөнгийн агуулгатай байж болохгүй бөгөөд эд хөрөнгийн бус эрх, үүрэг нь гэрлэлтийн гэрээ болон бусад гэрээ хэлэлцлийн зүйл болох боломжгүй, өөрөөр хэлбэл энэхүү эрх, үүргийг гэрээгээр тохиролцсоны үндсэн дээр үүсгэж, өөрчилж, дуусгавар болгох боломжгүй юм.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд гэрлэгчдийн амины эрх, үүргийг тусгасан байна. Тухайлбал:



**Эцэг, эх хүүхдийн амины эрх үүрэг.** Хүүхэд төрснөөр, үрчилснээр эцэг, эх хүүхдийн хооронд эрх, үүрэг үүснэ.

Хүүхэд нь гэр бүлд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

**Хүүхэд төрмөгцөө нэр авах эрхтэй.** Нэр гэдэг нь хүүхдийг анх төрөхөд нь оноон өгч дуудах нэр, өөрөөр хэлбэл иргэн өөрийн нэртэй байх нь иргэний салшгүй эрх юм. Нэр нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан, хүн төрснөөр түүнийг бодьгалжуулж байгаа нэгэн элемент юм. Нэртэй байхыг хуулиар хүлээн зөвшөөрч байгаа нь түүнийг эрх зүйн харилцаанд оролцох нөхцлийг хангаж байгаа явдал юм. Эцэг эх нь тохиролцсоны үндсэн дээр хүүхэддээ нэр өгөх бөгөөд хүүхэд эцгийн нэрийг авна. Олдсон хүүхдэд сум дүүргийн Засаг дарга, эсхүл иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагын ажилтан нэр өгнө.

**Хүүхэд аюулгүй орчинд амьдрах эрхтэй.** Эцэг, эх нь хүүхдээ хоол хүнс, орон байр ахуйн хэрэгслээр хангаж эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хоол хүнсээр хангана. Хүүхэд эцэг, эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжинд байх эрхтэй. Энэ нь хүүхэд эцэг эхээ мэдэх, эцэг, эхтэйгээ нэг гэр бүлд амьдрах, тэдний хайр халамжинд байх, хэрэв эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан бол хэнтэй нь амьдрах тухай хүсэлтээ эрх бүхий байгууллагад гаргах, эцэг, эхээсээ тусдаа амьдарч байгаа тохиолдолд тэдэнтэй байнгын харилцаатай байхыг ойлгоно.

**Хүүхэд эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.** Хүүхдийн эрх ашгийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч бусдын өмнө хамгаалах үүрэгтэй. Эцэг, эх нь шүүх, хууль хяналтын байгууллагад хүүхдийн эрх ашгийг хамгаалж, хуульд зааснаар төлөөлөх эрхтэй субъект байна.

**Хүүхэд ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй.** Эцэг, эх нь хүүхдэд боловсрол олгох нь тэднийг өв тэгш хөгжүүлэх, бусдыг хүндэтгэдэг дадал зуршил бий болгоход ач холбогдолтой гэдгийг ухамсарлан ойлгож, тэдэнд суурь боловсрол эзэмшүүлэх үүрэгтэй байна.

**Хүүхэд төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөх эрхтэй.**

**Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, бодож сэтгэх, мэдээлэл хийх эрхтэй.**

**Хүүхдийн эцэг, эхийг тогтоох.**

Хүүхэд төрснөөр болон үрчлэн авснаар эцэг, эх хүүхдийн хооронд эрх, үүрэг үүснэ. Энэ байдал нь гэрлэлтээ бүртгүүлсэн болон бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн



хүүхэд болон үрчлэгч, үрчлүүлэгч, дагавар хүүхэд, хойт эцэг, хойт эхийн хооронд нэгэн адил хамаарна. Эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа нь хүүхэд төрснөөр, болон хүүхэд төрснийг бүртгэснээр, өөрөөр хэлбэл хууль зүйн факт болсон үйлдэл, үйл явдлын үндсэн дээр үүснэ. Амьдралд эцэг, эх гэрлэлтээ бүртгүүлээгүй атлаа хүүхэд төрүүлэх явдал элбэг тохиолддог. Энэ үед хүүхдийн эцэг, эхийг тогтоох асуудал гарч ирнэ. Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийн эцэг, эхийг 2 журмаар тогтоож болохоор заажээ. Үүнд:

Захиргааны журмаар эцэг, эхийг тогтоох

Шүүхийн журмаар эцэг, эхийг тогтоох

Эцэг, эх нь хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, эрх, ашиг, сонирхлыг нь хамгаалах үүрэг хүлээнэ. Хэрэв эцэг, эх нь энэ үүргээ эс биелүүлбэл түүний эцэг, эх байх эрхийг хуульд заасан журмын дагуу хязгаарлах буюу хасна.



### Хяналтын асуулт:

1. Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины харилцаа, түүний онцлог шинжийг тайлбарлана уу?
2. Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины харилцааны ангилал, түүний шалгуурыг тодорхойлно уу?
3. Гэрлэгчдийн эд хөрөнгийн бус амины эрх, үүргийг тодорхойлно уу?
4. Эцэг, эх, хүүхдийн хоорондын амины эрх, үүргийг тайлбарлана уу?
5. Хүүхдэд овог, эцгийн нэр, нэр өгөх талаарх эрх зүйн зохицуулалтыг тайлбарлана уу?
6. Хүүхдийн төрсний бүртгэлийн журмын талаар ярилцана уу? Түүний үр дагаврыг тайлбарлана уу?
7. Хүүхдийн эцэг, эхийг тогтоох үндэслэлийг нэрлэнэ үү?
8. Практикт ихэвчлэн хүүхдийн эцэг, эхийг шүүхийн журмаар тогтоож байгаагийн учир шалтгааныг тайлбарлана уу?
9. Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарлах үндэслэлийг эцэг, эх байх эрхийг хасах үндэслэлээс ялган тайлбарлана уу?
10. Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарлах ба хассанаас үүсэх үр дагавар ялгаатай юу?
11. Хүүхдийн эцэг, эхийг захиргааны болон шүүхийн журмаар тогтоох зохицуулалтын онцлогийг тодорхойлж тайлбарлана уу?



### Сорил

1. **Олдсон хүүхдэд нэр өгөх эрхтэй этгээдийг олно уу?**
  - a. Олсон хүн
  - b. Цагдаагийн ажилтан
  - c. Иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан
  - d. Сум дүүргийн Засаг дарга
2. **Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь:**
  - a. Монгол улсын иргэний журамт үүрэг
  - b. Монгол улсын иргэний үндсэн үүрэг
  - c. Гэр бүлийн эрх зүйн гол зарчим

- d. Зан заншил, ёс суртахууны хэм хэмжээгээр зохицуулагддаг ойлголт
3. **Эцэг, эх нь өөрөө өргөдөл гаргасан бол ямар байгууллага хүүхдийн эцэг, эхийг тогтоох вэ?**
- Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар
  - Иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан
  - Аймаг, Нийслэлийн Засаг даргын тамгын газар
  - Эцэг, эх нь өөрөө
4. **15 настай хүү өөрийн эцэг, эхийг тогтоолгохоор шүүхэд өргөдөл гаргасан бол Гэр бүлийн тухай хууль зөрчсөн гэж үзэж болох уу?**
- Болно
  - Болохгүй
5. **Эцэг, эх нь хүүхдээ орон гэрээс нь дайжуулбал:**
- Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасна
  - Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарлана
  - Хүүхдийн эрхийг хамгаалахын тулд Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар эцэг, эхэд мөнгөн торгууль ноогдуулна
  - Цагдаагийн байгууллага эцэг, эхийг түр саатуулах арга хэмжээ авна
6. **Аль нь хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасах үндэслэлд хамаарах вэ?**
- Хүүхдийг гуйлгачлуулсан
  - Хувцас, хоол, ундаар санаатай гачигдуулсан
  - Хүүхдээ санаатай төөрүүлсэн
  - Орон сууцаар гачигдуулсан
7. **Эцэг, эх, хүүхдийн эрх, ашиг хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдвол эрх, ашиг сонирхлыг нь хэн хамгаалах вэ?**
- Засгийн газрын харъяа Хүүхдийн эрхийг хамгаалах Үндэсний төв
  - Аймаг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын нийгмийн ажилтан
  - Хүүхдийн эрх, ашигийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус болон олон нийтийн байгууллага
  - Сум, дүүргийн Засаг дарга
8. **Хүүхдэд нэр, овог өгөх талаар маргаан гарвал ямар байгууллага шийдвэрлэх вэ?**
- Шүүх
  - Сум, дүүргийн Засаг дарга
  - Иргэдийн төлөөлөгчдийн хурал
  - Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид



### Бодлого

1. Болд нь эхнэр, хүүхдийн хамт амьдардаг. Тэрээр нэгэн компанид удирдах ажил хийдэг тул зав чөлөө муутай. Амралтын өдрүүдэд ч гэртээ байх нь ховор. Тийм учраас хүүхдийн хүмүүжилд эхнэр нь анхаарч, хариуцах ёстой гэж үздэг. Гэр бүлийн амьжиргаанд хүрэлцэх мөнгийг Болд ганцаараа олж байгаа учраас эхнэрээ ажил хийхийг зөвшөөрдөггүй байв. Гэтэл нэгэн удаа хүү Сугар нь гэмт хэрэгт холбогдсон байна.



Энэ тохиолдолд:

1. Гэрлэгчдийн болон хүүхдийн эрх, үүрэг зөрчигдсөн эсэхэд дүгнэлт хийнэ үү?
2. Нийслэлийн Чингэлтэй дүүгийн иргэн Батсүх, түүний эхнэр Балжмаа нар 12, 6 настай хоёр хүүхдийн хамт амьдардаг. Батсүх, Балжмаа нар 2000 оноос эхлэн архи хэтрүүлэн хэрэглэдэг болсон. Батсүх ажил дээрээ архи дан согтуурсан гэдэг үндэслэлээр ажлаасаа халагдсан. Харин Балжмаа нь тодорхой эрхэлсэн ажилгүй байдаг байжээ. Энэ байдлыг мэдсэн 12 настай хүү Болдбаярын ангийн багш Эрдэнээ Чингэлтэй дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан. Нэхэмжлэлдээ: Болдбаярын эцэг, эх хуульд заасан эрх, үүргээ биелүүлэхгүй байнга согтуурдаг, тэд эцэг, эхийн хуралд оролцдоггүй, хүүхдийнхээ сурлага хүмүүжилд анхаарал тавьдаггүй, хаяа гэрт нь очиход согтуу байж байдаг. Хүүгийн сурлагын түвшин буурсан, цаашид ийм орчинд хоёр хүүхэд нь амьдарвал эрүүл мэнд, хүмүүжлийн доголдолтой болох тул хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасах арга хэмжээ авч өгөхийг хүсчээ.

Энэ тохиолдолд:

1. Шүүх нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэх вэ?
2. Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хассанаар ямар үр дагавар үүсэх вэ?



### Даалгавар:

- Гэрлэгчдийн эд хөрөнгийн бус амины эрх зөрчигдөж байгаа талаар жишээ татаж түүнээс үүсэх үр дагаврыг нэрлэнэ үү?
- Эцэг, эх байх эрхийг хязгаарласан, эсхүл хассан тухай шүүхийн шийдвэр байгаа эсэхийг судална уу?
- Хүүхдийн эцэг, эхийг тогтоосон шүүхийн шийдвэр 3-аас доошгүйг олж, дүгнэлт хийнэ үү?



### Эх сурвалж:

- |   |         |
|---|---------|
| 1. Монгол улсын Гэр бүлийн тухай хууль.                 | 1999 он |
| 2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль                | 1999 он |
| 3. Ц. Алтанцэцэг. Иргэн бизнесийн эрх зүйн гарын авлага | 2006 он |
| 4. А. Дугармаа. Гэр бүлийн эрх зүй                      | 2005 он |

## ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХАРИЛЦАА

### Сэдвийн агуулга

Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн тухай ойлголт, онцлог

Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө

Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгө

Гэрлэгчид эд хөрөнгийн харилцааг гэрээгээр зохицуулах нь

Гэр бүлийн гишүүний хамтран өмчлөх дундын хөрөнгөөс гишүүнд оногдох хэсгийг тодорхойлох нь

### Сэдвийн зорилго

Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааны талаар системтэй мэддэг эзэмших, гэр бүлийн эд хөрөнгийг ангилан, хамаарагдах эд хөрөнгийг зөв тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг тайлбарлах, холбогдох хуулийн заалтыг сонгон хэрэглэх, хууль зүйн үнэлэлт дүгнэлт хийх, гэрээ боловсруулах чадвартай болж цаашид энэ асуудалд хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшинө.



### Нэр томъёоны тайлбар

**Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцаа** - Гэр бүлийн гишүүдийн хуваарьт болон хамтран өмчлөх дундын өмч, бие биенээ гэжээн тэтгэхтэй холбогдон үүссэн гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцааг хэлнэ

**Гэр бүлийн хөрөнгө** - Гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийн эд юмс, оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох баялаг нь гэр бүлийн хөрөнгө болно

**Гэр бүлийн эд хөрөнгө** - Гэрлэгчид болон гэр бүлийн гишүүдийн эзэмшилд байгаа эд юмс хамаарна


**Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгө** - Гэр бүлийн гишүүн хуульд заасны дагуу гэрлэхийн өмнө буюу гэрлэлтийн явцад бий болсон, хамтран өмчлөх дундын өмчлөлд шилжүүлэхээр тохиролцоогүй, өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах хөрөнгийг хэлнэ

**Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө** – Хуульд заасны дагуу гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгийг хэлнэ

**Гэр бүлийн эд хөрөнгийн эрх** - Хуульд заасны дагуу хуваарьт болон хамтран өмчлөх дундын эд хөрөнгөтэй холбогдон үүсэх гэр бүлийн гишүүдийн эзэмших, ашиглах, захиран зарцуулах, шаардах эд хөрөнгийн эрхийг хэлнэ


**Гэрлэгчид хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулах** - Хуульд заасны дагуу гэрлэгчид нь хөрөнгийн эрхээ харилцан тохиролцож байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулахыг хэлнэ

**Гэр бүлийн эд хөрөнгөөс оногдох хэсгийг тодорхойлох** – Тодорхой нөхцөл байдал бий болсноор гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс хуульд заасны дагуу гэр бүлийн нэг гишүүнд ноогдох хөрөнгийн хэмжээг хэлнэ.



Гэр бүлийн эрх зүйн эд хөрөнгийн харилцааны нэг төрөл нь гэр бүлийн хөрөнгөтэй холбоотой харилцаа юм. Гэр бүлийн оршин тогтнох, аж төрж амьдрах үндсэн нь гэр бүлийн материаллаг баялаг болно.


**Монгол Улсын Үндсэн хууль / 16.3§ /**  
*“Монгол улсын иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.”*  
**Хүний эрхийн түгээмэл тунхаглал / 17§ /**  
*“Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа болон бусадтай хамтран өмчлөх эрхтэй.”*




Гэр бүлийн эд хөрөнгийн онцлогийг “Гэр бүл” хэмээх ойлголттой холбон авч үзэж тодорхойлно. Энэхүү ойлголтын агуулгаар “гэр бүлийн хөрөнгө” гэж томъёологдож иргэний хуулийн 3 дутаар дэд бүлэгт тусгай хөрөнгө гэж тодорхойлсон.

Гэр бүлийн хөрөнгийн онцлог:

**А/ Субъектын хувьд**



Гэр бүлийн дундын хөрөнгийн хамтран өмчлөгч нь гэрлэгчид, гэр бүлийн гишүүд байх бөгөөд гэр бүлийн гишүүн бус гуравдагч этгээд байх боломжгүй



**Б/ Гэр бүлийн хөрөнгө нь гэр бүлийн зорилго, гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн нэгдмэл хэрэгцээ ашиг сонирхолд тулгуурлан, түүнийг хангах зорилготой.**

Гэр бүлийн амьжиргааг баталгаажуулах үүднээс гэр бүлийн хамтран өмчлөх дундаа хөрөнгийг бүрдүүлнэ. Гэр бүлийн нэг гишүүний эрх бусад хамтран өмчлөгч гишүүдийн эрхээр хязгаарлагдах юм. Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.


**В/ Гэр бүлийн дундын хөрөнгө нь гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болно.**

Гэр бүлийн дундын өмчийг үүсгэхэд “гэрлэгчид” байх зайлшгүй шаардлагатайтулалбан ёсны гэрлэлт чухал үүрэг гүйцэтгэнэ. Албан ёсны гэрлэлт нь гэр бүлийн хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангана. Гэр бүлийн дундын өмч үүсэх нэг нөхцөл нь хамтран амьдрах шаардлагатай бөгөөд дундын хөрөнгөд хамтран амьдарсан хугацаанд бий болгосон хөрөнгийг хамруулна.

**Гэр бүлийн эд хөрөнгө** Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг хуулиар буюу **түүний зохицуулалт** гэрээгээр зохицуулна.

Иргэний хуулийн 3 дугаар дэд бүлэгт гэр бүлийн хөрөнгийн зохицуулалтыг тусгасан.

Энэ нь гэр бүлийн эд хөрөнгийн зохицуулалтын хуулийн дэглэм болно. Үүнд



### **1/ Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгө, түүний дэглэм**

- Иргэний хуулийн 127 дугаар зүйлд заасан хөрөнгө нь гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгөд хамаарна.
- Гэр бүлийн гишүүн хуваарьт эд хөрөнгөө өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй.
- Гэр бүлийн гишүүд өөрөөр тохиролцоогүй бол тэдгээр нь хувийн үйл ажиллагаатай холбогдсон үүргээ өөрийн хуваарьт эд хөрөнгөөрөө хариуцна.

### **2/ Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө, түүний дэглэм**

- Иргэний хуулийн 126 дугаар зүйлд заасан хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгөд хамаарна.
- Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж захиран зарцуулна.
- Гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа гэр бүлийн гишүүдийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна. Хуульд өөрөөр заагаагүй бол уг зөвшөөрөл аваагүй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.



- Гэрлэсэнээс хойш гэр бүлийн гишүүний хэн нэг нь эд хөрөнгөө дур мэдэн бусдад шилжүүлсэн, олсон ашиг, орлогоо санаатайгаар нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол эрх нь зөрчигдсэн гэр бүлийн гишүүн зөрчигдсэн эрхээ сэргээлгэх эрхтэй.

### **Гэрлэгчид эд хөрөнгийн харилцааг гэрээгээр зохицуулах:**

Энэ нь гэр бүлийн хөрөнгө болон тэжээн тэтгэх харилцааны зохицуулалтанд нэгэн адил хамаарна.

#### **Иргэний хууль / 132§ /**


*“Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ноогдох хөрөнгийг тодорхойлох, хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг хуульд нийцүүлэн байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулж болно”*

### **Гэрээнд тавигдах шаардлага:**

- Гэрээний хэлбэр
- Гэрээний талууд буюу субъект
- Гэрээний агуулга
- Гэрээ байгуулах, хүчин төгөлдөр болох

### **Гэрээг өөрчлөх, цуцлах журам:**

Гэрлэгчид нь энэхүү гэрээг өөрчлөх буюу цуцлах эрхтэй. Энэ эрхээ хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.



### **3/ Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөс гишүүнд ногдох хэсгийг тодорхойлох нь:**

- Хуульд заасан нөхцөл байдал бий болох /Иргэний хуулийн 129.1§/
- Гэр бүлийн гишүүдийн нэхэмжлэлийн шаардлага / Иргэний хуулийн 130§/
- Хуульд заасан журмын дагуу ногдох хэсгийн хэмжээг тодорхойлох / Иргэний хуулийн 129.2429.4,130.2,130.3§/ гэсэн үндсэн асуудлын хүрээнд



**Хяналтын асуулт:**

1. Гэр бүлийн эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэхэд анхаарвал зохих асуудлуудыг тодорхойлж түүний хууль зүйн ач хол богдолыг тайлбарлана уу?
2. Гэр бүлийн орон сууцны маргааныг шийдвэрлэхэд ямар бэрхшээлүүд үүсэх вэ?
3. Гэрлэгчид болон гэр бүлийн гишүүд үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа тэдгээрийн зөвшөөрлийг бичгээр авах талаарх хууль зүйн шаардлага нь ямар зорилготой вэ? Уг зөвшөөрлийг хэрхэн баталгаажуулах вэ? Үүнтэй холбогдож практикт ямар зөрчлүүд гардаг вэ?
4. Гэр бүлийн хөрөнгийн эрхийн гэрээ байгуулахын ач холбогдол юу вэ?
5. Гэрлэлтээ батлуулаагүй хамтран амьдрагчдын эд хөрөнгийн маргааныг хэрхэн шийдвэрлэх вэ? Ямар онцлогтой вэ?
6. Гэр бүлийн гишүүдийн дундын хөрөнгөөр хариуцах болон хариуцахгүй үүрэг гэж юуг хэлэх вэ?



**Сорил**

1. **Гэр бүлийн хөрөнгө нь**
  - a. *Хамтран амьдрагчдын хөрөнгөөс*
  - b. *Гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөөс*
  - c. *Гэрлэгчдийн хөрөнгөөс*
  - d. *Гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөөс бүрдэнэ*
2. **Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгөд аль нь хамаарах вэ?**
  - a. *Гэрлэснээс хойш хувийн авъяас, чадварыг үнэлэн олгосон шагнал*
  - b. *Хамтран өмчлөх дундын өмчлөлд шилжүүлэхээр тохиролцсон хөрөнгө*
  - c. *Гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаа гэрлэснээс хойш бий болсон хөрөнгө*
  - d. *Гэр бүл болоход нь зориулагдсан орон сууц*
3. **Гэр бүлийн гишүүд өөрийн хувийн үйл ажиллагаатай холбогдсон үүргээ хэрхэн хариуцах вэ?**
  - a. *Гэр бүлийн гишүүнтүлхамтран өмчлөх дундын хөрөнгөөр*
  - b. *Гэр бүлийн гишүүд өөрөөр тохиролцоогүй бол өөрийн хуваарьт эд хөрөнгөөр*
  - c. *Тухайн гэр бүлийн гишүүний эцэг, эхийн хөрөнгөөр*
  - d. *Гэр бүлийн насанд хурсэн гишүүдийн дундын өмчлөлийн хөрөнгөөр хариуцна*
4. **Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд хамаарах уу?**
  - a. *Дундын хөрөнгийн орлогоор олж авсан үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө*
  - b. *Амин хувийн хэрэгцээг хангахад зориулсан эд хөрөнгө*
  - c. *Бэлэглэлийн журмаар шилжүүлж авсан эд хөрөнгө*
  - d. *Зохиогчийн шагнал*



5. **Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа**
  - a. Гэр бүлийн бүх гишүүдийн бичгээр гаргаж нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна.
  - b. Гэрлэгчийн бичгээр гаргаж нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна.
  - c. Гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн бичгээр гаргаж нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна.
  - d. Гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай гишүүний бичгээр гаргаж нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна.
6. **Гэр бүлийн гишүүнд ногдох хөрөнгийн хэмжээ нь:**
  - a. Насанд хүрсэн хүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна
  - b. Хөдөлмөрийн чадвартай гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна
  - c. Насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна
  - d. Насанд хүрээгүй гишүүнийг оролцуулан нийт гишүүдэд адил байна.
7. **Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэмжээг тодорхойлохдоо:**
  - a. Гэрлэлт цуцлах болсон шалтгаан, хөрөнгийн хэмжээг
  - b. Насанд хүрээгүй хүүхдийн тоо, асрамжийн байдал
  - c. Гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн ашиг сонирхол
  - d. Гэр бүлийн гишүүний хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан түүний хувь хэмжээг харгалзан шүүх өөрөөр тогтооно.
8. **Шүүх гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцоноос үүссэн эд хөрөнгийн маргааныг:**
  - a. Гэр бүлийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн тухай заалтын дагуу
  - b. Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөх заалтын дагуу
  - c. Гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээний дагуу шийдвэрлэнэ.
9. **Тамирчин “Н”-ийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож алтан медаль хүртсэнийг үнэлж засгийн газраас түүнд 25 сая төгрөгийн мөнгөн шагнал олгожээ. Энэ нь гэр бүлийн ямар хөрөнгөд хамаарах вэ?**
  - a. Хуваарьт хөрөнгөд
  - b. Хамтран өмчлөх дундын хөрөнгөд
  - c. Гэр бүлийн гишүүд харилцан тохиролцож өмчийн хэлбэрийг тогтооно.
10. **Гэрлэгчид хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг хэдийд байгуулж болох вэ?**
  - a. Хамтран амьдрах болсон үеэс
  - b. Гэрлэгчид гэр бүл болохоос өмнө болон гэрлэсний дараа
  - c. Гэрлэсний дараа
  - d. Гэр бүлийн хөрөнгийг бүрдүүлсний дараа



### Бодлого

“Ш” нь эхнэр болон насанд хүрсэн 2 хүүгийн хамт амьдардаг бөгөөд хамтын хөдөлмөрийнхөө үр дүнд бий болгосон гэрийн мод, тавилга хийдэг үйлдвэрлэл эрхэлдэг. Том хүү өрх тусгаарлах үедээ гэр бүлийн хамтран өмчлөх дундын хөрөнгө болон уг үйлдвэрийн тодорхой хэсгийг авах тухай хүсэлт гаргасан. Хүүгийн эцэг гэрийн мод, тавилгын үйлдвэрлэл нь гэр бүлийн орлогын гол эх үүсвэр болох учраас түүнд ногдох хэмжээг өгөх боломжгүй учир бусад эд хөрөнгөөс зохих хувь хэмжээг өгч болно гэж үзжээ.

1. Эцэг болон хүүгийн үйлдэлд дүгнэлт хийнэ үү? Хүү гэр бүлийн эд хөрөнгийг хуваах талаар шаардлага гаргах эрхтэй юу?
2. Гэр бүлийн амьжиргааг залгуулахад шаардлагатай эд хөрөнгөөс ногдох хэсгийг шаардах эрхтэй эсэхийг хуулийн холбогдох заалтыг иш татаж тайлбарлана уу?
3. Хэрхэн шийдвэрлэх вэ?



### Даалгавар:

Иргэний хуулийн 132 дугаар зүйлд заасныг үндэслэн гэрлэгчдийн хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээний үлгэрчилсэн загварыг боловсруулна уу?



### Эх сурвалж:

- |   |         |
|---|---------|
| 1. Монгол Улсын Иргэний хууль /3-р дэд бүлэг/                   | 2002 он |
| 2. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /509-530 т/             | 2005 он |
| 3. Ц.Алтанцэцэг Иргэн, бизнесийн эрх зүйн гарын авлага/156-160/ | 2005 он |
| 4. А.Дугармаа Гэр бүлийн эрх зүй                                | 2005 он |
| 5. Л.М.Пчелинцева, Семейное право России /169-232с/             | 2001 г  |
| 6. Комментарий к семейному кодексу Российской федераций         | 2003 г  |



## ТЭЖЭЭН ТЭТГЭХ, ТЭТГҮҮЛЭХ ХАРИЛЦАА

### Сэдвийн агуулга

Тэжээн тэтгэх, тэтгүүлэх харилцааны ойлголт, түүний үүсэх үндэслэл, онцлог

Тэжээн тэтгэх, тэтгүүлэх харилцааны ангилал, субъект

Тэжээн тэтгэх гэрээ

Тэжээн тэтгэх тэтгэлгийг тогтоох, гаргуулах үйл ажиллагаа, журам

Тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх журам

Тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болох

### Сэдвийн зорилго

Оюутан энэ сэдвээр тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа үүсэх үндэслэл, тэжээн тэтгэх, тэтгүүлэх харилцааны субъектийн ангилал, тэдгээрийн эрх, үүрэг, тэтгэлгийн хэлбэр, хугацаа, хэмжээ, тэтгэлэг тогтоох, гаргуулах журам, тэтгэлгийн үүргээс чөлөөлөх болон дуусгавар болох талаарх онолын мэдлэг эзэмших, олж авсан мэдлэг дээрээ үндэслэн тэжээн тэтгэх гэрээ байгуулах, энэ харилцаатай холбоотой баримт бичиг боловсруулах, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх, хуулийн заалтыг тайлбарлах чадвар эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Тэжээгч** - Тэжээгч нь тэтгүүлэгчид материалаг тусламж, туслалцааг үзүүлэх үүрэг хүлээсэн тэтгүүлэгчийн эцэг, эх, эхнэр буюу нөхөр, хүүхэд, төрөл, садангийн хүн, гэр бүлийн гишүүдийг хэлнэ.

**Тэтгүүлэгч** -Тэжээн тэтгүүлэх зайлшгүй шаардлагатай болсон бага насны, насанд хүрээгүй хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй болсон эхнэр, нөхөр, эцэг, эх, төрөл садангийн хүмүүсийг хэлнэ

**Тэжээн тэтгэх үүрэг** - Гэрлэгчид бие биенээ, эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ, хүүхэд нь хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхээ, төрөл садангийн хүмүүс бие биеэ тэжээн тэтгэх үүрэг хүлээсэн этгээдийг хэлнэ.

**Тэтгэлгийн хэмжээ** - Тэжээгчээс тэтгүүлэгчид олгох хууль буюу гэрээнд заасан тэтгэлгийн доод хязгаарыг хэлнэ.

**Тэжээн тэтгэх гэрээ** - Тэтгэгч, тэтгүүлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр тэжээн тэтгүүлэх эрх үүссэнээс хойш харилцан тохиролцсон нөхцөлөөр бие биеэ тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахыг хэлнэ.

Тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа гэдэг нь гэр бүлийн гишүүний аль нэг нь нөгөөдөө хуульд заасан журмын дагуу материаллаг тусламж үзүүлэхтэй холбогдсон гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцаа юм. Тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаанд оролцогч субъектыг бүрэлдэхүүний хувьд эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эхээ, гэрлэгчид бие, биенээ, төрөл садангийн хүмүүс бие биенээ тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаа гэж ангилан үзнэ.



Хүүхдэд олгох тэтгэлгийг хүүхдийн насны байдлыг харгалзан сар тутам 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар, 11-16 настай /суралцаж байгаа бол 18/, насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр тогтооно.

**Тэжээн тэтгэх гэрээ** - 1999 оны Гэр бүлийн тухай хуулийн нэг онцлог бол хуульд зааснаар гэрлэгчид бие биеэ, эцэг эх нь үр хүүхдээ, насанд хүрсэн хүүхэд нь хөдөлмөрийн чадваргүй болсон эцэг, эхээ, төрөл садангийн хүмүүс бие биеэ тэжээн тэтгэх үүргийг тэжээн тэтгэх гэрээ байгуулсаны үндсэн дээр харилцан тохиролцож хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоож өгсөнд оршино.

Тэжээн тэтгэх гэрээгээр тэтгэгч, тэтгүүлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр тэжээн тэтгүүлэх эрх үүссэнээс хойш тохиролцсон нөхцөлөөр бие биеэ тэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Тэжээн тэтгэх гэрээний оролцогч нь нэг талаас бусдыг тэжээн тэтгэх үүрэг хүлээсэн тэтгэгч, нөгөө талаас тэтгэгчээс материаллаг тусламж зайлшгүй шаардлагатай болсон тэтгүүлэгч байна.



Гэрээний тэтгэгч тал нь үүрэг хүлээсэн учраас нэг талын, хариу төлбөргүй гэрээ юм. Тэтгэгч нь тэтгүүлэгчийг тэтгэсний төлөө хариу төлбөр нэхэх, эд хөрөнгө, мөнгө шаардах эрхгүй ба тэтгүүлэгч тэтгэгчид буцааж төлбөр төлөх үүрэг хүлээхгүй. Тэжээн тэтгэх гэрээг бичгээр үйлдэж нотариатаар гэрчлүүлсэн байна.

Энэхүү гэрээнд талууд тэтгэлгийн хэмжээ, хэлбэр, хугацаа зэргийг тодорхой тохиролцоно. Тэтгэлгийн хэмжээг талууд тохиролцоходоо тэтгэгчийн цалин, орлогын тодорхой хувийг эсхүл тодорхой хугацаагаар тогтмол мөнгөн дүнгээр, эсвэл гэрээний нийт хугацаанд нэг удаа тодорхой мөнгө буюу эд хөрөнгөөр тохиролцох боломжтой. Гэрээгээр тохиролцох тэтгэлгийн хэлбэрийн хувьд мөнгөн эсхүл эд хөрөнгө байж болно. Тэтгэлгийг эд хөрөнгөөр тохиролцвол түүний үнийг зах зээлийн тухайн үеийн ханшаар тогтооно.

Гэр бүлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т тэтгэлгийг сар, улирал, хагас жил, жилээр эсхүл нэг удаа олгохоор гэрээндээ зааж болно. Тэтгэгч тэтгэлгийг хугацаандаа төлөхгүй бол учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хожигдуулсан хоног тутамд алданги төлүүлэхээр тохиролцож болно. Гэрээний талууд харилцан тохиролцсоноор гэрээг өөрчлөх, цуцлах хуулиар зөвшөөрөгдсөн ямарч нөхцөлийг тусгаж болох бөгөөд өөрчлөх, цуцлах талаар хэдийд ч харилцан тохиролцож болно. Энэхүү гэрээг өөрчлөх, цуцлах тухай тохиролцоог бичгээр үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байна. Тэжээн тэтгэх гэрээг өөрчлөх, цуцлах талаар маргаан гарвал шүүх шийдвэрлэнэ.



#### Хяналтын асуулт:

1. Тэжээн тэтгэх ойлголтын онолын үндэслэлийг тайлбарлана уу?
2. Тэжээн тэтгэх харилцааны субъектийн ангилал, түүний онцлогийг тайлбарлана уу?
3. Тэжээн тэтгэх гэрээний агуулга, хэлбэрийг ойролцоо төрлийн гэрээнээс ялгагдах онцлогийг тодорхойлно уу?
4. Тэтгэлгийг хугацаанд төлөөгүйгээс үүсэх хариуцлагын хэлбэрийг тайлбарлана уу?
5. Хүүхдэд олгох тэтгэлгийн асуудлаар үүсч байгаа маргаанд анализ хийж тайлбарлана уу?



#### Сорил

1. **Тэжээн тэтгүүлэх хүн тэжээн тэтгүүлэх эрх үүссэн цагаас хойш ямар хугацаанд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй вэ?**
  - a. жил
  - b. 6 жил
  - c. 5 жил
  - d. Хугацаа харгалзахгүй
2. **Нөхөр нь эхнэрээсээ гэрлэлтээ цуцлуулснаас хойш 5 сар өнгөрөхөд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол:**
  - a. Эхнэр нь нөхрөө тэжээн тэтгэх үүрэгтэй
  - b. Бие биенээ тэжээн тэтгэх үүрэг үүсэхгүй
  - c. Хөдөлмөрийн чадвар алдах болсон үндэслэлийг тогтоосноор тэжээн тэтгэх үүрэг үүснэв
  - d. Нэгэнт гэрлэлтийн харилцаа дуусгавар болсон учраас үүрэг үүсэхгүй

3. **“Б” нь “Д”-гээс гэрлэлтээ цуцлуулах үед “Д” нь өндөр насны тэтгэврээтогтоолгосон байжээ. Тэдний гэрлэлтийг цуцалсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа “Д” нь “Б”-гээр тэжээн тэтгүүлэхээр нэхэмжлэл гаргасан байна.**
  - a. *“Б” нь “Д”-г тэжээн тэтгэх үүрэгтэй*
  - b. *“Д” нь амьдрах байнгын эх үүсвэр болсон тэтгэврийн орлоготой тул “Б”-д тэжээн тэтгэх үүрэг үүсэхгүй*
  - c. *Энэ талаар хуульд нарийвчилсан заалт байхгүй тул “Д” нь тэжээн тэтгүүлэх эрхгүй*
  - d. *Зөвхөн сайн дурын үндсэн дээр, хүсвэл “Б” тэжээн тэтгэх боломжтой*
4. **Гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд эцэг, эхээрээ тэжээн тэтгүүлэх эрхтэй эсэх?**
  - a. *Тийм*
  - b. *Үгүй*
5. **Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүн хүүхдээ тэжээн тэтгэх үү?**
  - a. *Чөлөөлөгдөнө*
  - b. *Тэжээн тэтгэнэ*
  - c. *Хүүхдийг харж хандах өөр хүнгүй бол заавал тэжээн тэтгэнэ*
  - d. *Зөвхөн хуулиар тогтоосон нөхцөлд тэжээн тэтгэхээс чөлөөлөгдөнө*
6. **Эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулаагүй бол тэтгэлэгийг ямар байгууллага тогтоох вэ?**
  - a. *Хүүхдийг асран хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага*
  - b. *Нийгтийн халамжийн байгууллага*
  - c. *Шүүх*
  - d. *Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар*
7. **Тэтгэлэгийг ямар хэлбэрээр олгох вэ?**
  - a. *Эд хөрөнгөөр*
  - b. *Мөнгөн хэлбэрээр*
  - c. *Бусад хэлбэрийг талууд тохиролцож болно*
  - d. *Энэ талаар хуульд зохицуулалт байхгүй учраас тэтгэлгийн хэлбэр шаардлагатай зүйл биш*
8. **Тэтгэлэг тогтоосон шүүхийн шийдвэрийн хувийг иргэний бүртгэлийн байгууллагад явуулах уу?**
  - a. *Тийм*
  - b. *Үгүй*
  - c. *Шаардлагатай тохиолдолд явуулж болно*
  - d. *Хуульд энэ талаар заагаагүй учраас шаардлагагүй*
9. **Тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадвараа алдсан бол:**
  - a. *Тэтгэлэг төлөхөөс чөлөөлөгдөнө*
  - b. *Төлөх тэтгэлгийн хэмжээг багасгаж болно*
  - c. *Тэтгэлэг төлөхтэй холбогдсон харилцаа дуусгавар болно*
  - d. *Тэтгэлэг төлөхийг түр зогсооно*



10. Хөдөлмөрийн чадвартай хүүхэд нь хөдөлмөрийн чадваргүй болсон хойт эцэг, эхээ тэжээн тэтгэх үү?

- Тийм
- Үгүй
- Тохиролцовол болно
- Тэжээн тэтгэх өөр хүн байвал тэжээн тэтгэхээс чөлөөлөгдөнө



### Бодлого

1. Дорлиг, Наран хоёр гэрлэлтээ бүртгүүлснээс хойш 3 жил хамт амьдарсан. Наран 23 настай байхдаа хүүхэдтэй болж энэ тухайгаа нөхөр Дорлигтоо хэлэхэд тэрээр хүүхэдтэй болсонд нь ихэд дургүйцэж, хүүхдээ эмнэлгийн аргаар авахуулахыг шаарджээ. Хэрвээ Наран хүүхдээ гаргахаар шийдвэл түүнээс гэрлэлтээ цуцлуулна гэдгээ ч Дорлиг мэдэгдсэн байна. Гэсэн хэдий ч Наран хүүхдээ төрүүлэхээр шийджээ. Наран хүүхдээ хүндрэлтэй төрүүлсэн бөгөөд охиноо төрүүлснээс хойш 6 цагийн дараа нас барсан байна. Нарангийн төрүүлсэн охиныг эцэг Дорлиг авахаас татгалзсан учраас Нарангийн ээж 52 настай Цэндээ нь өөрийн асрамжиндаа авсан байна. Цэндээ эрхэлсэн тодорхой ажилгүй, халамжийн тэтгэврийн мөнгөөр амьдралаа залгуулдаг нэгэн бөгөөд Дорлигоос охиныг тэжээн тэтгүүлэхээр материаллаг тусламж хүсэхэд тэрээр татгалзаж, “авдаг цалин нь зөвхөн өөрийн хэрэгцээг арай ядан хангадаг, мөн түүнчлэн хүүхэдтэй болохыг ерөөсөө хүсээгүй” гэж тайлбарлаж, цалингийн тодорхойлолтоо Цэндээд авчирч өгсөн байна. Энэ тохиолдолд:

- Цэндээ Нарангийн хүүхдийг тэжээн тэтгэх үүрэгтэй эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- Дорлиг охиноо тэжээн тэтгэх үүрэг хүлээх үү?

2. Дорноговь аймгийн сум дундын шүүхийн иргэний шүүх хуралдаанаар иргэн Чимидхорлоогийн нэхэмжлэлтэй хүүхдийн тэтгэлэг гаргуулахыг хүссэн нэхэмжлэлийг хэлэлцэв. Чимидхорлоо гэрлэлтээ цуцлуулсан нөхөр Мягмар нь төрсөн гурван хүүхдээ тэжээн тэтгэхээс татгалзаж, олон удаа худал амалсаар хоёр жилийг өнгөрөөсөн тул түүний цалин орлогоос тэтгэлэг гаргуулахыг хүсчээ. Мягмар нь өмгөөлөгчийн ажил эрхэлж, 3-4 байгууллагад тогтмол хуулийн зөвлөгчөөр ажилладаг. Дундаж цалин нь 500000 төгрөг болж байгааг нотолсон нотлох баримтыг Чимидхорлоо гаргаж өгчээ.

Энэ тохиолдолд:

- Чимидхорлоогийн гаргаж өгсөн нотлох баримт хэрэгт ач холбогдолтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- Мягмараас хүүхдийн тэтгэлгийг нөхөн гаргуулах уу?
- Хүүхэд тус бүрт нэмэгдэл зардал шаардлагатай юу?



**Даалгавар:**

1. Энэ сэдвийн хүрээнд тэжээн тэтгэх гэрээний үлгэрчилсэн загвар гаргана уу?
2. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай хэргийг шийдвэрлэж байгаа шүүхийн практикийг судалж, оюутан тус бүр дүгнэлт хийнэ үү?
3. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх ажиллагааны онцлогийг анхааран судалж, энэ талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал бэлтгэнэ үү



**Эх сурвалж:**

- |  |         |
|--|---------|
| 1. Гэр бүлийн тухай хууль                      | 1999 он |
| 2. ИХШХШ тухай хууль                           | 2002 он |
| 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль       | 2002 он |
| 4. Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл | 2004 он |



## ГЭРЛЭЛТ ДУУСГАВАР БОЛОХ НЬ

### Сэдвийн агуулга

Гэрлэлт дуусгавар болох тухай ойлголт, үндэслэл, онцлог

Гэрлэлт цуцлах тухай ойлголт, түүний зохицуулалтын онцлог, үр дагавар

### Сэдвийн зорилго

Гэрлэлт дуусгавар болох, цуцлах болон гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл, журмын талаар онол, практикийн цэгцтэй мэддэгийн үндсэн дээр гэрлэлтийг дуусгавар болгох зохицуулалтын нийтлэг болон ялгаатай талыг харьцуулан тодорхойлох, хууль зүйн дүгнэлт хийх, хуулийг сонгон хэрэглэх, түүний үр дагаврыг тайлбарлах чадварыг эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Гэрлэлт дуусгавар болох** - Энэ нь гэрлэгсдийн хооронд үүссэн гэрлэлтийн харилцааг гэрлэгчид болон бусад сонирхогч этгээдийн хүсэлтээр эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндэслэл журмын дагуу зогсоож буй ажиллагааг хэлнэ.

**Гэрлэлт цуцлах** - Энэ нь гэрлэлт дуусгавар болох нэгэн үндэслэл бөгөөд гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон гэрлэгчдийн хамтын амьдрал тэдний хүсэл зоригийн үндсэн дээр эрх бүхий байгууллагын шийдвэрээр дуусгавар болохыг ойлгоно.

**Гэрлэгчдийн аль нэг нь нас барах, нас барсан гэж зарлах** - Гэрлэгчдийн аль нэг нь, эсхүл хоёулаа нас барсан бол нас барсан тухай эмнэлгийн магадаагаа, оршуулсан тухай тодорхойлолт, нас барсан талаар гарсан шүүх эмнэлгийн дүгнэлт зэргийг үндэслэн түүний эцэг, эх, эхнэр нөхөр, 18 нас хүрсэн хүүхэд нь сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт нас барсныг бүртгүүлнэ. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь иргэний нас барсныг бүртгэж гэрчилгээ олгоно.

Монгол Улсын Иргэний хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар иргэн оршин суугаа газраасаа алга болсноос хойш 5 жилийн хугацаанд хаана байгаа нь мэдэгдэхгүй, сураг чимээгүй болсон, эсхүл амь үрэгдэж болох нөхцөл байдалд алга болсноос хойш нэг жилийн турш амьд байгаа эсэх нь мэдэгдэхгүй байгаа бол сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх онцгой ажиллагааны журмаар иргэнийг нас барсан гэж тооцсон шийдвэр гаргана. Шийдвэр хүчин төгөлдөр болмогц сум, дүүргийн Засаг дарга нас барсныг бүртгэж гэрчилгээ олгоно. Эхнэр, нөхрийн аль нэг нас барсан буюу нас барсан гэж шүүхээр зарлагдсан тохиолдолд гэрлэлт цуцалсны бүртгэл хөтлөхийг шаарддаггүй байна. Нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрийг уг этгээдийг нас барсан өдөр гэж үзнэ. Энэ өдрөөс эхлэн гэрлэлт дуусгавар болсонд тооцогддог.


**Гэрлэгчдийг эвлэрүүлэх** - Шүүх гэрлэлт цуцлах хэргийг шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг судлан тогтоож, гэрлэгчдийн болон хүүхдийн эрх, ашгийг хамгаалах зорилгод нийцүүлэн, хуульд заасан журмын дагуу гэрлэлт цуцлахыг түтгэлзүүлэн харилцан ойлголцож эвлэрэх боломжийг олгож байгаа ажиллагааг хэлнэ.

**Хүүхдийн асрамж тогтоох** - Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулснаар хүүхэдтэйгээ хамт амьдрах боломжгүй болсон нөхцөлд шүүхээс насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэний асрамжинд үлдээх вэ гэдэг асуудлыг шийдвэрлэж байгаа ажиллагааг ойлгоно.

**Хүүхдийн тэтгэлэг тогтоох** - Шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлээд түүнд олгох тэтгэлэгийг хуульд заасан журмын дагуу тогтоож байгаа ажиллагааг ойлгоно. Хүүхдийн тэтгэлгийн асуудлаар гэрлэгчид харилцан тохиролцож тэжээн тэтгэх гэрээ байгуулах боломжтой бөгөөд энэ талаар тохиролцож чадаагүй бол Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийн насны байдлыг харгалзан сар тутам, хүүхэд тус бүрт тэтгэлгийг тогтооно.

Гэрлэлт дуусгавар болсноор гэрлэгсдийн хоорондын гэрлэлттэй холбогдсон харилцаа гэрлэгчид болон бусад сонирхогч этгээдийн хүсэлтээр эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндэслэл, журмын дагуу дуусгавар болдог ба үүний үр дагавар нь тэдний хамт амьдрах, хамтын аж ахуйг эрхлэн хөглөх үйл ажиллагаа дуусгавар болж байгаа юм.

Харин эцэг, эхийн хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг хэвээр үргэлжилнэ. Гэр бүлийн тухай хуульд зааснаар дараах үндэслэлээр гэрлэлт дуусгавар болно



Гэрлэлт цуцлах нь гэрлэлт дуусгавар болох нэгэн үндэслэл бөгөөд захиргааны болон шүүхийн журмаар гэрлэлтийг цуцална.

Гэрлэгчид гэрлэхэд харшлах шалтгаан байхад гэрлэсэн, эсхүл гэр бүл болох зорилгогүйгээр гэрлэлтээ бүртгүүлсэн нь илэрсэн тохиолдолд гэрлэгчдийн хэн нэгний, эсхүл сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх гэрлэлтийн харилцааг дуусгавар болгоход чиглэгдсэн үйл ажиллагааг гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох гэнэ. Гэрлэлт цуцлах, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох нь гэрлэлтийг дуусгавар болгох үндэслэл гэдгээрээ адил ойлголт боловч, үндэслэл, журам, эрх зүйн үр дагавраар өөр хоорондоо ялгаатай.



#### Хяналтын асуулт:

1. Гэрлэлтийн харилцаа дуусгавар болох зохицуулалтын үндэслэлийг хуулийн холбогдох заалтыг иш татан тайлбарлана уу?
2. Гэрлэгч нас барсан буюу нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр олсон гэх үндэслэлээр гэрлэлтийн харилцаа дуусгавар болох зохицуулалт нь ямар онцлогтой вэ? Энэ тохиолдолд ИГБББ-д бүртгүүлэх шаардлагатай юу?



3. Гэр бүлийн тухай хуулийн 12.2-т заасан зохицуулалтын агуулгыг тайлбарлана уу? Энэ нь ямар ач холбогдолтой вэ?
4. Гэрлэгчдийг хэн нэгнийг нь шүүхээс нас барсан эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцсон, 3-аас дээш жил хорих ял эдлэх ээр шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон зэрэг үндэслэлээр гэрлэлтийг цуцлахад ямар бичиг баримт бүрдүүлэх вэ? Энэ тохиолдолд гэрлэлтийг ямар журмаар цуцлах вэ?
5. Гэрлэлт цуцлах тухай хэргийг шүүхээс шийдвэрлэхэд ямар ажиллагааг гүйцэтгэхийг хуулийн холбогдох заалтыг иш татан тайлбарлана уу?



### Сорил

1. **Дорж, Наран нарын гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тухай шийдвэр гаргах үед шүүх 4 настай хүү Сүрэнг Нарангийн асрамжинд үлдээж, Доржоос сар бүр тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэжээ.** Энэ шийдвэрийг Дорж эс зөвшөөрч, нэгэнт гэрлэлт хүчин төгөлдөр бус учраас хүүхдийг ээж нь гэжээн тэтгэх ёстой гэсэн үндэслэлээр давж заалдах гомдол гаргасан байна. Доржийн гаргасан давж заалдах гомдолд хууль зүйн дүгнэлт өгнө үү?
  - a. Доржийн гаргасан гомдол үндэслэлтэй юу?
  - b. Хүү Сүрэнгийн эрх, ашиг сонирхол хөндөгдөх ёсгүй учраас гомдол үндэслэлгүй байна.
  - c. Дорж, Наран хоёр хүүхдийнхээ тэтгэлэг дээр тохиролцох учраас шүүх энэ талаар шийдвэр гаргасан нь үндэслэлгүй, иймээс гаргасан гомдол үндэслэлтэй байна.
  - d. Хуульд энэ харилцааг зохицуулсан зохицуулалт үгүй учраас гомдол хууль зүйн үндэслэл үгүй байна.
2. **Саран, Сурмаажав нарын гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох нэхэмжлэлийг шийдвэрлэхэд 9 настай охин Тэмүүжинг эцэг, эхийн хэний асрамжинд үлдээх вэ? гэдэг маргааныг шүүх шийдвэрлэх шаардлагатай болов.** Энэ тохиолдолд охин Тэмүүжингээс санал авах шаардлагатай эсэхэд дүгнэлт хийнэ үү
  - a. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох нь гэрлэлт цуцлахтай адил ойлголт биш учраас санал авах шаардлагагүй.
  - b. 7 насанд хүрсэн хүүхдээс саналыг нь авна
  - c. Гэрлэгчид энэ талаар хүсэлт гаргавал шүүх саналыг нь авч болно
  - d. Эх Сарангийн асрамжинд үлдээх нь үндэслэлтэй.
  - e. Хүүхдийн саналыг авах шаардлагагүй
3. **Гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргасан Долгор 6 сартай жирэмсэн. Нөхөр Дамба байнгын хүчирхийлэл, дарамтанд байлгадаг нь амь насанд аюултай байгаа учраас гэрлэлтийг яаралтай цуцалж өгнө үү? гэжээ.** Энэ тохиолдолд шүүх хэргийг хэрхэн шийдвэрлэх вэ?
  - a. Шүүх гэрлэлтийг цуцлахыг хориглоно
  - b. Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна
  - c. Шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална
  - d. Шүүх эх, хүүхдийн эрх, ашгийг хамгаалж, гэрлэлт цуцлах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ



### Бодлого

Хувиараа хөдөлмөр эрхэлдэг Нямдорж худалдаа, үйлчилгээнийхээ ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Намхайгаас 3.000.000 сая төгрөгийг 6 сарын дараа эргүүлэн төлөх нөхцөлтэйгээр зээлж авчээ. Түүний зорьсон ажил амжилтгүй болж зээлсэн мөнгөө эргүүлэн өгөх боломжгүй болсоор нэг жил өнгөрсөн. Намхай мөнгөө өдөр алгасалгүй нэхэж, Нямдорж ч сэтгэл санааны хувьд хүнд дарамтанд өдөр хоногийг өнгөрүүлж байв. Нямдорж зээлсэн мөнгөнийхөө оронд дөнгөж 18 насанд хүрсэн охин Должинг эхнэрээ болгон аваач гэсэн хүсэлтийг Намхайд хэлэхэд тэрээр саналыг бүрэн зөвшөөрсөн бөгөөд ингээд тэдний хооронд мөнгө зээлсэн асуудал дуусгавар болсон байна.

Охин Должин нь энэхүү тохиролцооны талаар сонсоод ихэд бухимдан татгалзсан боловч, гэр бүлээ эдийн засгийн хүнд байдал, ядуурлаас хамгаалахын тулд арга буюу Намхайтай гэрлэлтээ бүртгүүлсэн. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ажилтан тэдний гэрлэлтийг бүртгэхдээ гэрлэх асуудлаа сайн дураар шийдвэрлэж байгаа эсэх талаар ямар нэгэн асуулт тавиагүй байна. Должин 19 нас хүрсний дараа гэрлэх болсон явдлын талаар өмгөөлөгчид хандаж туслалцаа хүсэхэд “тэдний гэрлэлт хууль бус учраас хүчин төгөлдөр бус гэж тооцуулж болно” гэсэн хариултыг өгсөн.

Энэ тохиолдолд:

1. Намхай, Должин нарын гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл байгаа эсэхэд дүгнэлт хийнэ үү?
2. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар өмгөөлөгч ямар байгууллагад хандана гэж үзэж байна вэ ?
3. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тохиолдолд Должин өөрийн сэтгэл санаанд гэм хор учирсан гэж хохирлоо Намхайгаас гаргуулах боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?



### Даалгавар:

Энэ сэдвийн хүрээнд гэрлэлт дуусгавар болох зохицуулалтаас ямар эрх зүйн үр дагаварууд үүсэх тухай асуудлын талаар хэлэлцэж ярилцана уу?



### Эх сурвалж:

- |  |         |
|--|---------|
| 1. Гэр бүлийн тухай хууль  | 1999 он |
| 2. ИХШХШ тухай хууль   | 2002 он |
| 3. Иргэний бүртгэлийн тухай хууль                                    | 1999 он |
| 4. Монгол улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар | 2006 он |



## ГЭРЛЭЛТИЙГ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС ГЭЖ ТООЦОХ

### Сэдвийн агуулга

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох тухай ойлголт, үндэслэл

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос үүсэх хууль зүйн үр дагавар

### Сэдвийн зорилго

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл, журам, түүнээс үүсэх хууль зүйн үр дагаврын талаар онолын мэдлэгтэй болж холбогдох хууль тогтоомжийг практик амьдралд зөв сонгож хэрэглэх, тайлбарлах, зөвлөгөө өгөх чадвар эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох** - Гэрлэхэд баримтлах хууль зүйн нөхцөл, шаардлагыг зөрчсөн эсхүл гэр бүл болох зорилгогүйгээр гэрлэлтээ бүртгүүлсэн нь илэрсэн нөхцөлд хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагаас тэдгээрийн гэрлэлтийн харилцааг дуусгавар болгож буй хууль ёсны ажиллагааг хэлнэ.

**Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноор үүсэх хууль зүйн үр дагавар** - Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэрлэлтийг хууль бус гэж тооцсоноор гэрлэгчид болон гэр бүлийн гишүүдэд тодорхой зарим эрх, үүргийг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгож буй хуулиар тогтоосон үр дүнг ойлгоно

**Хуурамч гэрлэлт** - Элдэв тэтгэвэр авах, орон сууцны талбай эзэмших, гадаадад зорчих ба оршин суух зөвшөөрөл авах зэргээр гэрлэгчдийн хэн аль нь гэрлэлтийн баталгааг эдлэх ёсгүй эрхийг эдлэх, эсхүл хүлээх ёстой үүргээс зайлсхийхийн тулд ашиглах зорилгоор гэрлэлтээ бүртгүүлэхийг ойлгоно.

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох зохицуулалтын агуулга нь дараах ойлголтын хүрээнд тодорхойлогдоно.

### Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох зохицуулалтын мөн чанар

#### Гэрлэлт

- Моногами дээр үндэслэгдсэн
- Чөлөөтэй, сайн дурын хүсэл зоригийн илэрхийлэл
- Тэгш эрхийн үндсэн дээр бий болох
- Гэр бүлийг үүсгэн байгуулах зорилготой


#### Хүчин төгөлдөр бус

- Хууль зүйн шаардлагыг зөрчсөн
- Субъектын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг зөрчсөн

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох нь гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын нэгэн механизм болох тул энэ нь гэрлэгчид болон гэр бүлийн гишүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.

Гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын механизм болохын хувьд энэ нь хуулиар баталгаажна. Үүнд:

- Хууль зүйн факт болох /Гэр бүлийн тухай хууль 16,17§/
- Хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх /Гэр бүлийн тухай хууль 16.1 ИХШХШ тухай хуулийн 135.2.10§/
- Хууль зүйн үр дагавар үүсэх /Гэр бүлийн тухай хууль 17§/




Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцоулах тухай хүсэлтийг дараах эрх бүхий этгээдүүд гаргана. Үүнд:

- Гэрлэгчдийн хэн нэг
- Эрх нь зөрчигдсөн бусад хүн
- Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага

**Гэр бүлийн хууль / 16.2§ /**

*“Иргэний хуульд заасны дагуу иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж зарлагдсан насанд хүрээгүй гэрлэгчийн ашиг сонирхлын үүднээс, эсхүл гэрлэлтээ хүчин төгөлдөр бус гэж тооцоулахыг зөвшөөрөөгүй бол шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож болно.”*





### Хяналтын асуулт:

1. Хуурамч гэрлэлтийн мөн чанар, түүний шалтгааныг тодорхойлно уу?
2. Хуурамч гэрлэлтээс ямар үр дагаварууд үүсэх вэ?
3. Шүүхийн практикт гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ?
4. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос учирсан материалын болон сэтгэл санааны хохирлыг хэрхэн барагдуулах вэ?



### Сорил

1. **Дараах тохиолдолд гэрлэлтийг хүчин төгөлдөр бус тооцно.**
  - a. Гэр бүл болох зорилгоор хамтран амьдарч хүүхэдтэй болсон
  - b. Гадаадад зорчих зорилгоор гэрлэлтээ бүртгүүлсэн
  - c. Өмнө нь гэр бүл болж хамтран амьдарч байсан
  - d. Гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтран амьдрагчид
2. **Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох субъект нь**
  - a. Засаг дарга
  - b. ИГБББ
  - c. Шүүх
3. **Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай хүсэлтийг**
  - a. Гэрлэгчид хамтран
  - b. Нийгмийн ажилтан
  - c. Эрх нь зөрчигдсөн бусад хүний болон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага гаргана
4. **Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай хүсэлтийг шүүхээс хэрэгсэхгүй болгох нөхцөл нь**
  - a. Насанд хүрээгүй гэрлэгчид хүүхэдтэй болсон
  - b. Гэрлэгчид гэрлэлтээ хүчин төгөлдөр бус гэж тооцуулахыг зөвшөөрөөгүй
  - c. Гэрлэгчдийн эцэг, эх зөвшөөрөөгүй
5. **Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэлийг тодорхойлно уу.**

A. Гэрлэхэд харшлах шалтгаан нь

  - a. Эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцсон
  - b. Өмнөх гэрлэлт нь хүчинтэй байгаа

B. Гэр бүл болох зорилгогүйгээр гэрлэлтээ бүртгүүлсэн нь

  - a. Байнга оршин суух зөвшөөрөл авах
  - b. Гэрлэгчид хамтран амьдраагүй
6. **Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох нь**
  - a. Шүүхэд нэхэмжлэл гаргасан өдрөөс
  - b. Гэрлэлтээ бүртгүүлсэн өдрөөс
  - c. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс
7. **Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос үүссэн эд хөрөнгийн маргааныг**
  - a. Гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээний дагуу
  - b. Эд хөрөнгийг хамтран өмчлөх заалтын дагуу
  - c. Эд хөрөнгийг хэсгээр өмчлөх заалтын дагуу шийдвэрлэнэ.

8. **Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тохиолдолд гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээ нь**
  - a. *Хүчин төгөлдөр бус байна*
  - b. *Хүчин төгөлдөр байна*
  - c. *Хүчин төгөлдөр бус эсэхийг харилцан тохиролцож шийдвэрлэнэ*
9. **Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон нь хүүхдийн эрх, ашиг сонирхолд**
  - a. *Нөлөөлөхгүй*
  - b. *Зарим хэсэгт нь нөлөөлөхгүй*
  - c. *Эцэг, эхийн гаргасан хүсэлтийн хүрээнд нөлөөлөхгүй*
10. **Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос гэрлэгчдийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн нь тогтоогдвол**
  - a. *Материалын хохирлыг гаргуулах эрхтэй*
  - b. *Сэтгэл санааны хохирлыг гаргуулах эрхтэй*
  - c. *Аль алиныг нь гаргуулах эрхтэй*



### Бодлого

Иргэн “М” нь залилангийн хэргээр шийтгэгдэж эмэгтэйчүүдийн хорих ангид ял эдлэх болсон. Тэрээр ял эдлэх ээс өмнө “Б”-гэй хамтран амьдарч гэр бүлийн харьцаатай байсан. Ял эдлэх хугацаанд “Б”-ээс эргэлт авах, хуульд заасны дагуу удаан хугацааны уулзалт авах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байсан тул “М” нь ял эдэлж байх хугацаандаа гэрлэлтээ батлуулжээ. Гэтэл өршөөлийн хуулиар ганц бие, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг өршөөлд хамруулах болж тэрээр энэ боломжийг ашиглан гэрлэлтээ хүчин төгөлдөр бус гэж тооцуулж, шүүхийн шийдвэрээр суллагджээ. “М” нь “Б”-г эхнэр хүүхэдтэй болохыг мэдэж байсан.

1. “М”-ийн үйлдэлд хамааралтай хуулиудын холбогдох заалтуудыг иш татаж дүгнэлт хийнэ үү.
2. Тэдний гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл нь юу вэ?
3. “Б”-ийн эхнэр, хүүхдийн эрх нь зөрчигдсөн үү? Тэд материалын болон сэтгэл санааны хохирлоо шаардах эрхтэй юу?



### Даалгавар:

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох зохицуулалтыг гэрлэлтийн харилцаа дуусгавар болох бусад зохицуулалттай харьцуулж, тэдгээрийн нийтлэг болон ялгаатай шинжийг тодорхойлж бичнэ үү? Энэ тохиолдолд хэрэглэгдэх хуулийн заалтуудыг тодорхойлж түүний агуулгыг жишээ татаж тайлбарлана уу?



### Эх сурвалж:

- |  |         |
|--|---------|
| 1. Гэр бүлийн тухай хууль /III бүлэг/                            | 1999 он |
| 2. Иргэний хууль   | 2002 он |
| 3. Улын Дээд Шүүхийн 71 дүгээр тогтоол                           | 2002 он |
| 4. Ц.Алтанцэцэг Иргэн, бизнесийн эрх зүйн гарын авлага /156-160/ | 2006 он |
| 5. А.Дугармаа Гэр бүлийн эрх зүй                                 | 2005 он |
| 6. Л.М.Пчелинцева, Семейное право России /169-232с/              | 2001 он |
| 7. Комментарий к семейному кодексу Российской федераций          | 2003 он |

## ГЭРЛЭЛТИЙГ ЗАХИРГААНЫ БА ШҮҮХИЙН ЖУРМААР ЦУЦЛАХ

### Сэдвийн агуулга

Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлах үндэслэл, журам  
Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах үндэслэл, журам  
Гэрлэлт цуцалсны үр дагавар

### Сэдвийн зорилго

Гэрлэлт дуусгавар болох зохицуулалтын нэгэн хэлбэр болох цуцлах зохицуулалтын үндэслэл, журмын талаар онол, практикийн мэдлэгийг эзэмшсэний үндсэн дээр гэрлэлтийг дуусгавар болгох зохицуулалтын нийтлэг болон ялгаатай талыг харьцуулан тодорхойлох, хууль зүйн дүгнэлт хийх, хуулийг сонгон хэрэглэх, түүний үр дагаврыг тайлбарлах чадварыг эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлах** - Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахаар харилцан зөвшөөрсөн, тэдний асрамжинд 18 хүртэлх насны төрсөн болон үрчилсэн хүүхэд байхгүй, эд хөрөнгийн болоод бие биеэ тэжээн тэтгэх, тэтгүүлэх талаар маргаангүй тохиолдолд гэрлэлтээ цуцлуулахаар оршин суугаа газрынхаа сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт өргөдөө хамтран гаргаснаар захиргааны байгууллага хуульд заасан журмаар гэрлэлт цуцлах эсэх асуудлыг шийдвэрлэж байгаа ажиллагааг хэлнэ.

**Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах** - Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, ИХШХШ тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ. Гэрлэгчдийн гаргасан гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэхийг шүүхийн журмаар гэрлэлт цуцлах гэж ойлгоно.

**Гэрлэлтийг цуцлах журам** Захиргааны журмаар гэрлэлтийг цуцлахын тулд гэрлэгчид энэ талаар харилцан тохиролцсон байх ёстой. Өргөдлөө хамтран гаргаж байгаа нь гэрлэгчид захиргааны журмаар гэрлэлт цуцлуулахаар харилцан зөвшөөрснийг илтгэж байгаа юм.

Тэд өргөдөлдөө гэрлэгчдийн овог, эцгийн нэр, нэр гэрлэлтийн гэрчилгээний дугаар болон гэрлэлтээ цуцлуулах талаар харилцан зөвшөөрсөн байдал, төрсөн болон үрчлэн авсан 18 хүртэлх насны хүүхэдгүй гэдгээ тодорхойлон зааж, түүнийг нотолсон баримт бичгийг хавсаргана. Сум, дүүргийн Засаг дарга өргөдлийг хүлээн авч хянаад 30 хоногийн дотор гэрлэлтийг цуцлах эсэхийг шийдвэрлэнэ. Захиргааны журмаар гэрлэлт цуцлахад гэрлэгчдийг биечлэн байлцуулах ба хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрлэгчид байлцах боломжгүй бол түүнийг байхгүйд гэрлэлт цуцлахыг зөвшөөрсөн, нотариатаар гэрчлүүлсэн өргөдлийг үндэслэн гэрлэлт цуцалсныг бүртгэж, гэрчилгээ олгоно.

Шүүхийн журмаар гэрлэлтийг цуцлах: Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэлийг шүүхийн нутаг дэвсгэрийн нийтлэг харъяаллын дагуу хариуцагчийн оршин суугаа газрын харьяа шүүхэд гаргах бөгөөд нэхэмжлэгч нь бага насны хүүхэдтэй буюу тахир дутуу, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газарт



очиход бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

Мөн түүнчлэн нэхэмжлэгч, хариуцагч маргааныг хэнийх нь оршин суугаа газрын харьяа шүүхээр хянан шийдвэрлүүлэх вэ? гэдгийг тохиролцон тогтоож болно. Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэл нь ИХШХШ тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрдүүлбэрийг хангасан байхаас гадна гэрлэлтээ хэзээ, хаана бүртгүүлсэн, гэрлэлт цуцлах болсон шалтгаан, төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн байдал, насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх, тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаар ямар хүсэлт гаргаж байгаагаа нэхэмжлэлд тодорхойлон бичиж холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.

Шүүх гэрлэлт цуцлах хэргийг хянан шийдвэрлэхдээ насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх, хүүхдийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, гэр бүлийн гишүүний хуваарьт болон хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах талаарх маргаан гарвал асуудлыг хамтатган шийдвэрлэнэ



### Хяналтын асуулт:

1. Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах үед ямар асуудлыг харилцан тохиролцож болох вэ?
2. Гэрлэгчдийн харилцан тохиролцоогүй асуудлыг шүүхээс хэрхэн шийдвэрлэх вэ?
3. Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн ямар маргааныг шүүх ердийн журмаар шийдвэрлэх вэ?
4. Захиргааны болон шүүхийн журмаар шийдвэрлэх гэр бүлийн маргааны онцлогийг тодорхойлно уу?
5. Гэрлэгчид эвлэрч шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж хүчин төгөлдөр байхад гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэлийг дахин гаргаж болох уу?



### Сорил

1. **Шүүхээс гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ урьдчилан авах арга хэмжээг нэрлэнэ үү?**
  - a. Хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилуулах
  - b. Шүүхийн зардлын тодорхой хувийг урьдчилгаа болгон төлүүлэх
  - c. Эхнэр, нөхрийн эрүүл мэндийн үзлэгт хамруулахыг даалгах
  - d. Эд хөрөнгийн маргааныг тусгаарлан шийдвэрлэх
2. **Шүүх гэрлэлт цуцлах үед насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх вэ? гэдгийг шийдвэрлэхэд насны байдлыг харгалзан хүүхдээс санал авах шаардлагатай юу?**
  - a. Шаардлагагүй. Хуульд энэ тухай заагаагүй.
  - b. Шаардлагатай. 9 насанд хүрсэн бол.
  - c. Шаардлагатай. 7 ба түүнээс дээш настай бол.
  - d. Шаардлагагүй. Хуульд эхийн асрамжинд хүүхдийг үлдээх зохицуулалттай.

3. Шүүхээс гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авах боломжит хугацааг тодорхойлно уу?
  - a. 6 сар хүртэл
  - b. 4 сар хүртэл
  - c. 3 сар хүртэл
  - d. 2 сар хүртэл
4. Гэрлэлт цуцлахыг хориглох шалтгаанд аль нь хамаарагдахгүй вэ?
  - a. Эхнэр нь жирэмсэн
  - b. Нэхэмжлэгч хүндээр өвчилсөн
  - c. Хүүхэд нь нэг нас хүрээгүй
  - d. Хариуцагч хүндээр өвчилсөн
5. Шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг шүүх хуралдаанаар хэлэлцэхдээ гэрлэгчдийг заавал байлцуулах зорилгоор шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулав. Энэ тохиолдолд:
  - a. Гэрлэгчдийн төлөөлөгч, өмгөөлөгч хуралдаанд ирсэн тул энэ нь буруу
  - b. Гэрлэгчид нь шүүх хуралдаанд ирэх үүрэгтэй
  - c. Гэрлэгчдийг байлцуулалгүйгээр хэргийг шийдвэрлэх боломжтой
  - d. Энэ тухай хуульд тодорхой заагаагүй
6. Гэрлэгчдэд эвлэрэх хугацаа өгч болохгүй нөхцөлийг нэрлэнэ үү?
  - a. Хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй
  - b. Гэрлэгчид эцэг байх эрхээ хасуулсан
  - c. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр худалдан борлуулсан гэдэг нь тогтоогдсон
  - d. Эхнэр, нөхөр 3 жилээс доошгүй хугацаанд хамт амьдраагүй
7. Шүүх нь гэрлэгчдийн эвлэрлийг баталж, захирамж гарган хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Дүгнэлт хийнэ үү?
  - a. Шүүхийн шийдвэр үндэслэлтэй зөв
  - b. Шүүхийн шийдвэр үндэслэлгүй байна
  - c. Шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон эвлэрлийг батлах нь үндэслэлтэй
  - d. Аль нь ч биш
8. Гэрлэгчид хамтран өмчлөх дундын хөрөнгөө хуваах асуудлаар маргахад тэдний хооронд байгуулсан эд хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг удирдлага болгон шүүх маргааныг хянан шийдвэрлэжээ. Энэ тохиолдолд гэрлэгчид маргаанаа иргэний хуулийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах журмыг баримтлах нь үндэслэлтэй гэж гомдол гаргав.
  - a. Уг гэрээ нь хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон бол хуулийн дагуу шийдвэрлэнэ
  - b. Зөвхөн гэрээг үндэслэн шийдвэрлэнэ
  - c. Шүүх гэрээг, эсвэл хуулийг хэрэглэх эсэхээ шийдвэрлэнэ
  - d. Гэрлэлт цуцлахад хэн нь буруу эсэхийг харгалзаж хуулийн дагуу шийднэ
9. Гэрлэлт цуцалсан тухай шийдвэрийг ямар хугацаанд иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад хүргүүлэх вэ?
  - a. Уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 14 хоногийн дотор
  - b. Уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 7 өдрийн дотор
  - c. Уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 өдрийн дотор
  - d. Уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 10 хоногийн дотор



10. Шүүх Ц, Б нарын гэрлэлтийг цуцалж 14 настай охин О-д эцэг Б-гээс нь сар бүр тэтгэлэг гаргуулахаар шийдвэртээ заажээ. О-д сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг тодорхойлно уу?

- Б-гийн сар бүрийн цалин орлогын 20 хувиар тэтгэлэг тогтоох*
- Б нь цалин, орлогогүй тул сар бүр тогттол 12000 төгрөг олгох*
- Хөдөлтөрийн хөлсний доод хэмжээгээр тэтгэлэг тогтоох*
- Бус нутагт тогтоогдсон амжиргааны доод тувшингийн хэмжээгээр тогтооно*

Σ

### Бодлого

1. Иргэн Надмид гэрлэлтээ цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ. Шүүх хуралдаанаар нэхэмжлэлийг хэлэлцэх явцад Надмидын иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлаж, харгалзан дэмжигчээр түүний эхнэр Байгалийг тогтоосон нь холбогдох нотлох баримтаар тогтоогдсон байна. Байгаль Надмид түүний зөвшөөрөлгүйгээр гэрлэлт цуцлуулах талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэж маргажээ.

Энэ тохиолдолд:

1. Надмид гэрлэлт цуцлуулах талаар нэхэмжлэл гаргах эрхтэй эсэхэд дүгнэлт хийнэ үү?
2. Оргилон Хулганаа хоёр 2001 онд танилцаж, 2003 онд гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Энэ үед тэд 24 настай байжээ. 2006 он гарсаар тэдний хоорондын үл ойлголцох байдал улам даамжирснаар гэрлэлтээ цуцлуулах болсон. Энэ үед эд хөрөнгөө хэрхэн хуваарилах талаар харилцан маргаангүйгээр тохиролцсон бөгөөд охин Номин-Эрдэнийг ээж Хулганаа асрамжиндаа авахаар тохиролцсон. Нэгэнт гэрлэлт цуцлуулах, эд хөрөнгө болон хүүхдийн асрамжийн талаар хэн ч маргахгүй харилцан зөвшөөрсөн учраас гэрлэлтээ бүртгүүлсэн Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн байгууллагад өргөдлөө гаргаж гэрлэлтээ цуцлуулахаар хандсан байна. Өргөдөл гаргах үед эхнэр Хулганаа нь жирэмсэн байсан боловч энэ байдлаа нууцлахаар шийдсэн.

Энэ тохиолдолд:

1. Захиргааны журмаар гэрлэлтийг цуцалж болох уу? Эрх зүйн зохицуулалтын хувьд ямар үр дагавар үүсэх вэ?
2. О, Х нарын үйлдэлд дүгнэлт хийнэ үү?



**Даалгавар:**

Гэрлэлт цуцлах талаарх нэхэмжлэлийн үлгэрчилсэн загварыг үндэслэн гэрлэлтээ цуцлуулахыг хүссэн 3-аас доошгүй хэргийн материалтай танилцан нэхэмжлэл бичнэ үү? Загвар

..... шүүхэд

Гэрлэлт цуцлуулах тухай

Нэхэмжлэгч. .... /овог, нэр/

Хаяг, холбогдох утас

Хариуцагч. .... /овог, нэр /

Хаяг, холбогдох утас

Би хариуцагч. ....тай. ..оны. ..сарын. ..өдөр хууль ёсоор гэрлэлтээ бүртгүүлснээр бидний хооронд гэрлэгчдийн эрх, үүрэг үүссэн билээ. Энэ үеэс эхлэн бид хамт амьдарсан бөгөөд хамтын амьдралын явцад охин, хүү. ....

..... /хүүхдийн нэр, төрсөн он, сар, өдөр, насыг тодорхой бичнэ/ нарыг төрүүлэн өсгөж байна. Хамт амьдарсан эхний жилүүдэд бид бие биедээ халамжтай, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд хоёулаа оролцож, бидний амьдрал болж байсан юм. Гэтэл сүүлийн жилүүдэд бид үзэл бодол, зан байдлын хувьд хоорондоо таарч тохирохоо больж, үргэлж маргалдаж хэрэлдэх болсон. /Гэрлэлт цуцлах болсон шалтгаанаа тодорхой заана/. Энэ байдал нь хүүхдүүдийн эрх ашиг, хүмүүжилд муугаар нөлөөлөх болсон учраас цаашид хамт амьдрах ямарч боломжгүй болж байна.

Иймд. ....оны. ....тоот гэрлэлтийн гэрчилгээтэй бидний гэрлэлтийг цуцлалж өгнө үү?

Би хүү....., охин..... нарыг өөрийнхөө асрамжинд авахыг хүсэж байгаа бөгөөд хүүхдүүддээ хуульд заасны дагуу тэтгэлэг гаргуулахыг хүсэж байна.

Гэрлэлтийн явцад бий болсон эд хөрөнгийн талаар маргах зүйлгүй болохыг харгалзан үзнэ үү? /..... эд хөрөнгийн талаар маргаантай тул хуулийн дагуу шийдвэрлэж өгнө үү./

Нэхэмжлэлд хавсаргасан баримт:

1. Гэрлэлтийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/

3. Хүүхдүүдийн төрсний гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/

4. Засаг даргын тодорхойлолт

5. Хүүхдийн эрүүл мэндийн байдлыг илэрхийлсэн өрхийн эмчийн тодорхойлолт

6. Нэхэмжлэгч, хариуцагчийн цалин хөлс, орлогын тодорхойлолт

7. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт

8. Эд хөрөнгийн талаарх нотлох баримт /байрны гэрчилгээ, машин гэх мэт/

9. Дундын эд хөрөнгийн жагсаалт болон үнэлгээ

Нэхэмжлэл гаргасан: .....



**Эх сурвалж:**

- |   |         |
|---|---------|
| 1. Гэр бүлийн тухай хууль                   | 1999 он |
| 2. Иргэний бүртгэлийн тухай хууль.          | 1999 он |
| 3. ИХШХШ тухай хууль                        | 2002 он |
| 4. Улсын Дээд шүүхийн тайлбар               | 2002 он |
| 5. Монгол улсын ИХШХШ тухай хуулийн тайлбар | 2006 он |



## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

### Сэдвийн агуулга

Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хүчирхийллийн хэлбэр  
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ  
Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ

### Сэдвийн зорилго

Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хэлбэр, түүнээс урьдчилан сэргийлэх болон таслан зогсоох арга хэмжээний талаар судалж онолын зохих мэдлэг олж авах, хуулийн заалтыг зөв ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэн хуулийг тайлбарлан таниулах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлж асуудалд хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшинө.



### Нэр томъёоны тайлбар

**Гэр бүлийн хүчирхийлэл** - Гэр бүлийн хүрээнд гэрлэгчид, төрөл садангийн хүмүүс болон гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөө этгээдийнхээ эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан эсвэл учруулахаар занал хийсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ

**Болзошгүй хүчирхийлэл** - Тухайн нөхцөл байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэхээр эсвэл хүчирхийлэл дахин үйлдэгдэхээр байгааг ойлгоно

**Хохирогч** - Хүчирхийлэлд өртөж буй этгээдийг хэлнэ

**Хүчирхийлэгч** - Хүчирхийллийг үйлдэж буй этгээдийг хэлнэ

**Хамгаалах байр** - Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсвэл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулж хохирогчид үйлчилгээ үзүүлэх газрыг ойлгоно

**Албадан сургалт** - Хүчирхийлэл үйлдэгчид гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаанаас үүссэн асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн зохих хөтөлбөрийн дагуу явуулах сургалтыг хэлнэ

**Хохирогчид үзүүлэх үйлчилгээ** - Хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэхүй нь түр хямарсан үед эмчилгээ хийх нөхөн сэргээх ажиллагааг ойлгоно

**Эрх хязгаарлах арга хэмжээ** - Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх албадлагын арга хэмжээг хэлнэ

**Хохирогчийг төрөл садангийн хүнийх нь түр хамгаалтанд өгөх** - Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчээс хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор эрх бүхий байгууллагаас хүчирхийлэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авч шийдвэр гарах хүртэлх хугацаанд түүнийг төрөл садангийн хүнтэй нь хамт байлгахыг ойлгоно

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч** - Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдсон аливаа хэрэг маргаанд хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах үүрэг бүхий, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагаас итгэмжлэгдсэн этгээдийг хэлнэ

**Тусдаа амьдрахыг даалгах** - Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон үйлдэж болзошгүй этгээдийг хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүчирхийлэл үйлдэгдэх бололцоо, нөхцөл шалтгааныг арилгах хүртэлх хугацаанд хохирогчтой хамт нэг гэрт амьдрахгүй байхыг шүүхээс түүнд үүрэг болгохыг ойлгоно


**Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, хэлбэр** Гэрлэгчид болон гэр бүлийн гишүүд нь бие биенээ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд нь шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх үүргийг хүлээнэ.

**Монгол Улсын Үндсэн хууль / 19§ /**


*“Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх дээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй ”*



**Төрийн үүрэг**

- Хүний эрх, эрх чөлөөг хангахуйц баталгааг бүрдүүлэх
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх
- Хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх



Хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсний, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосны үр дүнд тухайн иргэний асрамжинд байгаа этгээд





**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийг зөрчиж буй хууль бус үйлдэл тул түүнтэй тэмцэж урьдчилан сэргийлэх нь нэн чухал ач холбогдолтой юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хууль дээдлэх
- Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх
- Хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг авах
- Хохирогчийн аюулгүй байдлыг хангах
- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг:

**Төрийн байгууллага, түүний бүрэн эрх**





- Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох талаар онцгой үүрэг хүлээнэ. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйл/
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллага болон нийгмийн ажилтны үүрэг ч чухал ач холбогдолтой. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар бүлэг/

**Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ**

Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий тохиолдолд эрх бүхий байгууллагаас хуульд заасан журмын дагуу хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчид авч буй арга

хэмжээний цогц юм.

Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ нь:

- Мэдээлэл өгөх, хүлээж авах
- Хохирогчийг хамгаалах
- Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг багтаана





Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйл/

Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэрийг гаргахад дараах нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Үүнд:

- Хохирогчтой удаа дараа хэрцгий хандсан, заналхийлсэн, хүч хэрэглэсэн
- Хүчээр бэлгийн харилцаанд оруулсан буюу оруулахыг завдсан
- Хохирогчийг төрөл садан, хамт олноос нь тусгаарлаж сэтгэл санааны хүнд дарамтанд оруулсан
- Тэжээн тэтгэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн буюу хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулж байсан
- Согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга буюу удаа дараа хэрэглэж хохирогчийг айдас, түгшүүрт байдалд оруулсан
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээдийн хэн нэгний амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учирч болзошгүй байгаа



#### Хяналтын асуулт:

1. Тэгш бус харилцаа ба хүчирхийлэл гэсэн ойлголтуудыг тайлбарлана уу?
2. Гэр бүлийн зохистой харилцааны үр дагавар юу вэ?
3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх болсон шалтгаан нөхцөл юу вэ?
4. Хүчирхийлэл үйлдэгчийн хяналтаа тогтоох хэлбэрүүд хэрхэн илрэх вэ?



5. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхэд баримтлах цогц стратеги гэдэгт юуг хамааруулах вэ?
6. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхэд юуг анхаарах вэ?
7. Хохирогчийн болон хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангах үүднээс цагдаагийн байгууллага ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?
8. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх нотлох баримтыг бэхжүүлэх талаар цагдаагийн байгууллага ямар ажиллагаа явуулах ёстой вэ?
9. Нотлох баримтад юуг хамруулж болох вэ? Энэ нь ямар ач холбогдол, онцлогтой вэ?
10. Хүчирхийллийн болзошгүй эрсдэл гэж юуг ойлгох вэ? Түүнийг хэрхэн үнэлэх вэ?
11. Хүчирхийлэл үйлдэгдсэн орчны сөрөг нөлөөг судлахад шаардлагатай асуултуудыг тодорхойлно уу?
12. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийн агуулга ямар байвал илүү үр дүнтэй вэ?



### Сорил

1. **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь:**
  - a. Монгол Улсын Үндсэн хууль, эрүүгийн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас
  - b. Монгол улсын Үндсэн хууль Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах хууль энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас
  - c. Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль энэ хууль болон тэдгээртэй Нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
2. **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зохицуулалтад хамаарах этгээдийг нэрлэнэ үү?**
  - a. Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн
  - b. Гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс
  - c. Хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсний эсхүл асран хамгаалагч, харгалзан дэтжигч тогтоосны үндсэн дээр тухайн иргэний асрамжид байгаа этгээд
  - d. Бүгд нэгэн адил хамаарна.
3. **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар Засгийн газрын бүрэн эрх нь.**
  - a. Хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээг зохион байгуулах
  - b. Бодлого, хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх
  - c. Хамгаалах байранд тавигдах стандарт шаардлагыг тодорхойлох
  - d. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг баталж, мөрдүүлэх

4. **Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар цагдаагийн байгууллагын хүлээх үүрэг нь :**
  - a. *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих*
  - b. *Гомдлыг хүлээн авч бүртгэх, хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж тэмдэглэл хөтлөх*
  - c. *Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх мэдээ тайлан гаргах*
  - d. *Харъяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах*
5. **Хохирогчийг хамгаалах арга хэмжээ нь**
  - a. *Хохирогчийг хамт олны хамгаалтад өгөх*
  - b. *Нийгмийн ажилтны хамгаалтад түр өгөх*
  - c. *Хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл өгөх, сэтгэхүй нь түр хямарсан үед эмчилгээ хийх*
  - d. *Хүчирхийлэл үйлдэгчээс гэрлэлтээ цуцлуулах*
6. **Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах зорилгоор дараах арга хэмжээг авна**
  - a. *Тэжэээн тэтгэх үүргийг албадан хэрэгжүүлэх*
  - b. *Тусдаа амьдрахыг даалгах*
  - c. *Эцэг, эх, төрөл садны хүний түр хамгаалалтанд өгөх*
  - d. *Албан байгууллагад мэдэгдэх*
7. **Хохирогчийн амь нас эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг:**
  - a. *Цагдаагийн байгууллага*
  - b. *Засаг дарга*
  - c. *Шүүх*
  - d. *Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв гаргана*
8. **Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай гомдлыг хүлээн авснаас хойш шийдвэрийг**
  - a. *6 цагийн дотор*
  - b. *12 цагийн дотор*
  - c. *24 цагийн дотор*
  - d. *72 цагийн дотор гаргана.*
9. **Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг дараах хугацаагаар авч болно**
  - a. *6 сар*
  - b. *6 сар хүртэл*
  - c. *1 жил*
  - d. *1 жил хүртэл*



### Даалгавар:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу бэлтгэсэн CD үзэж хэлэлцүүлэг явуулах ба гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага, түүний үндэслэлийг тодорхойлно уу?



### Эх сурвалж:

- |  |         |
|--|---------|
| 1. Монгол Улсын Үндсэн хууль   | 1992 он |
| 2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль                          | 2002 он |
| 3. Улсын Дээд Шүүхийн 47 дугаар тогтоол                                  | 2006 он |
| 4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх,<br>урьдчилан сэргийлэх арга зам УБ. | 2003 он |
| 5. Хүний эрхийн үндэсний комисс гурван жил /80-85 т/ УБ.                 | 2004 он |
| 6. Ц. Алтанцэцэг Иргэн бизнесийн эрх зүйн гарын авлага                   | 2005 он |
| 7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги                        | 2005 он |

## ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БАЙДЛЫН БҮРТГЭЛ

### Сэдвийн агуулга

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ойлголт, ач холбогдол  
Иргэний бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн зарчим, ажилтны эрх, үүрэг  
Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн төрөл, бүртгэл хөтлөх журам  
Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, дахин олгох, хүчингүй болгох, сэргээн тогтоох журам

### Сэдвийн зорилго

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн асуудалтай танилцсанаар иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн төрөл, бүртгэлийн байгууллагын чиг үүрэг, бүртгэх журмын талаар онолын мэдлэг олгох, холбогдох хууль тогтоомж, баримт бичгийг судалж танин мэдсэнээр шаардлагатай баримт бичгийг тодорхойлох, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх, бүртгэлийн маягт, анкетыг үйлдэх, тайлбарлах, хууль зүйн үнэлэлт дүгнэлт хийх чадварыг эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Иргэний бүртгэл** - Иргэний эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх дуусгавар болохтой холбогдох Иргэний бүртгэлийн тухай хуульд заасан үйл ажиллагааг ойлгоно.

**Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл** - Иргэний бүртгэлийн нэг төрөл нь иргэний гэр бүлийн байдлын бүртгэл юм. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд төрсний, гэрлэлтийн, гэрлэлт цуцалсны, гэрлэлт сэргээсний, үрчлэлтийн, эцэг, эх тогтоосон, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний, нас барсны, хүйс өөрчлөгдсөний бүртгэл хамаарна.

**Төрсний бүртгэл** - Хүүхэд төрснөөр эцэг, эх, хүүхдийн хооронд үүссэн харилцааг эрх бүхий байгууллагаас хууль зүйн дагуу баталгаажуулж байгаа иргэний бүртгэлийн ажиллагааг ойлгоно

**Гэрлэлтийг бүртгэл** – Гэрлэлтийг хууль зүйн дагуу эрх бүхий байгууллагаас баталгаажуулж байгаа иргэний бүртгэлийн ажиллагааг ойлгоно.

**Гэрлэлт цуцалсны бүртгэл** - Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан иргэний гэрлэлт цуцалсныг эрх бүхий байгууллагаас хуульд заасан журмын дагуу баталгаажуулж байгаа иргэний бүртгэлийн ажиллагааг ойлгоно

**Гэрлэлт сэргээсний бүртгэл** - Хуульд заасан үндэслэл журмын дагуу нөхөр, эхнэрийн гэрлэлт сэргээгдсэнийг эрх бүхий байгууллагаас хууль зүйн дагуу баталгаажуулж байгаа иргэний бүртгэлийн ажиллагааг ойлгоно

**Үрчлэлтийн бүртгэл** - Үрчлэгч, үрчлүүлэгчийн хооронд эцэг, эх, хүүхдийн харилцаа үүссэнийг эрх бүхий байгууллагаас хууль зүйн дагуу баталгаажуулж байгаа иргэний бүртгэлийн ажиллагааг ойлгоно

**Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ойлголт ач, холбогдол**

Иргэний бүртгэл нь нэг талаар иргэний эрх зүйн байдлыг тодорхойлохын зэрэгцээ нөгөө талаар түүний төрийн хамгаалалтад байгааг илэрхийлж, хамгаалуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. Иргэний бүртгэл нь иргэний эрх



зүйн байдлыг тодорхойлж байгаа хууль зүйн факт төдийгүй хувь хүний эрх, ашиг сонирхолд шууд хамаарах юм.

Иргэний бүртгэл болон түүнийг эрхэлж байгаа байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг 1999 онд батлагдсан Иргэний бүртгэлийн тухай хуулиар зохицуулна. Иргэний бүртгэлд гэр бүлийн байдлын, хүн амын өрхийн, иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспортын, шилжилт хөдөлгөөний гадаадын иргэний бүртгэл зэрэг бүртгэлүүд хамаарна.

Манай улсад иргэний бүртгэлийн үйл ажиллагааг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв эрхлэн явуулна. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл мэдээллийн алба, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан, хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар тогтоосон журмын дагуу иргэний бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулна.

Иргэний бүртгэлийн нэг төрөл нь Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл юм. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн зорилго нь иргэний болон төрийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх, ашиг сонирхлыг хамгаалахад оршино. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл нь төрсний, гэрлэлтийн, гэрлэлт цуцалсны, гэрлэлт сэргээсний үрчлэлтийн, эцэг, эх тогтоох, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний, нас барсны, хүйс өөрчилсний бүртгэл гэсэн төрлүүдтэй байна. Эдгээр бүртгэлийн төрлүүдийн талаар гэрлэлт, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн бус амины харилцаа, үрчлэлт зэрэг сэдвийн хүрээнд тус бүрийг тодорхой судлах шаардлагатай. Иргэний бүртгэлд нэмэлт, өөрчлөлтийг тогтоосон журмын дагуу гүйцэтгэх ба тухайлбал үрчлэлтийг бүртгэсэн бүртгэл, эцэг тогтоосны болон иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчилснийг бүртгэсэн бүртгэл, шүүхийн шийдвэр зэргийг үндэслэн иргэний бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулна.

**Төрсний бүртгэл** Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу хүүхэд төрснийг бүртгэнэ. Эцэг, эх хүүхдээ төрснөөс хойш төв суурин газарт бол 15 хоног, алслагдсан сум, багт бол 30 хоногийн дотор хүүхэд төрснийг бүртгүүлэх үүргийг хуулиар хүлээж байдаг.

Хүүхэд төрснийг бүртгэхдээ хүүхдийн эцэг, эхийн оршин суугаа, эсхүл хүүхдийн өөрийнх нь төрсөн газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан хүүхэд төрсөн тухай эмнэлгийн магадлагаа, эрүүл мэндийн дэвтэр, эсхүл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас эмнэлгийн магадлагаа авах боломжгүй нөхцөлд төрсөн бол хөндлөнгийн гэрчийн тодорхойлолт, эцэг, эхийн гэрлэлтийн гэрчилгээ, эцэг, эхийн иргэний үнэмлэх зэрэг баримт бичгийг үндэслэн бүртгэнэ. Хүүхдийн эцэг буюу эх өөрийн биеэр бүртгэх байгууллагад ирж хүүхдээ бүртгүүлэх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ирэх боломжгүй бол тэдний төрөл садан, эмнэлгийн байгууллагын эрх бүхий ажилтан гэрт нь хүүхдийг бүртгэх ажиллагааг явуулж болох тухай Иргэний бүртгэлийн тухай хуульд заасан.

**Гэрлэлтийн бүртгэл** Гэрлэлтийг төрийн байгууллага буюу сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт бүртгэнэ. Харин гэрлэлтээ бүртгүүлэхдээ гэрлэгчид заавал биеэр байлцах шаардлагатай ба гэрлэхийг хүсэгчдийн хамтран гаргасан өргөдөл, иргэний үнэмлэх, эрүүл мэндийн тодорхойлолт /өөрсдийн оршин суугаа газрын эмнэлгийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн байна/ зэргийг үндэслэн бүртгэнэ Иргэний бүртгэлийн ажилтан гэрлэгчдийн өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гэрлэлтийг бүртгэнэ. Гэрлэлтийг бүртгэсэн өдрөөс эхлэн гэрлэгчдийн эрх, үүрэг үүснэ.

**Гэрлэлт цуцалсны бүртгэл** Гэрлэлтийг цуцалсан тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш шүүх ажлын 3 өдрийн дотор гэрлэлтийг бүртгэсэн Иргэний бүртгэлийн байгууллагад шийдвэрийг явуулна. Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан иргэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 10 хоногийн дотор гэрлэлт цуцалсны бүртгэлийг хийлгэнэ. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан холбогдох баримт бичгийг хүлээн авч, гэрлэлт цуцалсныг бүртгэж гэрчилгээ олгоно. Харин захиргааны журмаар гэрлэлт цуцалж байгаа тохиолдолд гэрлэгчид хүсэлтээ Иргэний бүртгэлийн байгууллагад гаргана. Иргэний бүртгэлийн байгууллага гэрлэлтийг цуцалж, гэрлэлт цуцалсны гэрчилгээ олгоно.

**Гэрлэлт сэргээсэн бүртгэл** Гэрлэлтээ цуцлуулсан хүмүүс эвлэрснээ хамтран илэрхийлж, өргөдөл гаргасан бөгөөд өөр хүнтэй гэрлээгүй бол гэрлэлтийг сэргээнэ. Сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүн эргэж ирж, нөхөр буюу эхнэр нь өөр хүнтэй гэрлээгүй бол Иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага гэрлэлтийг сэргээж бүртгэл үйлдэнэ.

**Үрчлэлтийн бүртгэл** Үрчлэгч нь хүүхэд үрчлэн авсан тухайгаа Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгүүлнэ. Үрчлэлтийг бүртгэхдээ хүүхдийн төрсний гэрчилгээг шинээр бичиж, үрчлэн авсан эцэг, эхэд олгоно. Харин хүүхдээ үрчлүүлсэн эцэг, эхэд хүүхэд үрчлүүлсний гэрчилгээ олгоно. Хүүхэд үрчлүүлсний гэрчилгээнд хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, төрсөн газар, үрчилж авсан болон үрчлүүлсэн эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн овог, эцгийн нэр, нэр үрчилсний бүртгэл үйлдсэн газрын нэр, гэрчилгээний дугаар, үрчилсэн бүртгэл үйлдсэн албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг зэргийг тусгасан байна.



**Хяналтын асуулт:**

1. Иргэний бүртгэлийн тухай ойлголт, үйл ажиллагааны зарчмын талаар хэлэлцэнэ үү?
2. Иргэний бүртгэлийн нэгэн төрөл болох иргэний гэр бүлийн байдлын бүртгэлтэй холбогдсон харилцаа нь гэр бүлийн эрх зүйн зохицуулах зүйлд хамаарах эсэх талаар авч үзэж судална уу?
3. Төрснийг бүртгэхэд ямар баримт бичиг шаардлагатай вэ? Хүүхэд төрснийг бүртгэсний ач холбогдол юунд орших вэ?
4. Гэрлэлтийг хэрхэн бүртгэх, түүний үр дагаврын талаар хэлэлцэнэ үү?
5. Хүүхэд үрчилсний бүртгэлийг хэрхэн үйлдэх вэ?
6. Хүүхдийн эцэг, эх тогтоосны бүртгэлийн талаар ярилцана уу?
7. Нас барсны бүртгэлийг тайлбарлана уу?
8. Овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл гэдгийг тайлбарлана уу?
9. Иргэний бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулж болох уу?
10. Иргэний бичиг баримтыг дахин олгож болох уу?
11. Иргэний бүртгэлд хийсэн бичилтийг сэргээн тогтоох, хүчингүй болгоход ямар журмыг баримтлах вэ?



## Сорил

1. **Гэрлэлтийг бүртгэдэг эрх бүхий этгээдийг олно уу?**
  - a. Шүүх
  - b. Хийд болон сүмийн захиргаа
  - c. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн байгууллага
  - d. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага
2. **Гэрлэгчдийн эрх, үүрэг хэзээ үүсэх вэ?**
  - a. Хурим, найр хийсэн үеэс
  - b. Хамтран амьдарсан өдрөөс
  - c. Гэрлэх өргөдлөө эрх бүхий байгууллагад гаргасан өдрөөс
  - d. Эрх бүхий байгууллага гэрлэлтийг бүртгэсэн өдрөөс
3. **Гэрлэлт бүртгүүлэх тухай өргөдлийг хүлээн авснаас хойш ямар хугацаанд гэрлэлтийг бүртгэдэг вэ?**
  - a. Өргөдөл хүлээн авсан өдөр
  - b. Өргөдөл хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор
  - c. Өргөдөл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор
  - d. Өргөдөл хүлээн авснаас хойш хэдийд ч болно
4. **Эрх бүхий байгууллага гэрлэлтийг бүртгэхээс татгалзвал ямар байгууллагад гомдол гаргаж болох вэ?**
  - a. Дээд шатны албан тушаалтанд
  - b. Шүүхэд
  - c. Улсын байцаагчид
  - d. Энэ талаар хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй
5. **Үрчлэлтийн нууцыг хадгалах эрхтэй этгээдийг нэрлэнэ үү?**
  - a. Төрүүлсэн эцэг, эх, ах, дүү
  - b. Үрчлэгч
  - c. Үрчлүүлэгч
  - d. Хүүхдийн үрчлэлтийг бүртгэсэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн ажилтан
6. **Үрчлэлтийн бүртгэлийг хэрхэн хийх вэ?**
  - a. Үрчлэлтийг шийдвэрлэсэн сум дүүргийн Засаг даргын захирамж гарсан учраас дахин бүртгэх шаардлагагүй
  - b. Хүүхдийн төрсний гэрчилгээг шинээр бичиж, үрчлэн авсан эцэг, эхэд олгоно
  - c. Хүүхэд үрчлүүлсний гэрчилгээг хүүхдээ үрчлүүлсэн эцэг, эхэд олгоно.
  - d. Үрчлэгдэж байгаа хүүхдийн төрсний бүртгэлийн талаарх материал архивт байхгүй бол үрчлэлтийг бүртгэхгүй ба үүнийг шүүх шийдвэрлэнэ



### Бодлого

Бага наснаасаа бие биеэ сайн таньдаг байсан Цэцгээ, Өлзий нар сургуульд нэг ангид суралцах болсон үеэс эхлэн хайр сэтгэлийн холбоотой болжээ. Тэд дотно харьцаа тогтоосноос хойш 6 сар өнгөрөхөд Цэцгээгийн хөл нь байнга өвдөх болсон. Эмнэлгийн бүх төрлийн шинжилгээнд хамрагдахад Цэцгээгийн өвчний онош нь ясны хорт хавдар болох нь тогтоогдсон. Уг өвчин нь цаашид бүрэн төгс эмчлэгдэх боломжгүй болох талаар ч эмч тодорхой тайлбарлаж өгчээ.

Өлзий Цэцгээд гэрлэх санал тавихад тэрээр хүлээн зөвшөөрсөн байна. Энэ үед Өлзий 18 настай, Цэцгээ 17 настай байв. Өлзий өөрийн оршин суугаа газрын харъяа иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад гэрлэлтээ бүртгүүлэх тухай өргөдөл гаргаж, хэдийгээр Цэцгээ нь гэрлэх 18 насанд хүрээгүй боловч тэд гэр бүл болсоор 7 сар өнгөрч байгаа. Цэцгээгийн биеийн эрүүл мэндийн байдлыг харгалзан хүндэтгэн үзэх шалтгаан байгааг дурьджээ. Иргэний бүртгэлийн ажилтан Өлзийгийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан байна.

Энэ тохиолдолд:

1. Иргэний бүртгэлийн ажилтан Өлзий, Цэцгээ нарын гэрлэлтийг бүртгэхээс татгалзсан нь үндэслэлтэй эсэхэд дүгнэлт хийнэ үү?
2. Өлзий, Цэцгээ нарт эрх зүйн туслалцаа үзүүлнэ үү?



### Даалгавар:

1. Энэ сэдвийн хүрээнд иргэний бүртгэлийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх баримт бичгийн үлгэрчилсэн загвар гаргана уу?
2. Төрснийг, гэрлэлт бүртгэх ажиллагаатай танилцаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлнэ үү?
3. Үрчлэлтийг бүртгэх бүртгэлийн практик ажиллагаатай танилцаж, энэ талаар гарсан сум, дүүргийн Засаг даргын захирамжийн төсөл, бусад баримт бичгийг боловсруулна уу?
4. Иргэний бичиг баримт дахин олгох талаарх хуулийн зохицуулалтыг судалж өөрсдийн саналаа бэлтгэнэ үү?



### Эх сурвалж:

- |   |         |
|---|---------|
| 1. Гэр бүлийн тухай хууль                                     | 1999 он |
| 2. Иргэний бүртгэлийн тухай хууль                             | 1999 он |
| 3. Иргэний бүртгэлтэй холбогдсон хууль тогтоомж, заавар журам | 2004 он |



## 4 БҮЛЭГ. ҮРЧЛЭЛТ

### ХҮҮХЭД ҮРЧЛЭХ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЖУРАМ, ҮР ДАГАВАР, ҮРЧЛЭЛТИЙГ ХҮЧИНГҮЙД ТООЦОХ

#### Сэдвийн агуулга

Үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтын ойлголт, онцлог  
Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх нөхцөл, журам, хууль зүйн үр дагавар  
Үрчлэлтийг хүчингүйд тооцох

#### Сэдвийн зорилго

Хүүхэд үрчлэх нөхцөл, журам, Монгол Улсын харъяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлүүлж болох эсэх асуудлыг танин мэдэж, энэ асуудлын эрх зүйн зохицуулалтын талаар онолын мэдлэгтэй болж түүнийг практик амьдалд зөв хэрэглэх, хэрэгжүүлэх болон бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх, тайлбарлах, дүн шинжилгээ хийх чадварыг эзэмшсэнээр үрчлэлтийн асуудалд хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшинө.



#### Нэр томъёоны тайлбар

**Хүүхэд үрчлэх** - Бусдын хүүхдийг өөрийн болгон тэжээх, үрчлүүлэх нь үрчлэхийн үйлдүүлэх хэв /Монгол хэлний тайлбар толь/

**Үрчлэлт** - Хүүхдийг өргөж авах хэлбэрээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу үрчлэгч, үрчлүүлэгчийн хооронд төрсөн эцэг, эх, хүүхдийн нэгэн адил эрх, үүргийг үүсгэж буй хууль ёсны ажиллагааг ойлгоно

**Үрчлэгч** - Хүүхдийг өргөж авч буй төрсөн эцэг, эхийн эрх, үүргийг хүлээх этгээдийг хэлнэ

**Үрчлүүлэгч** - Өргүүлсэн хүүхэд буюу төрсөн хүүхдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээх үрчлэгдсэн хүүхдийг хэлнэ

**Үрчлэх, үрчлүүлэх нөхцөл** - Үрчлэлт хүчин төгөлдөр байх хууль зүйн шаардлагыг ойлгоно

**Үрчлэлтэйг хүчингүйд тооцох** - Үрчлэлт хүчин төгөлдөр байх хууль зүйн шаардлагыг зөрчсөн, эсхүл үрчлүүлэгчийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах шаардлагатай гэж үзэх бусад үндэслэлээр шүүхээс хуульд заасан журмын дагуу үрчлэгч, үрчлүүлэгчийн хоорондын харилцааг дуусгавар болгож буй хууль ёсны ажиллагааг ойлгоно

**Үрчлэлтийг хүчингүйд тооцсоноос үүсэх үр дагавар** - Хуульд заасан үндэслэл, журмын дагуу үрчлэлтийг хүчингүйд тооцсоноор үрчлэгч, үрчлүүлэгчийн хооронд тодорхой эрх, үүргийг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгож буй хуулиар тогтоосон үр дүнг ойлгоно.

#### Үрчлэлтийн тухай ойлголт, зорилго, зарчим, журам

Үрчлэлт нь гэр бүлийн эрх зүйн системд бие даасан нэг институт бөгөөд үрчлэлтийн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох, түүнээс гарах хууль зүйн үр дагавартай холбогдон үүссэн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний нийлбэр цогц юм.

#### Үрчлэлтийн харилцааны оролцогч нь:

- Хүүхдийг үрчлүүлж буй этгээд  
/төрсөн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/

- Үрчлэгдэж буй хүүхэд / үрчлүүлэгч /
- Үрчлэн авагч этгээд /үрчлэгч/

### Үрчлэлтийн зорилго

- Хүүхдийг өв тэгш хөгжүүлэх үүднээс тэднийг гэр бүлийн болон баяр баясгалан, хайр, ойлголцлын орчинд өсгөж хүмүүжүүлэх
- Хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэн, үндсэн эрхийг хангах, хүүхэд худалдах, хулгайлах, хил дамнан худалдахаас сэргийлэх

*Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц*

*1993 онд баталж, 1995 онд хүчин төгөлдөр болсон*

### Үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтын зарчим

- Хүүхдийн дээд ашиг сонирхол, түүний үндсэн эрхийг хангах
- Гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нь нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэх

### Үрчлэлтийн систем




### Үрчлэлтийн хэлбэр

- Дотоодын үрчлэлт
- Улс хоорондын үрчлэлт

Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх нөхцлийг хуулиар тогтооно.

- Ерөнхий нөхцөл
- Тусгай нөхцөл - улс хоорондын үрчлэлт буюу гадаадын иргэн Монгол улсын харъяат хүүхдийг үрчлэн авахад баримтална.

### Үрчлэгч этгээдэд тавигдах шаардлага





### **Хүүхэд үрчлэхийг хориглох үндэслэл**

- 60-аас дээш настай
- Эцэг, эх байх эрхээ хасуулсан, хязгаарлуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан
- Урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн
- Шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон
- Сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй
- Согтууруулах ундаа, мансуурах бодис байнга хэрэглэдэг.
- Эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн
- Хорих ял эдэлж байсан.
- Ашиг хонжоо олох зорилготой

*Бүтэн өнчин, хүүхдийг төрөл садангийн хүн үрчлэн авахад дээрх насны хязгаарлалт үл хамаарна.*

### **Хүүхэд үрчлэх журам нь**

- Хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ гаргах
- Эрх бүхий этгээдүүдийн зөвшөөрлийг авах
- Эрх бүхий байгууллага шийдвэрлэх

*Хүүхэд үрчлэх тухай асуудлыг захиргааны журмаар шийдвэрлэнэ.*

### **Хүүхэд үрчлэх тухай асуудлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллага:**

- Хүүхдийн оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг дарга
- Монгол Улсын хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх алба
- Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар


### **Үрчлэлтийн бүртгэл**

Үрчлэн авагч нь хүүхдийг үрчлэн авсан тухайгаа Иргэний бүртгэлийн тухай хуульд заасны дагуу ИГБББ-д бүртгүүлнэ.

### **Үрчлэлтийн бүртгэлийг хийх эрх бүхий байгууллага нь**

- ИБМУТ
- Аймгийн Засаг даргын дэргэдэх иргэний бүртгэл мэдээллийн алба
- Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар
- Дипломат төлөөлөгчийн болон консулын газар

Үрчлэлт нь хууль ёсны үйл ажиллагаа тул хууль зүйн тодорхой үр дагаварыг үүсгэнэ.





**Гэр бүлийн хууль / 59.3§/**  
*Үрчлэгдсэн хүүхэд нь үрчлүүлсэн эцэг, эхээ тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөж, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхээ алдана.*

**Гэр бүлийн хууль /59.4§/**  
*Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авдаг үрчлэгдсэн хүүхэд нь уг тэтгэвэр авах эрхээ хэвээр эдэлнэ.*

**Үрчлэлтийг хүчингүйд тооцох**


Үрчлэлтийг хүчингүйд тооцох нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хэрэгжүүлж буй эрх зүйн зохицуулалтын механизмын нэг юм. Иймээс хуульд заасан журмын дагуу үрчлэлтийг хүчингүйд тооцно.





Үрчлэлтийг хүчингүйд тооцох асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэх ба ИХШХШ тухай хуульд заасны дагуу онцгой ажиллгааны журмаар шийдвэрлэнэ.

### Үрчлэлтийг хүчингүйд тооцсоноос үүсэх үр дагавар



Үрчлэлтийг хүчингүйд тооцох тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор тодорхой хууль зүйн үр дагаварууд үүснэ.

Хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэхтэй холбогдсон зардлыг үрчлэгчээс гаргуулж, учирсан гэм хорыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.



### Хяналтын асуулт:

1. Хүүхэд хараа хяналтгүй байдалд орох болсон шалтгааныг та юу гэж боддог вэ?
2. Эцэг, эхийн асран хамгаалалтгүй байгаа хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн зохицуулалтын ямар механизмууд байдаг вэ? Олон Улсын гэрээ конвенц болон үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтыг иш татаж тэдгээрийн онцлогийг тодорхойлно уу?
3. Гадаадын иргэнд Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлүүлж байгаа асуудалд та хэрхэн ханддаг вэ?

4. Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцид заасан үрчлэлтийн шаардлага, зарчим нь Монгол Улсын хуульд хэрхэн тусгалаа олсон бэ?
5. Монгол Улсаас бусад улс оронтой байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр үрчлэлтийн асуудлыг хэрхэн зохицуулдаг болохыг Унгар, Болгар, Румын, Чехославок, Югослав, Солонгос, Куба зэрэг улстай байгуулсан гэрээнүүдээс аль нэгийг нь иш татаж тайлбарлана уу?
6. Хүүхэд үрчлэн авахад бүрдүүлэх бичиг баримтыг нэрлэнэ үү?



### Сорил

1. **Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц нь:**
  - a. *Хүүхдийг үрчлүүлэх зорилгоор хэлэлцэн тохирч өөр нэг улсад хүүхэд шилжин очих гэж байгаа буюу очиход*
  - b. *Хэлэлцэн тохирогч өөр нэг улсад хүүхэд шилжин очсон*
  - c. *Хэлэлцэн тохирогч өөр нэг улсад хүүхэд шилжин очсон, очих гэж байгаа буюу очиход үйлчилнэ.*
2. **Хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн зөвшөөрөл болон хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг**
  - a. *Зөвшөөрлийг бичгээр үйлдэж нотариатаар гэрчлүүлж, хүсэлтийг бичгээр үйлдэнэ.*
  - b. *Зөвшөөрлийг бичгээр, хүсэлтийг нь бичгээр үйлдэж нотариатаар гэрчлүүлнэ.*
  - c. *Аль алиныг нь бичгээр үйлдэж нотариатаар гэрчлүүлсэн байна.*
3. **Бүтэн өнчин хүүхэд, түүнчлэн эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй нөхцөлд хүүхдийг үрчлүүлэхдээ**
  - a. *Хүүхдийн байгууллагын*
  - b. *Хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын*
  - c. *Засаг даргын зөвшөөрлийг авна.*
4. **Хүүхдийг үрчлэхэд тухайн хүүхдийн зөвшөөрлийг**
  - a. *7 нас*
  - b. *8 нас*
  - c. *10 нас хүрсэн бол авна*
5. **Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг энэ тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш хэдэн сарын дараа үрчлүүлж болох вэ?**
  - a. *3 сарын дараа*
  - b. *5 сарын дараа*
  - c. *6 сарын дараа*
6. **Хүүхэд үрчлэн авах хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг?**
  - a. *15 хоногт багтаан*
  - b. *20 хоногт багтаан*
  - c. *30 хоногт багтаан гаргана*



7. **Хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн нэгдсэн бүртгэл хөтөлж, хяналт тавих байгууллага нь**
  - a. Хүн амын асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага
  - b. Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллага
  - c. Сум, дүүргийн Засаг дарга
8. **Үрчлэлт гэр бүлийн хувийн нууцад хамаарах уу?**
  - a. Нууцад хамаарах эсэхийг шүүх тогтооно.
  - b. Хувийн нууц мөн эсэхийг гэр бүлийн гишүүд тогтооно.
  - c. Гэр бүлийн хувийн нууцад хамаарна.
  - d. Хувийн нууцад хамаарахгүй.
9. **Үрчлэгдсэн хүүхэд “С” нь үрчлүүлсэн эцэг, эхээ нас барсны дараа тэдний хөрөнгө болох орон сууц болон бусад эд хөрөнгийг өвлөн авах асуудлаар шүүхэд ханджээ. Хэрхэн шийдвэрлэх вэ?**
  - a. Үрчлэгдсэн ч төрсөн эцэг, эхийнхээ эд хөрөнгийг өвлөн авах эрхтэй.
  - b. Үрчлэгдсэн тул түүний эд хөрөнгийг өвлөн авах эрхээ алдана.
  - c. Түүний эд хөрөнгийг өвлөн авах эсэх асуудлыг дүүргийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.
10. **Монгол Улсад G сараас доошгүй хугацаанд оршин сууж байгаа гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлтээ ямар байгууллагад гаргах вэ?**
  - a. Өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргах журамд хамаарна.
  - b. Өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргах журам үл хамаарна.
  - c. Дээрх журамд хамаарах эсэх асуудлыг шүүх тогтооно.
11. **Гадаадын иргэн эхнэр, нөхөр нь Монгол Улсын харьяат 5 настай хүүхдийг үрчлэн авах үедээ үрчлэгдсэн хүүхдийнхээ иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргавал түүнийг хэрхэн шийдвэрлэх вэ?**
  - a. Монгол Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байх тул хүсэлтийг хангахгүй.
  - b. Иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргасан эсэхээс үл хамаарч үрчлэгдсэнээр хүүхдийн харьяалал өөрчлөгдөнө.
  - c. Иргэний харьяаллыг өөрчлөх хүсэлт гаргавал үрчлүүлж буй эцэг, эхийн саналыг харгалзан тухайн хүүхдийн иргэний харьяаллыг шийдвэрлэж болно.
12. **Охин “Э”-ийн бие даан гаргасан хүсэлтээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцох асуудлыг шийдвэрлэх үү?**
  - a. Эцэг, эхийн хүсэлтээр
  - b. 14 нас хүрсэн бол хүүхдийн өөрийн хүсэлтээр
  - c. Хүүхдийн байгууллагаас гаргасан хүсэлтээр
  - d. 16-18 хүртлэх насны хүүхдийн хүсэлтээр шийдвэрлэнэ.
13. **Аль нь үрчлэлтийг хүчингүйд тооцох үндэслэл болох вэ?**
  - a. Үрчлүүлсэн эцэг, эх нь хүүхдээ буцааж авах шаардлагатай гэж үзвэл
  - b. Хүүхдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах байгууллагаас шаардлагатай гэж үзвэл
  - c. Шүүхээс шаардлагатай гэж үзэх бусад үндэслэлээр

14. Үрчлэлтийг хүчингүйд тооцоноос хүүхдийг буцаах асуудлыг

- Үрчлэн авагч өөрөө төрүүлсэн эцэг, эхэд нь хүүхдийг буцааж өгнө
- Хүүхдийг төрүүлсэн эцэг, эхэд нь буцаах асуудлыг шүүх шийдвэрлэнэ
- Хүүхдийг төрүүлсэн эцэг, эхэд нь буцаах асуудлыг үрчлэлтийн тухай шийдвэр гаргасан байгууллага шийдвэрлэнэ



**Бодлого**

Нялхсын клиник сувилалын асрамжид байгаа Монгол Улсын харьяат 1 нас 4 сартай “Б”-г АНУ-ын иргэн “К”-д түүний хүсэлтийн дагуу үрчлүүлэх тухай Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх албаны шийдвэрт хүүхэд үрчлэн авсан эцэг, эхтэй үрчлэлтийн гэрээ байгуулах талаар заажээ.

- Энэхүү шийдвэрийг гаргахдаа хуулийн ямар заалтуудыг үндэслэх вэ?
- Үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудаар дээрх байгууллага нь бусад ямар байгууллагуудтай хамтран ажиллаж болох вэ?
- Монгол Улсын холбогдох хуульд үрчлэлтийн явцад тавигдах шаардлагыг хэрхэн тодорхойлсон вэ? Ямар шаардлагууд тавигдаж болох вэ?



**Даалгавар:**

Үрчлэлтийн гэрээний агуулгыг тодорхойлж гэрээний үлгэрчилсэн загварыг боловсруулна уу.



**Эх сурвалж:**

- |   |         |
|---|---------|
| 1. Монгол Улсын гэр бүлийн тухай хууль  | 1999 он |
| 2. Иргэний бүртгэлийн тухай хууль   | 1996 он |
| 3. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль  | 1996 он |
| 4. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай конвенц<br>Төрийн мэдээлэл тусгаар дугаар  | 2004 он |
| 5. Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх<br>асуудлаар хамтран ажиллах тухай конвенц<br>Төрийн мэдээлэл тусгаар дугаар | 2004 он |
| 6. А. Дугармаа Гэр бүлийн эрх зүй /102-107т/  | 2005 он |
| 7. Ц.Алтанцэцэг Иргэн бизнесийн эрх зүйн<br>гарын авлага /173-178 т/  | 2006 он |
| 8. Т. Мөнхжаргал Гэр бүлийн эрх зүй   | 1995 он |
| 9. Иргэний бүртгэл, мэдээллийн ажлын гарын авлага   | 2003 он |
| 10. Л.М.Пчелинцева, Семейное право России /482-548/   | 2001 г  |
| 11. Семейное законодательство   | 2003 г  |
| 12. Комментарий к семейному кодексу<br>Россий федераций /361-404т/  | 2003 г  |
| 13. Иргэний бүртгэлтэй холбогдсон хууль<br>тогтоомж, заавар журам   | 2004 он |



## 5 БҮЛЭГ. ХҮНД НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХДИЙГ АСРАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ

### ХҮНД НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХДИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТЭДНИЙ ЭРХ ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### Сэдвийн агуулга

Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тухай ойлголт, шалтгаан нөхцөл, үр дагавар  
Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн арга, хэрэгсэл

#### Сэдвийн зорилго

Хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж хэнийг ойлгох, тэдгээр хүүхдүүдийн эрх, хууль ёсны, ашиг сонирхолыг хамгаалах эрх зүйн арга хэрэгслийн талаар тодорхой мэдлэгтэй болж, тодорхой тохиолдол тус бүрт ямар арга хэрэглэх нь хүүхдийн эрх ашигт нийцэх талаар үнэлэлт, дүгнэлт өгөх, тухай аргыг хууль зүйн дагуу хэрэгжүүлэх чадвартай болж, цаашид энэ асуудалд эрх зүйн талаас нь хандах хандлага төлөвшинө.



#### Нэр томъёоны тайлбар

**Хүнд нөхцөлд байгаа хүүхэд** - Бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн хүүхдийг ойлгоно.

**Сум, дүүргийн Засаг дарга** - Сум, дүүргийн нутаг дэвсгэрт төрийн удирддагыг хэрэгжүүлэгч засаг төрийн төлөөлөгчийг ойлгоно.

#### Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн зохицуулалт

1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд хүнд хүүхдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах зорилгоор нилээд онцлог, шинэлэг зохицуулалтыг эрх зүйн зохицуулалт тусгаж өгсөн юм. Хараа хяналтгүй, хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, нэгдсэн бүртгэл хөтөлж, эрх, ашгийг нь хамгаалах үүргийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд сум, дүүргийн Засаг дарга хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Сум, дүүргийн Засаг дарга хүнд нөхцөлд байгаа хүүхдийг бусдад үрчлүүлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлэх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг тухайн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд шийдвэрлэнэ. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлсэнтэй холбогдон гарах зардлыг эхний ээлжинд захиргааны байгууллага хариуцан гаргаж, дараа нь буруутай этгээдээр нөхөн төлүүлж байх журмыг хуульчилжээ. Гэр бүлийн тухай хуульд эдгээр хүүхдийн эрх, ашгийг хамгаатгах эрх зүйн аргыг тодорхойлоод зогсохгүй, арга хэрэгслийг хэрхэн хэрэгжүүлэх тухай зохицуулалтыг тогтоож өгсөн.

Тухайлбал: хүүхэд үрчлэх нөхцөл журамд хараа хяналтгүй хүүхдийг бусдад үрчлүүлэхэд тусгайлсан ямар журам баримтлах вэ гэдгийг хуульчилан тогтоосон.

Мөн түүнчлэн сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эцэг эхийг тогтоолгох, эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлуулахаар эрх бүхий байгууллагад хүсэлт гаргах эрхтэй. Орон гэрээсээ дайжсан, хүнд нөхцөлд тэнүүчлэн амьдарч байгаа хүүхдийн эрх ашгийг хамгаалахад хуулийн эдгээр заалт чухал ач холбогдолтой юм.

Цаашид хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тухай тодорхойлолтод хамрагдаж байгаа хараа хяналтгүй хүүхэд гэж хэнийг ойлгох талаар нарийн зохицуулалт шаардлагатай байгаа юм.



### Хяналтын асуулт:

1. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж хэнийг хэлдэг вэ ?
2. Хүнд нөхцөлд байгаа болон хараа хяналтгүй хүүхдийн нийтлэг ба ялгаатай шинжийг тодорхойлно уу?
3. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн аргуудыг нэрлэж, тэдгээрийн ялгааг харьцуулан тодорхойлно уу?
4. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ авч, асран хүмүүжүүлэхийг хүссэн иргэнд шилжүүлэх нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах шинэлэг арга мөн болохыг тайлбарлана уу?
5. Асран хүмүүжүүлэх гэрээний эрх зүйн зохицуулалт, түүний онцлог, ач холбогдлыг тодорхойлно уу?



### Сорил

1. **Болорын эцэг, эх нас барсан учраас нагац эгч Сэргэлэн түүнийг үрчилж авсан байна. Болор хүнд нөхцөлд байгаа хүүхэд мөн эсэхэд дүгнэлт хийнэ үү?**
  - a. Болор үрчлэгдсэн хүүхэд
  - b. Болор бүтэн өнчин хүүхэд учраас хүнд нөхцөлд байгаа хүүхэд
  - c. Болор Сэргэлэнгийн асрамжинд байгаа тул энд хамаарахгүй
  - d. Болор Сэргэлэн нарын хооронд гэр бүлийн харилцаа үүссэн тул хүнд нөхцөлд байгаа хүүхэд биш
2. **Аль нь хүнд нөхцөлд байгаа хүүхэд вэ?**
  - a. 14 настай биеэ үнэлэгч охин
  - b. Өөрийн гэсэн гэр оронтой боловч, орцонд хоноглодог 17 настай хүү
  - c. Эцэг, эх нь хөдөлмөр эрхэлдэггүй учраас гуйлга гуйж амьдардаг 5 настай охин
  - d. Эхтэйгээ хамт амьдардаг 3 настай хүү
3. **Хүнд нөхцөлд байгаа хүүхдэд хяналт тавих эрхтэй этгээдийг тодорхойлно уу?**
  - a. Нийгмийн халамжийн байгууллага
  - b. Цагдаагийн байгууллага
  - c. Сум, дүүргийн Засаг дарга
  - d. Сургууль, цэцэрлэгийн захиргаа
4. **Хараа хяналтгүйгээс эрүүл мэнд нь хохирч болзошгүй хүүхдийг түр саатуулах эрхтэй этгээдийг олно уу?**
  - a. Сум, дүүргийн Засаг дарга
  - b. Цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан
  - c. Шүүгч
  - d. Нийгмийн халамжийн байгууллага



### Бодлого

1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Сансар үйлчилгээний төвийн ойролцоох хуучин халуун усны байранд 4, 5 настай гэж өөрсдийгөө танилцуулсан хоёр охин байнга хоноглох болсныг тус улсад түр оршин суудаг гадаадын иргэн эмэгтэй С мэдээд энэ тухай тус хорооны Засаг дарга Нямжавт мэдэгдсэн байна.  
Хорооны Засаг дарга харьяа Цагдаагийн хэсэгт энэ талаар мэдэгдэх нь зүйтэй гэсэн хариултыг С-д өгсөн. Энэ өдрөөс эхлэн С 2 охиныг 3 сар гэртээ байлгаж, хоол, унд, хувцсаар хангаж байв. Охидуудын талаар хэн ч санаа тавьж араас нь ирсэнгүй.  
Энэ тохиолдолд:
  1. 4, 5 настай хоёр охиныг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж хэлэх үү?
  2. Тэд хараа хяналтгүй хүүхэд мөн эсэхэд дүгнэлт хийнэ үү?
  3. Эдгээр охидуудын эрх, ашгийг хамгаалах талаар эрх зүйн ямар зохицуулалт байдаг талаар С-д эрх зүйн туслалцаа үзүүлнэ үү?
2. Насан 15 настай. Тэдний гэр бүл нилээд чинээлэг амьдралтай. Гэвч эцэг, эх хоёр нь хүүхэддээ анхаарал халамж тэр бүр тавьдаггүй. Энэ байдлаас болоод Насан сургуулиас завсардан, улмаар орон гэргүй хүүхдүүдтэй нийлэн тэнүүчилж, орц хонгилоор хоноглох болжээ.  
Энэ тохиолдолд:
  1. Насан хүнд нөхцөлд байгаа хүүхэд мөн үү?
  2. Түүний эрхийг хэрхэн хамгаалах вэ?



### Даалгавар:

1. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх, ашгийг хамгаалах талаар дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны арга хэлбэр, түүний үр нөлөө ямар байгаа талаар хэлэлцэнэ үү?
2. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх, ашгийг иргэн болон төрийн бус байгууллага хамгаалж байгаа практик ажиллагаатай танилцана уу?
3. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрхийг хамгаалах талаар хэрэгжиж байгаа хууль тогтоомжийг нэрлэн, боловсронгуй болох талаар өөрсдийн саналыг бичнэ үү?
4. Хараа хяналтгүй хүүхэд гэдгийг тодорхойлно уу?



### Эх сурвалж:

- |  |         |
|--|---------|
| 1. Гэр бүлийн тухай хууль  | 1999 он |
| 2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль                                       | 1996 он |
| 3. Хүүхдийн эрхийн тухай конвенц /төрийн мэдээлэл I боть/                      | 2004 он |
| 4. Ц. Алтанцэцэг. Иргэн бизнесийн эрх зүйн гарын авлага                        | 2006 он |
| 5. А. Дугармаа. Гэр бүлийн эрх зүй   | 2005 он |
| 6. Гэр бүл, эцэг, эхийн хараа хяналтаас гарсан хүүхдийн нийгэмшилтийн судалгаа | 2006 он |

## АСРАН ХАМГААЛАХ, ХАРГАЛЗАН ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Сэдвийн агуулга

Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааны тухай ойлголт, онцлог, ач холбогдол

Асран хамгаалагч, асран хамгаалалтад байх хүний эрх, үүрэг

Харгалзан дэмжигч, харгалзан дэмжлэгт байх хүний эрх, үүрэг

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох журам

Асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг дуусгавар болох нь

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох үндэслэл, журам

### Сэдвийн зорилго

Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудлыг танин мэдэх, асран хамгаалах үйл ажиллагааг харгалзан дэмжихээс ялгах, тэдгээрийн нийтлэг зорилго чиглэлийг тодорхойлох чадвартай болж, цаашид асран хамгаалах, харгалзан дэмжих тухай асуудалд хууль зүйн талаас нь хандаж, энэ талаар бусдад эрх зүйн туслалцаа үзүүлэх чадвар эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Асран хамгаалах үйл ажиллагаа** - нь нас болон эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдлын хувьд эрхийн тусгай хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа иргэнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалагч, тогтоож, тэдний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг ойлгоно.

**Харгалзан дэмжих үйл ажиллагаа** - нь нас болон эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдлын хувьд эрхийн тусгай хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа иргэнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр харгалзан дэмжигч тогтоож, тэдний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг ойлгоно.

**Асран хамгаалбал зохих хүмүүс** - Бага насны (14 нас хүрээгүй) бүтэн өнчин хүүхэд, эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд, эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн гэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхэд, сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүн асран хамгаалбал зохих хүмүүст хамаарна.

**Асран хамгаалагч, харгалзан дэмжигч** - Хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагаас асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон эд хөрөнгийн зохих бололцоотой, төрөл садан буюу төрөл садангийн бус хүнийг ойлгоно.

Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, өөрөө асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа, мансууруулах бодис, согтууруулах ундаа



байнга хэрэглэдэг, хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн, үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцааж өгсөн хүмүүсийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоож болохгүй. **Харгалзан дэмжвэл зохих хүн** - Насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны бүтэн өнчин хүүхэд, эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний насанд хүрээгүй хүүхэд, эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний насанд хүрээгүй хүмүүс, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэсний улмаас иргэний эрх зүйн эрхийн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн, эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсоны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон хүнийг ойлгоно.

**Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох** - Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь эрхээ урвуулан ашигласан, үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас асрамж, дэмжлэгтээ байгаа хүнийг хараа хяналтгүй, шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлээгүй орхисон бол шүүх асран хамгаалагч харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрийг хүчингүйд тооцох ажиллагааг ойлгоно.

Асран хамгаалах, харгалзан дэмжих нь нас болон эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдлын хувьд эрхийн тусгай хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа иргэнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалагч харгалзан дэмжигчийг тогтоож, эрхийг нь хамгаалж байгаа үйл ажиллагааг юм.

Асран хамгаалах, харгалзан дэмжих ажиллагаа нь тухайн асрамж, хамгаалалт шаардлагатай байгаа хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, тэднийг зөв боловсон өсгөж хүмүүжүүлэх, асран хамгаалах, эрүүл энх, ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэх зорилготой.

Асран хамгаалах, харгалзан дэмжих тухай асуудал нь зорилгоороо адил боловч, хуулийн дагуу үүсэж байгаа эрх, үүрэг, хариуцлага, үр дагаврын хувьд ялгаатай. Асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байх этгээдийг хуулиар тогтооно.

#### Асран хамгаалалт харгалзан дэмжлэгт байх хүн

- Бүтэн өнчин хүүхэд
- Эцэг, эх нь хоёулаа иргэний эрхзүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүний хүүхэд
- Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний хүүхэд
- Эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаагаас хүүхдээ асрах бололцоогүй хүний бага насны хүүхэд
- Эцэг, эх нь хоёулаа хорих ял эдэлж байгаа хүний хүүхэд

14 нас хүрээгүй дээрх бага насны хүүхэд, сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрхзүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүнд асран хамгаалагч тогтооно.

14-18 хүртэлх насны дээрх насанд хүрээгүй хүүхэд согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэсний улмаас иргэний эрхзүйн, эрхийн хязгаарлагдмал хүнд харгалзан дэмжигч тогтооно чадамжтай гэж тооцогдсон

### **Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох журам**

Сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох асуудлыг шийдвэрлэдэг. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр төрөл садан буюу төрөл садан бус хүн байж болно.

Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоож болох хүний эд хөрөнгийн боломж, төрөл садангийн холбоо, тухайн хүний хувийн байдлыг нарийвчлан шалгаж, эдгээр байдлыг нотолсон баримт материалтай танилцан асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоох, эсэх асуудлыг шийдвэрлэдэг.

Хэрэв асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох үндэслэлтэй байна гэж үзвэл захирамж гаргана. Энэхүү захирамжинд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох болсон үндэслэл, түүнийг нотолсон баримт бичиг, үндэслэсэн хуулийн зүйл, заалтыг дурьдаж, хүсэлтийг хэрхэн шийдвэрлэснийг тодорхой заана. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоосноор асрамж, дэмжлэгт байгаа хүн бүрт хувийн хэрэг нээдэг.

Энэхүү хувийн хэргийг нээснээр уг асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаанд төрөөс хууль зүйн дагуу хяналт тавих ажиллагааа хэрэгжинэ.

Хувийн хэрэгт: Засаг даргын шийдвэр, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, түүнийг нотлох, баримт бичгийг бүрдүүлж, материалд хавсаргана.

#### **Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох журам**

Асран хамгаалах, харгалзан дэмжих тухай хүсэлтийг иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан хүлээн авч нягтлан шалгана.

Иргэний бүртгэлийн ажилтан асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох саналаа Засаг даргад танилцуулж захирамж

Асрамж дэмжлэгт байгаа хүн тус бүрт хувийн хэрэг нээн хөтөлж, хяналт тавина

Иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоосон шийдвэрийг үндэслэн гэрээ байгуулж биелэлтийг шалгана.

### **Асран хамгаалах, харгалзан дэмжих эрх үүрэг дуусгавар болох, болон асран хамгаалагч харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох тухай**

Асран хамгаалах, харгалзан дэмжих эрх, үүрэг нь тодорхой тохиолдолд дуусгавар болно. Тухайлбал: асран хамгаалах, харгалзан дэмжих нөхцөл арилж, хүүхдийг эцэг, эхэд нь буцаасан, хүүхдийг үрчлүүлсэн, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлсэн, харгалзан дэмжүүлэгч насанд хүрсэн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, шүүхийн шийдвэрээр харгалзан дэмжүүлэгчийг иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж тооцсон, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл асрамж, дэмжлэгт байгаа хүн сураггүй алга болсон буюу нас барсанд тооцогдсон, нас барсан зэрэг үндэслэлүүд хамаарна.

Асран хамгаалалтад байгаа хүүхэд 14 нас хүрмэгц асран хамгаалагч нь харгалзан дэмжигчийн үүрэг хүлээнэ. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь эрхээ урвуулан ашигласан, үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас асрамж, дэмжлэгтээ байгаа хүнийг хараа хяналтгүй, тусламж, дэмжлэг, үзүүлээгүй орхисон бол шүүх асран хамгаалагч харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцдог.



Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтийг сум, дүүргийн Засаг дарга, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллагын төлөөлөгч гаргах бөгөөд асрамж, дэмжлэгт байгаа хүний оршин суугаа газрын харъяа шүүхэд гаргана.



### Хяналтын асуулт:

1. Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаа гэдгийг тодорхойлно уу? Түүний зорилго юу вэ?
2. Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааны онцлог, ялгааг харьцуулалт хийж дүгнэнэ үү?
3. Асран хамгаалагчид тавигдах шаардлага, асран хамгаалалтад байх хүнийг нэрлэн жагсааж бичнэ үү?
4. Харгалзан дэмжигч гэж хэнийг хэлэх вэ? Түүний эрх, үүргийг тодорхойлоно уу?
5. Харгалзан дэмжлэгт байх хүнийг нэрлэнэ үү?
6. Хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох онцлогийг тодорхойлно уу?
7. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг ямар байгууллага тогтоодог вэ?
8. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтооход ямар баримт бичгийг бүрдүүлэх вэ?
9. Асран хамгаалагч харгалзан дэмжигчийн хувийн хэргийн ач холбогдлыг тодорхойлно уу?
10. Ямар тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосныг хүчингүйд тооцох вэ?
11. Ямар байгууллага асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосныг хүчингүйд тооцох вэ? Энэ талаар хүсэлт гаргах эрхтэй этгээдийг нэрлэнэ үү?
12. Асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоосныг хүчингүйд тооцох ажиллагааны онцлогийг тайлбарлана уу?



### Сорил

1. **Асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага нь**
  - a. *Нийгмийн халамжийн байгууллага*
  - b. *Сум, дүүргийн Засаг даргын дарга*
  - c. *Шүүх*
  - d. *Аймаг, нийслэлийн Засаг дарга*
2. **16 настай эцэг, эхгүй бүтэн өнчин хүүхдэд:**
  - a. *Асран хамгаалагч тогтоопо*
  - b. *Харгалзан дэмжигч тогтооно*
  - c. *Бусдад үрчлүүлж, эрх, ашигийг нь хамгаална*
  - d. *Төрийн эрх бүхий байгууллагаас эрхийг нь хамгаална*

3. **Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг өөрчлөх тухай тухай шийдвэрийг хэн гаргах вэ?**
  - a. Шүүх
  - b. Сум, дүүргийн Засаг дарга
  - c. Нийгмийн халамжийн байгууллага
  - d. Хүүхдийн эрх ашгийг хамгаалах байгууллага
4. **Өндөр настай болсны улмаас бие дааж амьдрах боломжгүй болсон хүнийг асран тэтгэх гэрээний үндсэн дээр асран хамгаална.**
  - a. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтооно
  - b. Зөвхөн харгалзан дэмжигчийг тогтооно
  - c. Гэрээний үндсэн дээр асран хамгаална
  - d. Насанд хүрсэн хүүхдээрээ асран хамгаалуулна.
5. **Иргэний бүртгэлийн ажлтан асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон шийдвэрийг үндэслэн асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон тухай бүртгэл хийх үү?**
  - a. Бүртгэлийг Иргэний бүртгэлийн тухай хуульд заасны дагуу үйлдэнэ
  - b. Тусгайлсан бүртгэлийг үйлдэхгүй
  - c. Зохих тэмдэглэл үйлдэнэ. Энэ нь бүртгэлд үл хамаарна
  - d. Энэ талаарх хуулийн зохицуулалт байхгүй



#### Даалгавар:

1. Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааны талаарх онолын мэдлэгтэй тулгуурлан сум, дүүргийн Засаг даргын тамгын газраас энэхүү үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж байгаа тапаар практик судалж, холбогдох материалыг бүрдүүлнэ үү?
2. Асран хамгаалалтад байх хүний талаарх мэдээллийг хэрхэн ямар журмаар авч болох талаар хэлэлцэнэ үү?
3. Харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн хувийн хэрэгтэй танилцаж бүрдүүлэлт хийж сурна уу?



#### Эх сурвалж:

1. Гэр бүлийн тухай хууль 1999 он
2. Ц. Алтанцэцэг. Иргэн бизнесийн эрх зүйн гарын авлага 2006 он
3. А. Дугармаа. Гэр бүлийн эрх зүй 2005 он
4. Иргэний бүртгэлтэй холбогдсон хууль тогтоомж, заавар, журам 2004 он



## ХҮҮХДИЙГ ГЭР БҮЛДЭЭ АВЧ АСРАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Сэдвийн агуулга

Хүүхэд асран хүмүүжүүлэх үйл ажиллагааны тухай ойлголт, ач холбогдол  
Асран хүмүүжүүлэх гэрээний ойлголт, агуулга  
Асран хүмүүжүүлэгч иргэнд тавигдах шаардлага  
Нийгмийн халамжийн байгууллагын эрх, үүрэг  
Асран хүмүүжүүлэх гэрээ дуусгавар болох тухай

### Сэдвийн зорилго

Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах зорилгоор тэднийг гэр бүлдээ авч, асран хүмүүжүүлэх үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэгтэй болсноор дээрх хүүхдийн эрх ашгийг хамгаалах арга хэрэгслийг зөв сонгон хэрэглэх, түүний үндэслэлийг тайлбарлах чадвартай болж энэ асуудалд хууль зүйн талаас хандах хандлага төлөвшинө



### Нэр томъёоны тайлбар

**Хүүхдийг гэр бүлдээ авч, асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа** - Өөрийн зардаар хүүхдийг асран хүмүүжүүлэхийг хүссэн иргэн, нийгмийн халамжийн байгууллагын хооронд тодорхой хугацаагаар байгуулагдсан гэрээний үндсэн дээр хэрэгжих үйл ажиллагааг ойлгоно.

**Хүүхдийг гэр бүлдээ авч, асран хүмүүжүүлэх гэрээ** - Гэрээг нэг талаас хүүхдийг асран хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих эрх, үүрэг бүхий нийгмийн халамжийн байгууллага, нөгөө талаас хуульд тавигдаж буй шаардлага хангасан, хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхийг хүссэн иргэний хооронд бичгээр байгуулсан гэрээг ойлгоно.

**Хүүхэд асран хүмүүжүүлэхийг хүссэн иргэн** - Хуульд заасан журмын дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхийг хүссэн иргэнийг ойлгоно.

**Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагааны тухай, ойлголт журам**

Нийгэмд бий болсон ядуурал, ажилгүйдэл, гэрлэлт цуцлалт зэрэг олон шалтгаанаас үүдэн амьжиргааны эх үүсвэрийн хувьд зарим нэгэн гэр бүл хүнд нөхцөлд байх болсон төдийгүй хүүхэд амьдрахын эрхэнд орон гэрээсээ дайжиж, хаана яваа нь мэдэгдэхгүй, орц хонгил, траншейнд хоноглох зэргээр хэний ч хараа хяналтгүй тэнүүчлэн амьдрах болсон. Мөн хүүхдээ наад захын хоол хүнс, хувцас, орон байраар хангаж чадахгүй хүүхдээ хаях төөрүүлэх нь энгийн үзэгдэл болж хүүхдийн эрх, ашиг ноцтойгоор зөрчигдөх болсон. Тийм ч учраас “хаягдмал”, “олдмол”, “траншейны” хүүхдүүд хэмээх нэр томъёо хүртэл бий болсон төдийгүй, бүтэн өнчин, харж хандах хүнгүй, тахир дутуу, нэн ядуу, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хэрхэн хамгаалах вэ гэдэг асуудал зүй ёсоор тавигдсан юм. Бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ” хэмээн тодорхойлсон

бөгөөд эдгээр хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх зохицуулалт Гэр бүлийн тухай хуульд анх удаа тусгагдсан нь хүнд нөхцөлд байгаа бага насны, насанд хүрээгүй хүмүүсийг гэр бүлд хүмүүжүүлэх нэгэн шинэ хэлбэрийн ажиллагаа юм.

Гэр бүл нь хүүхдийн өв тэгш өсч бойжих, зан байдал нь төлөвшин тогтох гол орчин учраас хүнд нөхцөлд байгаа хүүхдийг аль болох гэр бүлийн орчинд өсгөж хүмүүжүүлэх зорилгоор энэхүү шинэлэг зохицуулалтыг бий болгосон нь ач холбогдолтой юм. Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагааны зорилго нь хүүхдийн эрх ашгийг хамгаалахад оршино.

Гэрээ байгуулах талууд хуулиар тодорхойлогдож, тэдэнд тусгайлсан шаардлага тавигдаж байдаг. Асран хүмүүжүүлэгч болон хүүхдийн хооронд асран хамгаалагч, харгалзан дэмжэгч болон, асран хамгаалалт, харгал зан дэмжлэгт байх хүний хооронд үүссэн эрх, үүрэг мөн нэгэн адил үүснэ. Гэрээний талууд тухайлбал нийгмийн халамжийн байгууллага нь нийгмийн халамжийн сангаас асран хүмүүжүүлэгчид урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх, хүндэтгэн үзэх шалтгаан бий болсон тохиолдолд хүүхдийн эрх ашгийн үүднээс гэрээг цуцлах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ.

Хүүхдийг гэр бүлдээ асран хүмүүжүүлэхийг хүссэн иргэнд хүүхдийг шилжүүлэхдээ хүүхэд 7 насанд хүрсэн бол түүний саналыг заавал харгалзан үзнэ. Асран хүмүүжүүлэгчид хүүхдийг шилжүүлэхдээ хүүхдийн биеийн эрүүл мэнд, сурлага, хүмүүжлийн байдал, эцэг, эх, төрөл садан, ах, эгчийн талаарх мэдээллийг үнэн зөвөөр мэдээлэх үүрэгтэй. Хэрэв хүүхэд өвчний учир эмчийн хяналтад байх шаардлагатай бол өвчний түүхийг заавал өгнө. Асран хүмүүжүүлэхээр шилжүүлсэн хүүхэд Монгол Улсын Гэр бүлийн болон, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар тогтоосон эрхийг эдлэх бөгөөд нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжинд хамрагддаг бол тэрхүү эрх нь үргэлжилнэ.

Асран хүмүүжүүлэх гэрээнд гэрээний үргэлжлэх хугацаа, гэрээ дуусгавар болох, нэг талын санаачилгаар түүнийг цуцлах үндэслэл, журмыг тохиролцоно.

Гэрээнд тохиролцооноор хүүхдийг ёс суртахуун, оюун санааны болон бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөх, сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, төлөөлөх, хүүхдийн амьдрах орон сууц, идэх хоол, өмсөх хувцас зэрэг материаллаг хангамжийг бүрдүүлэх, эрүүл мэндийн үзлэгт тодорхой хугацаанд хамруулж байх, сургууль, цэцэрлэгийн байгууллагатай байнга холбоотой ажиллах, гэр бүлд хүүхэд өсч, хүмүүжих нөхцөл өөрчлөгдсөн бол нэн даруй нийгмийн халамжийн байгууллагад мэдэгдэх зэрэг үүргийг хүлээнэ.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар асран хүмүүжүүлэх гэрээ байгуулж болохгүй этгээдэд эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж хасуулж байсан, асран хүмүүжүүлж байсан буюу үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа ял шийтгүүлж байсан болон хорих ял эдэлж байгаа хүн зэрэг тус тус багтана

Гэрээ дуусгавар болоход хүүхэд 18 насанд хүрсэн, гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон зэрэг үндэслэл хамаарна.

Асран хүмүүжүүлэгч өвчилсөн, түүний гэр бүлийн болон эд хөрөнгийн байдал өөрчлөгдсөн хүүхэд, асран хүмүүжүүлэгчийн хооронд үл ойлголцох, маргаантай асуудал бий болсон зэрэг тохиолдолд асран хүмүүжүүлэгчийн, харин хүүхдийг эцэг, эхэд нь буцаан өгсөн, бусдад үрчлүүлсэн бол нийгмийн халамжийн байгууллагын санаачилгаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.



### Хяналтын асуулт:

1. Асран хамгаалах, харгалзан дэмжих болон хүүхдийг асарч хүмүүжүүлэхийг хүссэн иргэнд хүүхдийг шилжүүлэх үйл ажилагааны нийтлэг ба ялгаатай байдлыг харьцуулан судалж, тус бүрийн онцлог шинжийг тодорхойлно уу?
2. Асран хүмүүжүүлэх гэрээний агуулгыг тайлбарлана уу?
3. Асран хүмүүжүүлэх гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах үндэслэлийг жишээ авч тайлбарлана уу?
4. Асран хүмүүжүүлэх гэрээ дуусгавар болох үндэслэлийг тодорхойлохын тулд бусад гэрээтэй харьцуулан тодорхойлно уу?
5. Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан зохицуулалтаас ямар хууль зүйн үр дагавар үүсэх вэ?



### Сорил

1. **Хүүхэд асран хүмүүжүүлэх тухай гэрээний субъектыг олно уу?**
  - a. Эмнэлгийн байгууллага
  - b. Нийгмийн халамжийн байгууллага
  - c. Сум дүүргийн Засаг дарга
  - d. Асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага
2. **Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхэд тухайн хүүхдийн насыг харгалзах уу?**
  - a. Тийм. Хүүхэд 7 насанд хүрсэн байна.
  - b. Харгалзахгүй
3. **Хүүхдийг асран хүмүүжүүлэх үйл ажиллагааны явцад хүүхэд, асран хүмүүжүүлэгчийн хооронд ямар эрх, үүрэг үүсэх вэ?**
  - a. Төрсөн эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг
  - b. Хойт эцэг, хойт эх, хүүхдийн эрх, үүрэг
  - c. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа хүний эрх, үүрэг
  - d. Үрчлэгч, үрчлүүлэгчийн эрх, үүрэг
4. **Асран хүмүүжүүлэх гэрээ байгуулж болох хүнийг тодорхойлно уу?**
  - a. Шүүхээр хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн
  - b. Насанд хүрсэн хүн
  - c. Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулж байсан хүн
  - d. Асран хамгаалж байсан хүнээ өөрийн буруугаас буцаан өгсөн
5. **Асран хүмүүжүүлэх гэрээний биелэлтэд хяналт тавих эрхтэй этгээдийг олно уу?**
  - a. Асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага
  - b. Нийгмийн халамжийн байгууллага
  - c. Цагдаагийн байгууллага
  - d. Хүүхдийн эрхийн үндэсний төв



### Бодлого

Нийгмийн халамжийн байгууллага нь Санждаваа, Долгор нарын хүсэлтээр хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээг 10 жилийн хугацаатай байгуулж, Саран-Одыг тэдний асрамжинд өгсөн. Саран-Од нь бүтэн өнчин бөгөөд 8 настай. Саран-Од өөрөө ч тэдний гэр бүлд байхыг зөвшөөрсөн. Тэрээр сургуульдаа онц сурч, хүмүүжлийн хувьд ч бусдын хайр, хүндэтгэлийг хүлээсэн хүүхэд байв. Саран-Од 10 дугаар анги төгсөөд эмч болох хүсэлтэй байсан учраас ЭМШУ Их Сургуулийн эмчилгээний ангид элсэн орсон. Одоо нэгдүгээр курст суралцдаг.

Энэ тохиолдолд:

1. Саран-Одыг Санждаваагийн гэр бүлд өсгөн хүмүүжүүлэхэд ямар бичиг баримт шаардлагатай вэ?
2. Төрөөс Санждаваад бүтэн өнчин хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлсэн гэдэг үндэслэлээр ямар нэгэн хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх үү?
3. Саран-Од 18 насанд хүрсэн бол хүүхэд асран хүмүүжүүлэх гэрээ дуусгавар болох уу? Цаашид Саран-Одын сургалтын төлбөрийг хэн хариуцан төлөх вэ?



### Даалгавар:

Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэрээний үндсэн дээр гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх тухай гэрээний төсөл боловсруулах, гэрээнд тавигдах шаардаагыг тодорхойлно уу?



### Эх сурвалж:

- |   |         |
|---|---------|
| 1. Гэр бүлийн тухай хууль                 | 1999 он |
| 2. Нийгмийн халамжийн тухай хууль         | 2005 он |
| 3. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль  | 1996 он |
| 4. Ц. Алтанцэцэг. Иргэн бизнесийн эрх зүй | 2006 он |
| 5. А. Дугармаа. Гэр бүлийн эрх зүй        | 2005 он |



## 6 БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### ГЭРЛЭЛТИЙН ХАРИЛЦААНЫ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

#### Сэдвийн агуулга

Гадаадын элемент агуулсан гэрлэлтийн харилцааны ойлголт, түүний зохицуулалтын онцлог, эх сурвалж

Гадаадын элемент агуулсан гэрлэлтийн харилцаанаас үүсэх үр дагавар

#### Сэдвийн зорилго

Гэр бүлийн эрх зүйн гадаадын элемент бүхий харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, зарчим, эрх зүйн зохицуулалтын онцлог, эх сурвалжтай танилцаж, бусад эрх зүйн харилцаануудтай харьцуулан судалж онолын мэдлэгтэй болох замаар энэ харилцаанаас үүсэх үр дагаварт дүн шинжилгээ хийх, хууль тогтоомжийг сонгож хэрэглэх, асуудалд хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшинө.



#### Нэр томъёоны тайлбар

**Гадаадын элемент агуулсан гэр бүлийн эрх зүйн харилцаа** - Гэр бүлийн эрх зүйн харилцааны элементийн аль нэг нь нэг болон хэд хэдэн улсын эрх зүйд хамааралтай буюу олон улсын шинжтэй болохыг ойлгоно

**Гадаадын элемент агуулсан гэр бүлийн эрх зүйн эх сурвалж** - Гадаадын элемент бүхий гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулж буй хэм хэмжээнүүдийн илрэн гарах гадаад хэлбэр бөгөөд олон улсын шинжтэй гэрээ, зан заншил болон үндэсний хууль тогтоомж, шүүхийн прецедент юм.

**Гэр бүлийн эрх зүйн зөрчилдөөний хэм хэмжээ** - Гадаадын элемент агуулсан гэр бүлийн эрх зүйн харилцаанд аль улсын хуулийг хэрэглэхийг тодорхойлж буй хэм хэмжээг хэлнэ

#### Гэр бүлийн харилцааны олон улсын эрх зүйн зохицуулалтын ойлголт, онцлог, эх сурвалж

Гэр бүлийн эрх зүйн материаллаг хэм хэмжээнүүд улс орон бүрт онцлог байдлаар зохицуулагддаг. Энэ нь:

- Эрх зүйн тогтолцоо
- Үндэсний зан заншил, ахуй
- Шашны уламжлал
- Нийгэм, эдийн засгийн байдал гэх мэт нөхцөл байдалтай холбоотой.

Англо Саксоны эрх зүйн тогтолцоо

Шүүхийн хэвшүүлэн хэрэглэх хэм хэмжээ нь эрх зүйн үндсэн эх сурвалж.

Англи, Ану, Канад, Австрали, Шинэ Зеланд, Умард Ирланд

Ром-германы эрх зүйн тогтолцоо

Хууль, хуульчилсан акт нь эрх зүйн үндсэн эх сурвалж

Франц, Итали, Испани, ХБНГУ, Австри, Швейцарь, Бельги

Тухайлбал: Эрх зүйн тогтолцооны хувьд авч үзвэл:

Гадаадын элемент агуулсан гэр бүлийн эрх зүйн харилцаа нь олон улсын иргэний эрх зүйд хамаарна.

Олон улсын иргэний эрх зүйд үүсэх гэр бүлийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг ижилтгэх процесс ХХ зууны үеэс эхэлсэн. Үүнтэй холбогдуулж

гэрлэлт, гэрлэлтийг цуцлах, үрчлэлт болон хүүхдийн тэтгэлэг, асран хамгалах, харгалзан дэмжих тухай конвенциудыг батлан гаргасан.

Олон талт олон улсын гэрээг байгуулахад олон улсын байгууллагуудын үүрэг роль чухал ач холбогдолтой. Тухайлбал:

*Олон Улсын иргэний эрх зүйн асуудал эрхэлсэн олон улсын байгууллага нь 1893 онд байгуулагдсан бөгөөд энэ байгууллагын зорилго нь зөрчилдөөний хэм хэмжээг жигдрүүлэх, ижилтгэх боловсронгуй болгоход оршино.*

**Гэр бүлийн харилцааны хүрээн дэхь зөрчилдөөний хэм хэмжээ:**

- Хүүхдийн алимент төлөх үүрэгт хэрэглэгдэх эрхийн тухай конвенц 1956 он
- Гэр бүл салалт болон гэр бүл бологсдыг шүүхээр тусгаарласан шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай конвенц -1970 он
- Гэр бүл болон түүнийг хүчингүйд тооцох тухай конвенц - 1978 он

**Олон улсын иргэний процессын хүрээнд:**

- Иргэний процессын асуудлаарх конвенц -1954 он/
- Хүүхдийн алиментын үүргийн тухай шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай конвенц -1958 он

**Олон улсын шинжтэй хэм хэмжээ агуулсан үндэсний хууль тогтоомж**

- Монгол Улсын Үндсэн хууль -18 §
- Гэр бүлийн тухай хууль - 2§, 6§, 12§, 14§, 23§, 58§
- Монгол Улсын Харьяатын тухай хууль - 3§, 13§, 3, 4 дүгээр бүлэг
- Иргэний бүртгэлийн тухай хууль - 2§, 12-18§
- Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль - 2 дугаар бүлэг
- ИХШХШ тухай хууль - 7 дугаар хэсэг
- Иргэний хууль - 6 дугаар хэсэг

**Гэр бүлийн харилцааны зохицуулалт дахь зөрчилдөөний асуудал** - Улс орнуудын гэр бүлийн эрх зүйн харилцааны зохицуулалт нь онцлог ялгаатай байх тул тухайн салбарт үүссэн асуудлыг практикт шийдвэрлэхэд зөрчилдөөнийг бий болгодог.

Гэр бүлийн эрх зүйн харилцааны мөн чанар, зохицуулалтын онцлогоос шалтгаалж гэр бүлийн харилцаа гадаадын элемент агуулах нь түүний бүх институт дээр зөрчилдөөнийг үүсгэдэг. Тухайлбал;

- Гэрлэх
- Гэрлэлтийг цуцлах
- Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох
- Гэрлэгсдийн хоорондын эд хөрөнгийн харилцаа
- Эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа
- Үрчлэлт
- Асран хамгаалах, харгалзан дэмжих гэх мэт.



Энэхүү харилцааны зохицуулалт нь улс орнуудын хууль тогтоомжид өөрөөр тусгагдсан байдаг.

Бүртгэгдсэн газрын хуулийн дагуу нэг улсад бүртгэгдсэн гэрлэлт нөгөө улсад хүлээн зөвшөөрөгдөхгүй байх үр дагавар нь коллизийн асуудлыг бий болгоно. Зөрчилдөөн нь өөрөө өрөөсгөл харилцааг үүсгэдэг. Өрөөсгөл харилцаа нь нэг улсын



хуулиар хүлээн зөвшөөрөгдөж хууль ёсны байх боловч нөгөө улсад эрх зүйн үр дагавар үүсгэхгүй. Зөрчилдөөний хэм хэмжээ нь уг өрөөсгөл харилцааг зохицуулах, арилгах зохицуулалтын шинжийг агуулна.


*Зөрчилдөөний хэм хэмжээнүүд нь зөвхөн дотоодын хууль тогтоомжид төдийгүй Монгол Улсын олон улсын гэрээ, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээнүүд, консулын конвенцүүдэд агуулагдаж байдаг*



Нягт холбооны зарчим нь гадаад, дотоодын эрх зүйг адил түвшинд тавих, ижилтгэн үзэх асуудал бөгөөд маргааныг аль улсын шүүх шийдвэрлэснээс үл хамаарч нэгэн ижил шийдвэр гарах болоцоотой байхыг илэрхийлнэ.

**Гэрлэлтийн харилцааны олон улсын эрх зүйн зохицуулалт**

Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр Монгол Улсад гэрлэж болно. Гэрлэхэд гадаадын элемент нь дараах хэлбэрээр илэрнэ.



Гэрлэлтийг бүртгэх улсын хуулийг хэрэглэх нь үндэсний зөрчилдөөний хэм хэмжээ юм.

**Монгол Улсад гэрлэх**


**Гэр бүлийн тухай хууль / 6.3§ /**

*Монгол улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэрлэх асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг баримтална.*

*Энэ тохиолдолд Монгол Улсын гэр бүлийн тухай хуульд заасан гэрлэхэд тавигдах нөхцөл шаардлагыг хангана.*

Гэрлэлтийн бусад хэлбэр болох сүмд гэрлэх болон заншлын дагуу гэрлэсэн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөхгүй. Өөрөөр хэлбэл, манай хуулийг хэрэглэхээр бол гэр бүлийн хуулийн зохих заалтыг баримталснаар гэрлэлт хүчинтэйд тооцогдоно.

Гэрлэлтийн хэлбэрийг улс орон бүр өөр өөрөөр тодорхойлдог. Үүнд



Гэрлэлтийг бүртгэхэд Монгол Улсын хуульд заагаагүй аливаа хориг хязгаарлалт үл хамаарна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа гадаадын элчин сайдын яам, консулын газар гэрлэлтийг бүртгэнэ.

**Гадаад улсад гэр бүл болох**

Монгол Улсын иргэд гадаад улсад хоорондоо гэр бүл болох болон гадаадын иргэнтэй гэр бүл болох нөхцөл, журам нь дээр дурьдсантай ерөнхийдөө адил төстэй.



### Гэрлэлтийг бүртгэх журам

Тухайн улсад суугаа манай дипломат төлөөлөгчийн болон консулын газар

Тухайн гадаад улсын гэр бүлийн хууль тогтоомж үйлчилнэ.

Гадаад улсын иргэний бүртгэлийн байгууллага

Монгол улсын гэр бүлийн хууль тогтоомж үйлчилнэ.

Гадаад улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын иргэд хоорондоо эсхүл Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн буюу харьяалалгүй хүнтэй гэрлэсэн нь Монгол Улсын гэр бүлийн хуулийн 9 дугаар зүйлд харшлахгүй бол тэдгээрийн гэрлэлт Монгол Улсад хүчинтэйд тооцогдоно. Энэ нөхцөлд тэдгээрийн эрх, үүргийг гэр бүлийн хуулийн 6.5, 6.6 §-д заасны дагуу тодорхойлно.

Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуульд заасны дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээг үндэслэн тэдгээрийн гэрлэлтийг бүртгэж гэрчилгээг сольж олгож болно.

Хоёр талын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд ихэвчлэн гадаадын иргэний харьяалсан улсын хуулийг хэрэглэхээр зохицуулдаг. Тухайлбал: Монгол Улсаас Куба /1988 он/, Югославь /1981/ улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд

*Гэрлэх нөхцөлийг гэрлэхийг хүсэгч тус бүр харьяат нь байгаа хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжоор тодорхойлно. Гэрлэлт бүртгэх хэлбэрийг нутаг дэвсгэр дээр нь гэрлэлтийг бүртгэж байгаа улсын хууль тогтоомжоор тодорхойлно.*

### Гэрлэлтийг цуцлах

Монгол Улсад гадаадын иргэдийн гэрлэлтийг цуцлах

#### Гэр бүлийн хууль /12.3§/

*Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэрлэлтээ цуцлуулах асуудлаа Монгол Улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.*

### Гадаад улсад гэрлэлтийг цуцлах

#### Гэр бүлийн хууль /14.10, 14.11§/


*Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэд болон Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс гэрлэлтээ цуцлуулсан нь Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуульд харшлахгүй бол гэрлэлт цуцлуулсныг хүчинтэйд тооцно.*

*Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэн гэрлэлтээ Монгол Улсад захиргааны ба шүүхийн журмаар цуцлуулж болно.*

Гадаад улсад Монгол Улсын иргэдийн гадаад улсын иргэнтэй гэр бүл болсон гэрлэлтийг ихэвчлэн сүүлийн хугацаанд хамтран амьдарч байсан орны хууль, нөхрийн харьяалсан орны, нэхэмжлэгчийн харьяалсан орны гэх мэт коллизийн хэм хэмжээнүүдээс сонголт хийх замаар цуцална.

Зарим оронд гадаадын иргэн гэр бүлээ цуцлуулах нэхэмжлэл гаргах эрхгүй байдаг. Ийм тохиолдолд гадаадад суугаа Монгол Улсын иргэн Монгол Улсын шүүхэд нэхэмжлэлээ гаргаж болно. /Гэр бүлийн хуулийн 14.11§ /

Гэрлэлтийг цуцлах нөхцөл, журмыг улс орон бүр үндэснийхээ хууль тогтоомжид тодорхойлох бөгөөд зарим нэг онцлог зохицуулалтууд тусгагдсан байдаг. Тухайлбал, Франц улсад



Гэрлэлтийг цуцлах тухай шүүхийн шийдвэр гарсанаар гэрлэлтийн харилцаа дуусгавар болно. Зарим оронд шүүхээр гэрлэгсдийг тусгаарлах шийдвэр гаргадаг. Энэ нөхцөлд гэрлэлтийн харилцаа дуусгавар болохгүй.

**Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ.** Тухайлбал: Монгол Улсаас Югослав улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд

- Гэрлэлт цуцлуулах хэргийг үүсгэх үед нөхөр, эхнэр хоёр харьяат нь байсан улсын хууль тогтоомжийг баримтлана.
- Хэрэв өөр өөр харьяалалтай байвал гэрлэлт цуцлах хэргийг хамгийн сүүлд хамт оршин сууж байгаа буюу сууж байсан улсын хууль тогтоомжоор тодорхойлно.

Гэрлэлт цуцлах хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын ИХШХШ тухай хуулийн 192 дугаар зүйлд зааснаар зохицуулагдана.

Гэрлэгсдийн хоорондын эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцаа нь Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 6.5, 6.6 дугаар зүйлд зааснаар зохицуулагдана.



### Хяналтын асуулт:

1. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээний зохицуулалт ямар ач холбогдолтой вэ? Монгол Улс ямар улс оронтой энэ гэрээг байгуулсан бэ?
2. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээнд гэр бүлийн эрх зүйн ямар асуудлыг тусгаж зохицуулдаг вэ?
3. Гадаад улсад цуцлуулсан гэрлэлтийг Монгол Улсад хүлээн зөвшөөрөх үү?
4. Зөрчилдөөний хэм хэмжээний холбоос гэж юуг хэлэх вэ? Энэ асуудал Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан бэ?
5. Гэр бүлийн эрх зүйн харилцаанд харъяалсан улсын хуулийг хэрэглэх зохицуулалт ямар онцлогтой вэ?
6. Гэр бүлийн эрх зүйн харилцаанд оршин суугаа улсын хуулийг хэрэглэх зохицуулалт ямар онцлогтой вэ?



### Сорил

1. **Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, мөн улсад түр хугацаагаар ирсэн гадаадын харъяат иргэнтэй гэр бүлээ батлуулах хүсэлт гаргавал хэрхэн шийдвэрлэх вэ?**
  - a. Гэрлэлтийг бүртгэхээс татгалзана.
  - b. Гэрлэлтийг олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Гэр бүлийн хуулийн дагуу бүртгэнэ.
  - c. Монгол Улсад суугаа ЭСЯ бүртгэнэ.
  - d. Гадаадын харъяат хүмүүс гэрлэлтээ өөрийн орны бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.
2. **Хоёр эхнэртэй байхыг зөвшөөрдөг улсын иргэнтэй Монгол улсын иргэн тухайн улсад гэрлэлтээ бүртгүүлсэн бол манайд хүчинтэйд тооцогдох уу?**
  - a. Гэрлэлт хүчинтэйд тооцогдоно.
  - b. Хүчинтэй эсэхийг олон улсын гэрээгээр шийдвэрлэнэ.
  - c. Гэрлэлт хүчингүйд тооцогдоно.
  - d. Гэрлэлт хүчинтэй эсэхийг шүүх шийднэ.
3. **Гэр бүлийн хуульд зааснаар Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэдийн гэрлэх асуудлыг**
  - a. Гэрлэгчдийн сонгосон улсын хуулиар
  - b. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын хуулиар
  - c. Гэрлэгчдийн нийтлэг харъяаллын хуулиар
  - d. Гэрлэгчдийн амьдран суугаа газрын хуулиар тус тус тодорхойлно.
4. **Монгол Улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээнд /Унгар, Болгар, Куба/ гэрлэгчдийн гэрлэх үндсэн нөхцлийг дараах байдлаар тодорхойлсон.**
  - a. Гэр бүл бүртгүүлсэн газрын хуулиар
  - b. Гэрлэгчдийн харъяалагдсан улсын тус бүрийн хуулиар
  - c. Нөхрийн харъяалагдсан улсын хуулиар
  - d. Гэрлэгчдийн амьдран суух газрын хуулиар

5. **Монгол Улсын Засгийн газрын урилгаар тус улсад зочилж буй ХБНГУ-ын Засгийн газрын зочинг хүүхдийн эцгээр тогтоох асуудлыг Монгол Улсын Шүүх ИХШХШ тухай Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлэхээр үйл ажиллагаа явуулж болох уу?**
- Ямар ч тохиолдолд Монгол Улсын шүүх, хууль тогтоомжид үл хамаарна.*
  - Хоёр орны хооронд гэрээ, хэлцэл байгаа бол түүний дагуу асуудлыг зохицуулна.*
  - ХБНГУ-ын хууль тогтоомжоор зохицуулна.*
  - Зочид төлөөлөгчдийн тухай хоёр улсын хооронд солилцсон нот бичгийн дагуу зохицуулна.*
6. **Америкийн харьяат иргэн Монгол Улсын харьяат насанд хүрээгүй иргэнийг хууль бусаар үрчлэн авсан тухай маргаан үүсэв. Ямар улсын хуулиар уг асуудлыг аль улсын шүүх шийдвэрлэх вэ?**
- Хариуцагчийн харьяалах хуулийн дагуу тухайн орны шүүх*
  - Монгол Улсын шүүх, Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.*
  - Хоёр орны хооронд байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, конвенцийн дагуу аль нэг улсын шүүх*
  - Хоёр улс нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлцлийн дагуу аль нэг улсын шүүх*



### Бодлого

Монгол Улсад оршин суугаа ХБНГУ-ын иргэн “К” тус улсын иргэн “С” нар харилцан зөвшөөрөлцсөнөөр гэр бүл болж, гэрлэлтээ батлуулахаар шийдэж энэ асуудлаар зөвлөгөө авахаар нэгэн хууль зүйн товчоонд хандан гэр бүл болох хүсэлтээ хаана хандаж гаргах, ямар баримт материал бүрдүүлэх тухай асуудлыг тавьжээ.

- “К”, “С” нарын гэрлэлтийн асуудлыг шийдвэрлэхэд аль улсын хуулийг баримтлах вэ? Герман улсын хуульд заасны дагуу тэд гэрлэлтээ батлуулахаас өмнө 6 сар хамтран амьдарсан байх шаардлагыг хангасан байх ёстой юу?
- Тэдэнд хууль зүйн зөвлөгөө өгөхдөө ямар хуулийн хэд дүгээр зүйл, заалтыг үндэслэх вэ?
- Гэрлэлтийг бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичигт юуг хамруулах вэ? Гадаадын иргэнтэй гэр бүл болоход ямар нэмэлт материал шаардлагатай вэ?
- К”, “С” нарын эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүргийг аль улсын хуулиар тодорхойлох вэ?



### Даалгавар:

Монгол Улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний зохицуулалтыг харьцуулан авч үзэж гэрээний зорилго, зарчим, зохицуулалтын талаар дүгнэлт бичнэ үү.



### Эх сурвалж:

- |   |          |
|---|----------|
| 1. Монгол Улсын Үндсэн хууль /18 дугаар зүйл/   | 1992 он  |
| 2. Гэр бүлийн тухай хууль   | 1995 он  |
| 3. Иргэний бүртгэлийн тухай хууль   | 1999 он  |
| 4. Монгол Улсын харъяатын тухай хууль   | 1995 он  |
| 5. Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль   | 1993 он  |
| 6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль  | 2002 он  |
| 7. Иргэний хууль /60 дугаар зүйл/   | 2002 он  |
| 8. Монгол Улсын Олон улсын гэрээ “Төрийн мэдээлэл 1 боть”   | 2004 он. |
| 9. Монгол Улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний эмхтгэл | 2003 он  |
| 10. Б.Оюунчимэг Олон улсын иргэний эрх зүй  | 2000 он  |
| 11. Т.Мэндсайхан Олон улсын хувийн эрх зүйн үндэс   | 2002 он  |

## ЭЦЭГ, ЭХ, ХҮҮХДИЙН ХАРИЛЦААНЫ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### Сэдвийн агуулга

1. Эцэг, эх, хүүхдийн харилцааны олон улсын эрх зүйн зохицуулалтын онцлог, эх сурвалж
2. Гадаадын элемент бүхий харилцаан дахь эцэг, эх, хүүхдийн хоорондын эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцааны зохицуулалт

### Сэдвийн зорилго

Гадаадын элемент оролцсон гэр бүлийн эрх зүйн харилцаан дахь эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг, түүний эрх зүйн зохицуулалтын мөн чанарыг танин мэдэж түүний онцлогийг зөв сонгож хэрэглэх, холбогдох баримт бичгийг боловсруулах, хууль зүйн үр дагаврыг зөв тодорхойлж бусдад тайлбарлах, зөвлөгөө өгөх, асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй хандах хандлага төлөвшинө.



### Нэр томъёоны тайлбар

**Гадаадын иргэн** - Тухайн орны иргэний харьяалалгүй, гадада улсын харьяат мөн болохыг гэрчилсэн хууль ёсны нотолгоотой хүнийг хэлнэ.

**Иргэний харьяалалгүй хүн** - Тухайн орны иргэний харьяалалгүйгээс гадна өөр ямар нэг орны харьяат мөн болохыг гэрчилсэн хууль ёсны нотолгоогүй хүнийг хэлнэ.

**Иргэний харьяалал** - Тухайн этгээд тодорхой улсын нутаг дэвсгэр дээр буюу түүний гадна байхаас үл хамааран эрх зүйн хувьд уг улсад хууль ёсоор харьяалагдахыг ойлгоно.

**Иргэний харьяалалтай байх эрх** - Тухайн улсад хууль ёсоор харьяалагдан хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг биелүүлж уг улсад хамааран захирагдаж, түүний ивээл хамгаалалтад байх эрхийг ойлгоно.

**Хүүхдийг гадаадад үрчлэх** - Төрөлх улсад үрчлэн авах тохиромжтой гэр бүл олдохгүй тохиолдолд түүний дээд ашиг сонирхолд нийцүүлэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу гадаадын иргэнд тухайн улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх ажиллагааг ойлгоно.

**Хүүхдийн дээд ашиг сонирхол** - Аз жаргал, хайр, ойлголцол бүхий гэр бүлийн орчинд өсөж бойжих тэдний асрамж хамгаалалтанд байх, хамгаалуулах гэх зэрэг хуулиар зөвшөөрөгдөн хамгаалагдсан нэн тэргүүний хүүхдийн эрх ашгийг ойлгоно.

**Хууль сонгож хэрэглэх** - Зөрчилдөөний асуудал үүссэн тохиолдолд гэр бүлийн эрх зүйн тухай тодорхой хугацаанд аль улсын хуулийг хэрэглэх тухай ойлголтыг хэлнэ.

### Эцэг, эх, хүүхдийн харилцааны олон улсын эрх зүйн зохицуулалт

Гэр бүлийн эрх зүйн харилцаан дахь эрхийн тухай асуудал нь хувийн эрх зүйн төдийгүй олон улсын нийтийн эрх зүй гэр дундаа хүний эрхийн салбарт хамаарна. Эцэг, эх, хүүхдийн харилцааны зохицуулалтад энэхүү харилцаа үүсэх үндэслэл, журам, үр дагавар болон тухайн субъектүүдийн эдлэх эрх, үүрэг, түүнийг хэрэгжүүлэх журам, тэдгээрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн хамгаалалтын тухай асуудлууд хамаарна. Энэ асуудлын нэг бол хүүхдийн эцэг, эхийг тогтоох явдал юм.



Хүүхэд Монгол Улсын иргэн бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбогдолтой эцэг, эх тогтоох асуудлыг Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Гэр бүлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Гадаад улсын хуулиар Монгол Улсын иргэнтэй холбогдолтой эцэг, эх тогтоосон нь Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд харшлаагүй бол хүчинтэйд тооцно.

Гадаад улсад оршин сууж байгаа хүүхдийн эцэг, эхийн хэн нэг нь Монгол Улсын иргэн бол мөн хуулийн дагуу эцэг, эх тогтоолгох хүсэлтийг Монгол Улсын дипломат болон консулын байгууллагаар уламжлан тавьж болно.

*Монгол Улсын ИХШХШ тухай хуулийн “Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа ба Олон улсын хууль тогтоомж” гэсэн 7 дугаар хэсэгт олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг тусгасан.*

Эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаанд хүүхдийн эрх зүйн байдал чухал ач холбогдолтой. Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль нь хүүхдийн эрхийг баталгаажуулж түүний эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Олон улсын практикт хүүхдийн эрх зүйн байдаг түүний харьяаллаар тодорхойлно.

Хүүхдийн харьяалалтай холбогдсон харилцааг Монгол Улсын харьяатын тухай хуулиар зохицуулна.

Хүүхэд Монгол Улсын харьяат байх асуудал нь дараах байдлаар зохицуулагддаг. Үүнд:

- Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрсөн тэдний хүүхэд Монгол Улсын харьяат байна. Хэрэв хүүхэд гадаад улсын нутаг дээр төрсөн бол хүүхдийн иргэний харьяалалыг эцэг, эхийн харилцан бичгээр тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- Эцэг эх нь хоёулаа Монгол Улсын харьяат байсан, хүүхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт төрсөн буюу түүний гадна төрснөөс үл хамааран Монгол Улсын иргэн байна.
- Эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат нөгөө нь харьяалалгүй хүн байхад тэдний дундаас төрсөн хүүхэд хаана төрснийг хамаарахгүйгээр Монгол Улсын иргэн байна.
- Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд эцэг эх нь хоёулаа тогтоогдоогүй хүүхэд Монгол Улсын харьяат байна.
- Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа харьяалалгүй эцэг, эх хоёрын дундаас Монгол Улсад төрсөн хүүхэд 16 нас хүрсний дараа өөрөө хүсвэл Монгол Улсын харьяат байж болно.
- Харьяалалгүй хүний үрчлэн авсан Монгол Улсын харьяат 16 нас хүрээгүй хүүхэд Монгол Улсын харьяат хэвээр байна.

Монгол Улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний зохицуулалт чухал ач холбогдолтой юм. Энэхүү гэрээ нь:

1. Эцэг, эх хүүхдийн харилцааг аль улсын хууль тогтоомжоор зохицуулах
2. Эцэг, эх тогтоох буюу түүнтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэх

3. Эцэг, эх, хүүхдийн харилцааны тухай хэргийн харъяалалыг тодорхойлох зэрэг асуудлыг хамарч зохицуулна.

Тухайлбал: Монгол Улсаас Куба улстай байгуулсан гэрээнд зааснаар хүүхдийн эцгийг тогтоох, хүлээн зөвшөөрөх талаарх маргаан болон уг гэр бүлээс хүүхэд төрснийг тогтоохтой холбогдсон асуудлыг дараах журмаар зохицуулна.

- Хүүхдийн харъяалагдах улсын хуулиар
- Хүүхдийн харъяалагдах, эсхүл хүүхэд нутаг дэвсгэрт нь оршин сууж байгаа талын шүүх харьяалан шийдвэрлэнэ.


Эцэг, эх, хүүхдийн хооронд эрх зүйн харилцаа үүсэх хууль зүйн нэгэн факт бол хүүхэд үрчлэх явдал юм.

Үрчлэлтэй холбогдсон харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулна. Үүнд:

- Хүүхдийн эрхийн тухай конвенц
- Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц
- Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль
- Иргэний бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын харъяатын тухай хууль

Тухайлбал: Үрчлэлтийн бүртгэлтэй холбогдсон харилцааг Иргэний бүртгэлийн тухай хуулиар зохицуулна.

Гадаадын иргэн Монгол Улсын харьяат болон тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа харъяалалгүй хүүхдийг үрчлэн авах хүсэлтээ дараах журмаар гаргана.



### **Гэр бүлийн хууль /58.5§/**

*Хүн ам зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын харъяат хүүхэд үрчлэн авах хүсэлтэй гадаадын иргэний бүртгэл хөтөлж, хүүхдийг үрчлэх, үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар бусад улс тэдгээрийн холбогдох байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллана.*

Үрчлэгдсэн хүүхэд харьяатаа сонгох эрхийг Харъяатын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу эдэлнэ.



### **ИХШХШ тухай хуулийн /192.1.4§/**

*Хүүхэд үрчлүүлэх, үрчлэн авахад үрчлэн авагч буюу үрчлэгдэж буй хүүхэд Монгол Улсын харъяат эсхүл Монгол Улсад байнга оршин суудаг этгээд бол Монгол Улсын Шүүх хэргийг шийдвэрлэх ажиллагаа явуулна.*

Үрчлэлтийн асуудал нь хоёр улсын хооронд байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээгээр зохицуулагдана. Тухайлбал:

Солонгос Улстай байгуулсан гэрээгээр хүүхэд үрчлэх нөхцөл болон үрчлэлтийн тухай хэргийн харьяаллыг дараах журмаар зохицуулсан байна. Үүнд:

1. Хүүхэд үрчлэх нөхцөлийг үрчлэн авагч болон үрчлүүлэгчийн харьяалах талын хууль тогтоомжийг баримтална.
2. Иргэний өөр, өөр харьяалалтай эхнэр, нөхөр хүүхэд үрчлэн авч байгаа бол тухайн хоёр улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.
3. Үрчлэгдэж буй хүүхэд нь хэлэлцэн тохирогч нэг талын харьяат, үрчлэн авагч нь хэлэлцэн тохирогч нөгөө талын харьяат бол хүүхэд үрчлэх талаар хүүхэд харьяат нь байгаа хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийн өөрийн нь болон түүний хууль ёсны төлөөлөгч, хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авна.

Дээрх заалтыг хүүхэд үрчилснийг хүчингүй болгоход нэгэн адил хэрэглэнэ. Монгол улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг мөн зохицуулна.

Тухайлбал: Солонгос Улстай байгуулсан гэрээнд:

1. Гэрээнд өөрөөр заагаагүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох тухай асуудлыг асран хамгаалах, харгалзан дэмжүүлэх шаардлагатай хүн харьяат нь байгаа улсын хууль тогтоомжийг баримтална.
2. Асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг хүлээн авахад асран хамгаалагч, харгалзан дэмжигч харьяат нь байгаа талын хууль тогтоомжийг баримтална.



#### **Хяналтын асуулт:**

1. Өөр өөр нутаг дэвсгэрт амьдарч буй эцэг, эх, хүүхдийн эрх, үүргийг ямар эрх зүйн актаар зохицуулдаг вэ?
2. Олон улсын практикт хүүхдийн эрх зүйн байдлыг хэрхэн тодорхойлдог болохыг тайлбарлана уу?
3. Хоёр талын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээгээр эцэг, эх, хүүхдийн хаирилцааг хэрхэн зохицуулдаг болохыг жишээ татаж тайлбарлана уу?
4. Гадаадын элемент бүхий гэр бүлийн харилцаан дахь эцэг, эх тогтоох асуудлыг ямар журмаар шийдвэрлэдэг вэ?
5. Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг ямар байгууллага шийдвэрлэх вэ?
6. Гадаад улсын хуулиар Монгол улсын иргэнтэй холбогдолтой эцэг, эх тогтоосон нь Монгол Улсад хүчинтэйд тооцогдох уу?
7. Хүүхэд Монгол Улсын иргэн бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа харьяалалгүй хүнтэй холбогдсон эцэг, эх тогтоох асуудлыг аль улсын хуулиар шийдвэрлэх вэ?

8. Монгол Улсаас Болгар улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээгээр хүүхдийн тэтгэвэр төлөх үүргийг хэрхэн зохицуулсан бэ?



Сорил

- Олон улсын ямар гэрээ конвенцид “Үрчлэлтийн системийн талаарх зохицуулалт тусгагдсан бэ?**
  - Хүний эрхийн түгээмэл тунхаглал*
  - Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт*
  - Хүүхдийн эрхийн тухай конвенц*
  - Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай конвенц*
- Гадаад улсад оршин сууж байгаа хүүхдийн эцэг, эхийн хэн нэг нь Монгол Улсын иргэн бол аль улсын хуулийн дагуу эцэг, эх тогтоолгох хүсэлтээ гаргах вэ?**
  - Гадаад Улсын хуулийн дагуу Монгол Улсын дипломат болон консулын байгууллагаар уламжлан*
  - Монгол Улсын хуулийн дагуу гадаадын эрх бүхий байгууллагад*
  - Монгол Улсын хуулийн дагуу Монгол улсын дипломат болон консулын байгууллагаар уламжлан*
  - Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын шүүхэд гаргаж болно.*
- Гадаад улсын хуулиар Монгол Улсын иргэтэй холбогдолтой эцэг, эх тогтоосон нь**
  - Гэр бүлийн хуульд харшлаагүй бол хүчинтэйд тооцогдоно*
  - Аль ч улсын хуулиар эцэг, эх нь тогтоогдсон бол хүчинтэйд тооцогдоно*
  - Эцэг, эхийн гаргасан хүсэлтээр шүүхээр шийдвэрлэсэн нөхцөлд түүнийг хүчинтэйд тооцогдоно*
  - Олон улсын гэрээнд зааснаар шийдвэрлэсэн нөхцөлд хүчинтэйд тооцогдоно*
- Монгол улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбогдсон эцэг, эх тогтоосныг бүртгэхдээ**
  - Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуулийг баримтална.*
  - Хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний бүртгэлийн тухай хуулийг баримтална.*
  - Хуульд өөрөөр заагаагүй бол Гэр бүлийн тухай хуулийг баримтална*
  - Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийг баримтална*
- Монгол улсын харьяат болон тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа харьяалалгүй хүүхдийг үрчлэн авах журам болон гадаадын иргэдээс бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг**
  - Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.*
  - Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.*
  - Хууль зүйн байнгын хороо батална.*
  - Хууль зүй болон эруул мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.*



### Бодлого

Герман улсын иргэн “Д” өөрийн орныхоо үрчлэлтийн асуудал эрхэлсэн байгууллагаар уламжлан Монгол Улсын хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах тухай хүсэлтээ гаргасан.

1. Иргэн”Д” ямар баримт бичгийг бүрдүүлэх вэ?
2. Монгол Улсын хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Д”-гийн материалыг хангалттай бүрдсэн гэж үзвэл түүнд ямар баримт бичгийг бүрдүүлж явуулах вэ?
3. “Д” нь хүүхэд үрчлэн авах тухай саналаа ирүүлвэл түүний асуудлыг ямар байгууллага хэрхэн шийдвэрлэхийг хуулийн холбогдох заалтыг иш татаж тайлбарлана уу?



### Даалгавар:

Эцэг, эх, хүүхдийн харилцааг зохицуулж буй олон улсын хэм хэмжээ агуулсан үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудад дүн шинжилгээ хийж тайлбар бичнэ үү?



### Эх сурвалж:

1. Гэр бүлийн тухай хууль	1999 он
2. Иргэний бүртгэлийн тухай хууль	1996 он
3. ИХШХШ тухай хууль	2002 он
4. Монгол Улсын харьяатын тухай хууль	2006 он
5. Хүний эрхийн нэр томъёоны товч тайлбар толь	1996 он
6. Б. Оюунчимэг. Олон Улсын иргэний эрх зүй	2000 он
7. Монгол улс бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний эмхтгэл	2003 он

## ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ НЬ

### Сэдвийн агуулга

Гэр бүлийн харилцааны олон улсын эрх зүйд зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэх тухай

Гэр бүлийн харилцааны олон улсын эрх зүйд хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох нь

### Сэдвийн зорилго

Олон улсын гэр бүлийн эрх зүйн зарчимтай танилцан, холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, баримт бичгийг судалж, тэдгээрийг хэрэглэх, хэрэглэх хуулиа тодорхойлох болон хууль зүйн дүгнэлт, зөвлөгөө өгөх чадварыг эзэмшинэ.



### Нэр томъёоны тайлбар

**Зөрчилдөөний хэм хэмжээ** - Гадаад улсын оролцоо /гадаад элемент/ бүхий иргэний эрх зүйн харилцаанд аль улсын хууль хэрэглэх зохимжтойг заасан буюу түүнийг сонгох арга, журмыг агуулсан хэм хэмжээг ойлгоно.

**Зөрчилдөөний хэм хэмжээний бүтэц** - Зөрчилдөөний хэм хэмжээ ихэнх тохиолдолд 2 элементээс бүрдэнэ. Эрх зүйн харилцааны төрөл, зүйлийг заасан хэсэг буюу холболтын зүйл, эрх зүйн харилцааны төрөлд хэрэглэгдэх эрх зүйг тодорхойлсон хэсэг буюу холболт. Холболт нь тусгайлсан арга, журмын тусламжтайгаар хэрэглэгдэх эрх зүйг тодорхойлно.

УИХ-аас 1999 онд батлагдсан, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуульд олон улсын гэр бүлийн эрх зүй асуудлыг тусгайлсан бүлэг, хэсгээр зохицуулаагүй боловч, гэрлэлт, гэр бүлийн харилцааны зарчим, гэрлэх нөхцөл, гэрлэлт цуцлах журам, гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах, хүүхдийн эцэг, эхийг шүүхийн журмаар тогтоох, гадаадын иргэн Монгол улсын харъяат хүүхэд үрчлэн авах, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулсан холбогдох зүйлүүдэд энэ талаарх тодорхой зохицуулалт байгаа болно. Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн харьяалалгүй хүн гэр бүлийн харилцаанд Монгол Улсын иргэнтэй адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Гэхдээ гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулах хэм хэмжээнүүд улс орон бүрт өөр өөр байх бөгөөд энэ нь асуудлыг шийдвэрлэхэд зөрчилдөөнийг бий болгодог талтай. Ихэнх улс орнуудад гэр бүлийн эрх зүйн гол эх суралж нь төрөлжсөн гэр бүлийн хууль байх ба зарим улс оронд Иргэний хуулийн бие даасан бүлгээр энэ харилцааг зохицуулдаг байна. Олон улсын хэмжээнд гэр бүлийн эрх зүйн гэрлэлт, гэрлэгчдийн хоорондын харилцаа, гэрлэлт цуцлах, эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг, хүүхэд үрчлэлт, асрамж хамгаалалтай холбогдсон харилцаанд зөрчилдөөний хэм хэмжээний холболтыг голлон хэрэглэдэг байна. Тийм учраас Гэр бүлийн тухай хуулийн 4, 6, 12, 14, 58, 67 дугаар зүйлүүдэд заасан зохицуулалтаар уг асуудлыг шийдвэрлэнэ.



### Хяналтын асуулт:

1. Эцэг, эх, хүүхдийн эрх үүргийг тодорхойлох, ялангуяа хүүхдээ тэжээн тэтгэх эрх, үүргийн хувьд ямар улсын хэм хэмжээг хэрэглэх талаар жишээ гарган тайлбарлана уу.
2. Гадаадын элементтэй гэрлэсэн гэрлэлтийг болон гэрлэлт цуцлалтыг бүртгэх, энэ харилцаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх ямар эрх зүйн акт байж болох вэ?
3. Гэрлэгчдийн эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн харилцааг зохицуулах зөрчилдөөний хэм хэмжээний ямар үндсэн холбоос байдаг вэ? Яагаад?
4. Монгол улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн харьяалалгүй хүний гэрлэлтийг цуцлахад Монгол улсын хуулийг хэрэглэх боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?
5. Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэн гэрлэлтээ манай улсад цуцлуулж болх уу?
6. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбоотой Монгол улсын харьяат хүүхдийн эцэг тогтоох асуудлыг Монгол улсын Гэр бүлийн тухай хуулиар зохицуулж болох уу?



### Сорил

1. **ХБНГУ-ын иргэн “С” Говь-Алтай аймгийн Дарви суманд 5 дахь жилдээ амьдарч байгаа. Тэр тус сумын харьяат 6 настай О -г үрчлэн авахаар шийджээ. “С” энэ тухай өргөдлөө ямар байгууллагад гаргах эрхтэй вэ?**
  - a. “С” өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол улсын эрх бүхий байгууллагад гаргах эрхтэй
  - b. Оршин суугаа газрынхаа буюу Дарви сумын Засаг даргын тамгын газарт
  - c. Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх иргэний бүртгэл тэдээллийн албанд
  - d. Монгол улсын хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус, тус гаргана.
2. **Гадаадын иргэн, ганц бие эрэгтэй “К” Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг гаргасан боловч эрх бүхий байгууллага түүнд хүүхэд үрчлэхээс татгалзжээ. Энэ нь зөв үү?**
  - a. Зөв.
  - b. Буруу
3. **Монгол улсын иргэд хоорондоо гадаад улсад гэрлэсэн бол оршин суугаа улсын хуулийн дагуу гэрлэж болох эсэхэд дүгнэлт хийнэ үү?**
  - a. Монгол улсын хуульд зохицуулалт байгаа тул болно
  - b. Монгол улсын хуульд энэ талаар ямар нэгэн зохицуулалт үгүй тул гэрлэж болно
  - c. Монгол Улсын иргэд хоорондоо зөвхөн Монгол улсын хуулийн дагуу гэрлэх учраас болохгүй
  - d. Монгол улсын хуульд зааснаар энэ талаар зохицуулалт үгүй тул гадаад улсын хуулийн дагуу гэрлэхийг хориглоно

4. **Монгол улсын иргэн гадаадын иргэнтэй гадаад улсад гэрлэсэн бол тэдгээрийн эрх, үүргийг аль улсын хуулиар тодорхойлох вэ?**
- a. *Монгол улсын хуулиар*
  - b. *Гэрлэлтийг бүртгүүлсэн улсын хуулиар*
  - c. *Гэрлэгчдийн сонгосон улсын хуулиар*
  - d. *Гэрлэгчдийн амьдарч байгаа улсын хуулиар*
5. **Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенцийн агуулгад аль нь тохирч байна вэ?**
- a. *Улс орон бур улс хооронд гэрлэх явдлаас хэн нь ч санхүүгийн буюу ашиг хонжоо олох ёсгүй.*
  - b. *Янз бүрийн бүлэг хүмүүст үйлчлэх гэрлэлтийн харилцаанд үйлчлэх хоёр буюу түүнээс дээш эрх зүйн тогтолцоотой улсын хувьд тус улсын хуулийн талаарх аливаа заалт нь тухайн улсын хуулиар тодорхойлсон хуулийн тогтолцоонд хамаарах*
  - c. *Гэрлэлтийг бүртгэх ажиллагаанд оролцсон байгууллагуудын захирал, ажилтнууд үзүүлсэн үйлчилгээтэй харьцуулахад бодит бус, өндөр хөлс, төлбөр авах ёсгүй*
  - d. *Эрх бүхий байгууллага гэрлэгсдийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс онцгой шалтгааныг харгалзан үзэж, хуулиар тогтоосон насанд хүрээгүй этгээдийн гэрлэх явдлыг хууль ёсны хэмээн тооцож болно.*



### Бодлого

Загджав Монгол улсын харъяат иргэн. Тэрээр Польш улсад амьдраад 7 жилийг ардаа орхисон ба Польш эмэгтэйтэй гэрлэж, 2 хүүхдийн эцэг болсон. Загджав 2005 оны 8 дугаар сард төрсөн эцгээ асрахаар Улаанбаатар хотод ирснээс хойш эргэж Польш руу явалгүй нэг жил найман сарын хугацаа өнгөрсөн. Загджав Польш улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрлэлтээ бүртгүүлсэн ба гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэлийг Монгол улсын харъяалагдах шүүхэд гаргахаар шийджээ.

Энэ тохиолдолд:

1. Загджавд эрх зүйн туслалцаа үзүүлнэ үү?
2. Монгол улсын шүүх хэргийг харъяалан шийдвэрлэх боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?



### Даалгавар:

1. Гадаадын элемент оролцсон гэр бүлийн эрх зүйн харилцааг ямар хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн зохицуулах талаар оюутан бүр саналаа бичиж бэлтгэнэ үү?
2. Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээг гэр бүлийн маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ шүүх хэрхэн хэрэглэх талаар хэлэлцэнэ үү?



### Эх сурвалж:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Хүүхдийн эрхийн тухай конвенц.  
“Төрийн мэдээлэл”, Тусгай дугаар 1 дүгээр боть УБ., 2004 он
3. Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц. “Төрийн мэдээлэл”, Тусгай дугаар. 1 дүгээр боть УБ., 2004 он
4. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, 1999 он
5. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 1993 он
6. Иргэний бүртгэлийн тухай хууль, 1999 он
7. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 1997 он

